



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Засгийн газрын III байр, Бага тойруу 44,  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200

Утас/Факс: (976-11) 32 14 33,

Цахим шуудан: international@nso.mn,

Цахим хуудас: www.nso.mn

2026.08.30 № 011249  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т


МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН, ЭДИЙН ЗАСГИЙН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА  
РЕНЧИНБЯМБЫН СЭДДОРЖ ТАНАА

Статистикийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 5 дахь заалтын дагуу Үндэсний статистикийн хорооны 2025 оны үйл ажиллагааны тайланг хүргүүлж байгааг хүлээн авна уу.

Хавсралт III хуудастай.

Хүндэтгэсэн,

ДАРГА




Б.БАТДАВАА

1426090436





ҮНДЭСНИЙ  
СТАТИСТИКИЙН  
ХОРОО



# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 2025



[www.1212.mn](http://www.1212.mn)

Улаанбаатар хот, 2026 он





ҮНДЭСНИЙ  
СТАТИСТИКИЙН  
ХОРОО

# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН - 2025


Улаанбаатар хот  
2026 он

## ХОЛБОО БАРИХ


 14200 Улаанбаатар, Монгол Улс,  
Засгийн Газрын III байр, 306 тоот


 7014-1212, 51-261502

 information@nso.mn

 www.1212.mn

 /StatisticMGL

 /StatisticMGL

 /StatisticMGL

---

# ГАРЧИГ

|  |           |
|--|-----------|
| <b>ӨМНӨХ ҮГ</b>  | <b>8</b>  |
| <b>ОНЦЛОХ АЖЛУУД</b>   | <b>13</b> |
| <b>1. АЛБАН ЁСНЫ СТАТИСТИКИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА</b>  | <b>17</b> |
| 1.1 Аргачлал, арга зүй   | 18        |
| 1.2 Албан ёсны статистикийн мэдээ  | 18        |
| 1.3 Статистикийн мэдээллийн эх үүсвэр  | 19        |
| 1.4 Зохион байгуулсан тооллого, судалгаа   | 20        |
| 1.5 Статистик мэдээллийн тархаалт, хэрэглээ  | 36        |
| <b>2. АРГА ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ, ЧАНАРЫН УДИРДЛАГА</b>  | <b>37</b> |
| 2.1 Арга зүйн шинэчлэл   | 38        |
| 2.2 Чанарын удирдлага  | 41        |
| <b>3. ӨГӨГДЛИЙН ЭКОСИСТЕМ</b>  | <b>46</b> |
| 3.1 Ангилал, стандарт  | 48        |
| 3.2 Мета өгөгдөл   | 48        |
| 3.3 Төрийн нэгдсэн мэдээллийн сангийн хөгжүүлэлт   | 51        |
| 3.4 Мэдээллийн аюулгүй байдал, тасралтгүй ажиллагаа  | 53        |
| <b>4. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШИНЭЧЛЭЛ, ЦАХИМЖИЛТ</b>  | <b>54</b> |
| 4.1 Мэдээллийн систем, дэд бүтэц   | 55        |
| 4.2 Статистикийн мэдээний систем   | 55        |
| 4.3 Статистикийн мэдээллийн нэгдсэн сан  | 60        |
| <b>5. ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА</b>  | <b>61</b> |
| 5.1 Олон талт хамтын ажиллагаа   | 62        |
| 5.2 Хоёр талт хамтын ажиллагаа   | 64        |
| <b>6. НӨӨЦИЙН УДИРДЛАГА</b>  | <b>65</b> |
| 6.1 Байгууллагын бүтэц, зохион байгуулалт  | 66        |
| 6.2 Хүний нөөц, сургалт  | 67        |
| 6.3 Санхүү, хөрөнгө оруулалт   | 69        |
| 6.4 Дотоод аудит   | 71        |
| 6.5 Эрсдэлийн удирдлага  | 73        |
| <b>7. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ</b>  | <b>76</b> |
| 7.1 Статистикийн салбарыг 2021-2025 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөөний хэрэгжилт (гол томоохон ажил, үр дүн) | 77        |
| 7.2 Статистикийн салбарыг 2026-2030 онд хөгжүүлэх стратеги   | 77        |
| <b>8. ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН</b>         | <b>79</b> |
| 8.1 Чиг үүргийн хэрэгжилт  | 80        |
| 8.2 ҮСХ-ны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт  | 82        |
| 8.3 Хүний нөөцийн хэрэгцээний үнэлгээ  | 85        |
| 8.4 Санхүү, төсвийн үйл ажиллагааны үнэлгээ  | 92        |
| 8.5 Дүгнэлт  | 93        |
| 8.6 Санал  | 94        |
| <b>ХАВСРАЛТ</b>  | <b>95</b> |

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

|            |   |    |
|------------|---|----|
| Хүснэгт 1  | СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНД ТАРХААЖ БУЙ ҮЗҮҮЛЭЛТ   | 16 |
| Хүснэгт 2  | МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН ТОО, тооллогын оноор  | 18 |
| Хүснэгт 3  | МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН ТОО, аймаг, нийслэлээр  | 19 |
| Хүснэгт 4  | МАЛ ТООЛЛОГЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, 2025 он  | 21 |
| Хүснэгт 5  | ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ НИЙТ ОРЛОГО, мянган төгрөгөөр   | 22 |
| Хүснэгт 6  | ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ НИЙТ ЗАРЛАГА, мянган төгрөгөөр  | 23 |
| Хүснэгт 7  | ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧ НЭГЖИЙН ЖИЛИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, ЗАВСРЫН ХЭРЭГЛЭЭ, НЭМЭГДЭЛ ӨРТӨГ, эдийн засгийн салбараар                               | 27 |
| Хүснэгт 8  | МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР АВСАН МАЛЧИН, ОЛГОСОН НӨХӨН ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ   | 29 |
| Хүснэгт 9  | ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭ   | 30 |
| Хүснэгт 10 | ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН САЛБАРУУДЫН ЖИНГИЙН ӨӨРЧЛӨЛТ   | 37 |
| Хүснэгт 11 | ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ЭДИЙН ЗАСАГТ ЭЗЛЭХ ХУВЬ   | 38 |
| Хүснэгт 12 | СТАТИСТИКИЙН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛД 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА  | 40 |
| Хүснэгт 13 | СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН ЧАНАРТ ӨГСӨН ҮНЭЛГЭЭ, чанарын үзүүлэлтээр, маш сайн, сайн үнэлгээний нийт дүнд эзлэх хувиар                               | 42 |
| Хүснэгт 14 | ХАМГИЙН ИХ БҮЮУ 10-ААС ДЭЭШ ДАВХАРДСАН АНГИЛАЛ, КОДЫН ЖАГСААЛТ  | 48 |
| Хүснэгт 15 | АШИГЛАЖ БАЙГАА СИСТЕМҮҮД  | 54 |
| Хүснэгт 16 | ҮСХ-НЫ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД   | 64 |
| Хүснэгт 17 | ЗӨВЛӨЛИЙН ХУРЛААС ГАРСАН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ   | 65 |
| Хүснэгт 18 | ГАДААД СУРГАЛТ АРГА ХЭМЖЭЭНД ХАМГИЙН ИХ ХАМРАГДСАН УЛС  | 66 |
| Хүснэгт 19 | ТӨСВИЙН УРСГАЛ ЗАРДЛЫН ЗАРЦУУЛАЛТ, эдийн засгийн ангиллаар, сая төгрөг  | 68 |
| Хүснэгт 20 | НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ   | 69 |
| Хүснэгт 21 | ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ  | 81 |
| Хүснэгт 22 | НИЙСЛЭЛ, АЙМАГ, ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ГАЗАР, ХЭЛТСИЙН АЛБАН ХААГЧДЫН ТОО  | 84 |
| Хүснэгт 23 | НИЙСЛЭЛ, АЙМАГ, ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ГАЗАР, ХЭЛТСЭЭС ИРҮҮЛДЭГ МЭДЭЭНИЙ ТОО   | 85 |
| Хүснэгт 24 | ЖИЛД МЭДЭЭ АВЧ БАЙГАА ААНЬ-ЫН ТОО, АЙМГААР  | 86 |
| Хүснэгт 25 | АЛБАН ТУШААЛЫН ЗЭРЭГЛЭЛ   | 87 |
| Хүснэгт 26 | ТУХАЙН ШАТНЫ ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ИЖИЛ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИН БОЛОН НИЙТ ЦАЛИНГИЙН ЗӨРҮҮ  | 88 |
| Хүснэгт 27 | УИХ-ААС УДИРДЛАГА НЬ ТОМИЛОГДДОГ, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮҮРЭГТ НЭГЖТЭЙ ҮСХ, УАГ-ЫН АЛБАН ХААГЧДЫН ИЖИЛ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИН БОЛОН НИЙТ ЦАЛИНГИЙН ЗӨРҮҮ | 89 |

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

|          |  |    |
|----------|--|----|
| Зураг 1  | ШИНЭЭР БАТАЛСАН АРГАЧЛАЛ, МАЯГТ, АСУУЛГА, НӨХӨХ ЗААВАР, ГАРЫН АВЛАГА                         | 16 |
| Зураг 2  | ТХЗ-ЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН МЭДЭЭЛЛИЙН БЭЛЭН БАЙДАЛ, 2025 он                               | 17 |
| Зураг 3  | АЗИ, НОМХОН ДАЛАЙН БҮСИЙН УЛСУУДЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН МЭДЭЭЛЛИЙН БЭЛЭН БАЙДАЛ            | 17 |
| Зураг 4  | УЛАМЖЛАЛТ БУС МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭРИЙН АШИГЛАЛТ   | 17 |
| Зураг 5  | ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2015, 2025 он   | 20 |
| Зураг 6  | 15 БА ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, улсын дүнгээр, улирлаар        | 24 |
| Зураг 7  | АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТҮВШИН, улирлаар                          | 24 |
| Зураг 8  | ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ДУТУУ АШИГЛАЛТЫН ТҮВШИН, улирлаар  | 25 |
| Зураг 9  | ДОТООДЫН ЖУУЛЧДЫН ТОО, аймаг, нийслэлээр, давхардсан тоогоор, мянган хүн                     | 26 |
| Зураг 10 | ДОТООДЫН ЖУУЛЧДЫН ТОО, сараар, мянган хүн  | 26 |
| Зураг 11 | ДОТООДЫН ЖУУЛЧДЫН ТОО, аяллын зорилгоор, мянган хүн  | 27 |
| Зураг 12 | ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧ НЭГЖИЙН НЭМЭГДЭЛ ӨРТГИЙН ДНБ-Д ЭЗЛЭХ ХУВЬ, эдийн засгийн салбараар | 28 |
| Зураг 13 | ФЭЙ-ХЭРРИОТ БА ШУУД ТООЦООЛЛЫН ХАРЬЦУУЛАЛТ, ТҮҮВРИЙН ХЭМЖЭЭ                                  | 31 |
| Зураг 14 | ФЭЙ-ХЕРРИОТ ТООЦООЛОЛ: ҮНДЭСНИЙ ЯДУУРЛЫН ТҮВШИН  | 31 |
| Зураг 15 | ФЭЙ-ХЭРРИОТ ЗАГВАРААРХ УЛААНБААТАР ХОТЫН ЯДУУРЛЫН ТҮВШИН, дүүргээр                           | 32 |
| Зураг 16 | НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ЗАРДАЛ, хөтөлбөрөөр, 2024 он, тэрбум төгрөгөөр                            | 33 |
| Зураг 17 | ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХАД НӨЛӨӨЛЖ БУЙ АХИУ НӨЛӨӨ  | 33 |
| Зураг 18 | МЭДЭЭЛЭЛ ТАРХААЛТЫН СУВГУУД  | 34 |
| Зураг 19 | ДНБ-ИЙ ЖИЛИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХАРЬЦУУЛАЛТ  | 36 |
| Зураг 20 | МЭДЭЭЛЛИЙН НЭЭЛТТЭЙ ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ, 2024  | 43 |
| Зураг 21 | ӨГӨГДЛИЙН ЭКОСИСТЕМИЙН ЗУРАГЛАЛ  | 45 |
| Зураг 22 | БАРАА БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН СИСТЕМ  | 46 |
| Зураг 23 | ТӨРИЙН МЕТА ӨГӨГДЛИЙН НЭГДСЭН САН  | 47 |
| Зураг 24 | ӨГӨГДЛИЙН САНГИЙН УДИРДЛАГЫН СИСТЕМИЙН ТӨРӨЛ   | 47 |
| Зураг 25 | ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН  | 49 |
| Зураг 26 | АНХАН ШАТНЫ ӨГӨГДЛИЙН ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ, холболтын төрөл, эх үүсвэрээр                         | 50 |
| Зураг 27 | ТӨРӨЛЖСӨН БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН СИСТЕМ  | 50 |
| Зураг 28 | ҮСХ-НЫ МАБ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗУРАГЛАЛ   | 51 |
| Зураг 29 | ДАТАЛАБЫН АЖИЛЛАХ ЗАРЧИМ   | 53 |
| Зураг 30 | СТАТИСТИКИЙН МЭДЭЭНИЙ СИСТЕМИЙН ДАШБОАРД   | 54 |
| Зураг 31 | СУДАЛГААНЫ ЦАХИМ ХЯНАЛТЫН СИСТЕМ   | 55 |
| Зураг 32 | ӨНЭЭС БОЛОН АХС-НЫ ДАШБОАРД  | 55 |
| Зураг 33 | ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ ЗАВСРЫН ТООЛЛОГЫН ПРОГРАММ   | 56 |
| Зураг 34 | 30 СМ-ЫН НАРИЙВЧЛАЛТАЙ ЗУРАГЛАЛД ГЭР ТАНИУЛСАН БАЙДАЛ, сумын төв, хөдөөгийн байршлаар        | 57 |

|          |  |    |
|----------|--|----|
| Зураг 35 | МАЛ ТООЛЛОГЫН AI АППЛИКЕЙШН  | 57 |
| Зураг 36 | СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГИЙН ШИНЭЧЛЭЛ                                 | 58 |
| Зураг 37 | ХАМТЫН АЖИЛЛАГААТАЙ БАЙГУУЛЛАГУУД  | 60 |
| Зураг 38 | БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ  | 64 |
| Зураг 39 | СУРГАЛТЫН ЦАХИМ СИСТЕМИЙН БҮТЭЦ  | 67 |
| Зураг 40 | СУРГАЛТЫН ЦАХИМ СИСТЕМД БАЙРШУУЛСАН ХИЧЭЭЛҮҮД                                    | 67 |
| Зураг 41 | 2025 ОНД ХИЙСЭН ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТ                                     | 69 |
| Зураг 42 | ШИЛЭН ДАНСАНД ОРЛОГО, ЗАРЛАГЫН ГҮЙЛГЭЭГ МЭДЭЭЛСЭН БАЙДАЛ, хувиар                 | 70 |
| Зураг 43 | ХУДАЛДАН АВАЛТЫГ МЭДЭЭЛСЭН БАЙДАЛ, хувиар  | 70 |
| Зураг 44 | ШИЛЭН ДАНСАНД МЭДЭЭЛЭХ ХУУЛИЙН ХУГАЦААГ ХОЦРООСОН БАЙДАЛ, хувиар                 | 70 |
| Зураг 45 | ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, 2025                                    | 72 |
| Зураг 46 | ҮСХ-НЫ ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ТӨЛӨВШИЛ   | 73 |
| Зураг 47 | СТАТИСТИКИЙН САЛБАРЫН 2026-2030 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО, ХҮРЭХ ҮР ДҮН | 76 |
| Зураг 48 | НИЙСЛЭЛ, АЙМАГ, ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ГАЗАР, ХЭЛТСИЙН АЛБАН ХААГЧДЫН ТОО         | 84 |
| Зураг 49 | АЛБАН ХААГЧДЫН ТОО, ажилласан жилээр, дүнд эзлэх хувиар                          | 84 |
| Зураг 50 | АЛБАН ХААГЧДЫН ТОО, мэргэжлээр, дүнд эзлэх хувиар                                | 85 |

## ХАВСРАЛТ

|             |  |     |
|-------------|--|-----|
| Хавсралт 1  | ҮСХ-ООС ШИНЭЭР БОЛОН ШИНЭЧЛЭН БАТАЛЖ МӨРДҮҮЛСЭН АРГАЧЛАЛ, АНГИЛАЛ, МАЯГТ, АСУУЛГА, НӨХӨХ ЗААВАР, ТҮҮВРИЙН ДИЗАЙН | 94  |
| Хавсралт 2  | СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГААР ТАРХААЖ БУЙ ҮЗҮҮЛЭЛТ   | 95  |
| Хавсралт 3  | ҮСХ-ООС 2025 ОНД ШИНЭЭР ТООЦОЖ ТАРХААЖ БАЙГАА ҮЗҮҮЛЭЛТ   | 97  |
| Хавсралт 4  | ҮСХ-ООС 2025 ОНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААНЫ АЖИЛ, САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА   | 100 |
| Хавсралт 5  | ДЭЛХИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДЭЭС МОНГОЛ УЛСЫН ХЭМЖЭЭНД ГАРЧ БАЙГАА ҮЗҮҮЛЭЛТ           | 101 |
| Хавсралт 6  | ҮСХ-ООС 2025 ОНД ШИНЭЭР БОЛОН ШИНЭЧЛЭН ЗАСВАР, ӨӨРЧЛӨЛТ ХИЙСЭН ПРОГРАММ  | 102 |
| Хавсралт 7  | ХҮНИЙ НӨӨЦИЙН 2025 ОНЫ ХӨДӨЛГӨӨН   | 104 |
| Хавсралт 8  | ҮСХ-ООС 2025 ОНД ЗОХИОН БАЙГУУЛСАН СУРГАЛТ, зорилтот бүлгээр   | 105 |
| Хавсралт 9  | ОЛОН УЛСЫН САНХҮҮЖИЛТЭЭР ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР, мянган төгрөгөөр  | 106 |
| Хавсралт 10 | ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР, ТЕХНИКИЙН ТУСЛАЛЦАА   | 107 |

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

|                |  |
|----------------|--|
| <b>ААН</b>     | Аж ахуйн нэгж  |
| <b>ААНБ</b>    | Аж ахуйн нэгж, байгууллага   |
| <b>АНДЗЭНК</b> | Ази Номхон Далайн Эдийн засаг, Нийгмийн Комисс   |
| <b>АХБ</b>     | Азийн Хөгжлийн Банк  |
| <b>АХС</b>     | Ажиллах хүчний судалгаа  |
| <b>БОЭЗДС</b>  | Байгаль орчин, эдийн засгийн дансны систем   |
| <b>БНСУ</b>    | Бүгд Найрамдах Солонгос Улс  |
| <b>БНХАУ</b>   | Бүгд Найрамдах Хятад Ард Улс   |
| <b>БРС</b>     | Бизнес регистрийн сан  |
| <b>ДАЭУГ</b>   | Дотоод аудит, эрсдэлийн удирдлагын газар   |
| <b>ДНБ</b>     | Дотоодын нийт бүтээгдэхүүн   |
| <b>МАО</b>     | Мал аж ахуй  |
| <b>МАБ</b>     | Мэдээллийн аюулгүй байдал  |
| <b>МАБМТ</b>   | Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо  |
| <b>НисГ</b>    | Нийгмийн статистикийн газар  |
| <b>НҮБ</b>     | Нэгдсэн Үндэстний Байгууллага  |
| <b>НҮБСХ</b>   | Нэгдсэн Үндэстний Байгууллагын Статистикийн хэлтэс   |
| <b>НҮБХХ</b>   | Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр   |
| <b>НҮТС</b>    | Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа   |
| <b>НӨАТ</b>    | Нэмэгдсэн өртгийн албан татвар   |
| <b>НӨАТУС</b>  | Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын систем  |
| <b>НАХ</b>     | Нөөц ашиглалтын хүснэгт  |
| <b>ОХЯИ</b>    | Олон хэмжээст ядуурлын индекс  |
| <b>ОУХБ</b>    | Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага   |
| <b>ОУБТС</b>   | Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаа   |
| <b>ӨССХ</b>    | Өрхөд суурилсан судалгааны хэлтэс  |
| <b>ТӨШГ</b>    | Тооллого, өгөгдлийн шинжилгээний газар   |
| <b>ӨНЭЗС</b>   | Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа  |
| <b>СМНС</b>    | Статистикийн мэдээллийн нэгдсэн сан ( <a href="https://1212.mn/">https://1212.mn/</a> )                          |
| <b>СХТ</b>     | Салбар хоорондын тэнцэл  |
| <b>СҮАЕЗ</b>   | Статистикийн үйл ажиллагааны ерөнхий загвар  |
| <b>ТХЗ</b>     | Тогтвортой Хөгжлийн Зорилго  |
| <b>УИХ</b>     | Улсын Их Хурал   |
| <b>УТҮГ</b>    | Улсын төсөвт үйлдвэрийн газар  |
| <b>ҮАГ</b>     | Үндэсний Аудитын Газар   |
| <b>ҮСХ</b>     | Үндэсний Статистикийн Хороо  |
| <b>ХААИС</b>   | Хөдөө Аж Ахуйн Их Сургууль   |
| <b>ХАӨМС</b>   | Хүн ам, өрхийн мэдээллийн сан  |
| <b>ХХЭН</b>    | Хувиараа хөдөлмөр эрхлэгч нэгж   |
| <b>ХХЭС</b>    | Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн судалгаа   |
| <b>ХАОСЗТ</b>  | Хүн ам, орон сууцны завсрын тооллого   |
| <b>ХХААХҮЯ</b> | Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яам   |
| <b>ЦХИХХЯ</b>  | Цахим Хөгжил, Инновац, Харилцаа Холбооны Яам   |
| <b>ЭЗНК</b>    | Эдийн засаг нийгмийн комисс  |
| <b>САPI</b>    | Computer Assisted Personal Interview/Цахим төхөөрөмж ашиглан нүүр тулан ярилцлага авах                           |
| <b>САTI</b>    | Computer Assisted Telephone Interview/Цахим төхөөрөмж ашиглан утсаар ярилцлага авах                              |
| <b>PARIS21</b> | The Partnership in Statistics for Development in the 21st Century/XXI зууны хөгжлийн төлөөх статистикийн түншлэл |

## ӨМНӨХ ҮГ



Үндэсний Статистикийн Хорооны дарга  
**Б.БАТДАВАА**

Үндэсний Статистикийн Хорооны 2025 оны үйл ажиллагааны тайланг статистикийн мэдээлэл хэрэглэгч та бүхэнд өргөн барьж байна. Бид өнгөрсөн онд 6 бүлгийн 859 статистик үзүүлэлтийг 7-15 хоног, сар, улирал, жилээр бэлтгэн тархааж, 2 тооллого, 9 түүвэр судалгааг зохион байгуулж, үр дүнг нэгтгэн боловсрууллаа. Үүний зэрэгцээ албан ёсны статистикийг хөгжүүлэх 3 дахь удаагийн хөтөлбөр буюу “Статистикийн салбарын 2021-2025 оны стратеги төлөвлөгөө”-г хэрэгжүүлж ажиллалаа.

Дээрх стратеги төлөвлөгөөний дагуу Үндэсний Статистикийн Хороо нь 2025 онд статистикийн гол тооллого судалгааг төрийн суурь болон төрөлжсөн мэдээллийн сангуудыг ашиглан жил бүр зохион байгуулах систем хөгжүүлэх, статистикт гар утасны өгөгдөл, их өгөгдөл, машин сургалт, хиймэл оюуныг ашиглах, мэдээллийн аюулгүй байдлыг сайжруулах, судалгаа шинжилгээний зорилгоор дата лаб байгуулах,

мэдээллийн чанарыг сайжруулах, дотоодын нийт бүтээгдэхүүний тооцоонд хэлхээ индексийн арга нэвтрүүлэх зэрэг томоохон ажлуудыг хийж хэрэгжүүллээ.

**Төрийн суурь болон төрөлжсөн мэдээллийн сангуудыг ашиглан тооллого судалгаа явуулах системийг бий болголоо.** Үндэсний Статистикийн Хороо 2021 оноос эхлэн “Төрийн их өгөгдөл: Төрийн нэгдсэн мэдээллийн санг хөгжүүлэх” төслийг хэрэгжүүлж байгаа. Төслийн хүрээнд Монгол Улсад өгөгдлийн засаглалын суурь тогтолцоог бэхжүүлэх ажлыг төрийн бусад байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж, “Төрийн мета өгөгдлийн нэгдсэн сан”, “Төрийн нэгдсэн өгөгдлийн сан” цахим талбаруудыг шинээр үүсгэж, “Үндэсний өгөгдлийн замын зураглал”-ыг боловсруулсан. Энэ ажлын хүрээнд 2025 онд төрийн 14 байгууллагын суурь болон төрөлжсөн 30 мэдээллийн санг ашиглан “Хүн ам, орон сууцны 2025 оны завсрын тооллого”-ыг бүртгэлд

суурилсан аргаар зохион байгуулж, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн нэгдсэн мэдээллийн сан буюу "Хүн ам, орон сууцны тооллого", "Аж ахуйн нэгжийн тооллого"-ыг жил бүр зохион байгуулах систем хөгжүүлээ.

**Статистикийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлд гар утасны өгөгдөл, их өгөгдөл, хиймэл оюун нэвтрүүлэх ажлыг эрчимжүүллээ.** Бид 2024 онд хэрэглэгчдэд статистикийн мэдээллээр шуурхай үйлчлэх хиймэл оюунд суурилсан чатботыг (MonStatGPT) нэвтрүүлсэн. Өнгөрсөн онд уг чатботыг сайжруулахын зэрэгцээ мал тооллогыг хялбаршуулах хиймэл оюунд суурилсан системийг нэвтрүүлээ. Түүнчлэн Үндэсний Статистикийн Хороо нь Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын дэргэдэх "PARIS21" байгууллагаас санаачилсан ажлын хэсэгт нэгдэж, Дэлхийн банк болон "Google Foundation"-тай хамтарч Монгол Улсын статистикийн системийн хиймэл оюуны бэлэн байдлыг бэхжүүлэх төслийг эхлүүлсэн. Статистикийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлд мэдээллийн шинэ эх үүсвэр ашиглах зорилгоор цахим хуудасны өгөгдөл ашиглалтыг нэмэгдүүлж, гар утасны өгөгдлийг дотоодын аялал жуулчлал, шилжилт хөдөлгөөний статистикт ашиглах төслийг Харилцаа Холбооны Зохицуулах Хороо болон Мобиком Корпорац ХХК-тай хамтран хэрэгжүүлж байна.

**Мэдээллийн аюулгүй байдал, хүртээмжийг нэмэгдүүлэхэд ахиц гарлаа.** Үндэсний Статистикийн Хороо "Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо (ISO 27001:2022) олон улсын стандарт"-ыг 2024 онд үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн нь мэдээллийн нууцлал, аюулгүй байдал, эрсдэлийн удирдлагад гарсан томоохон ахиц байсан. 2025 онд энэхүү стандартын магадлах аудитыг хийлгэлээ. Түүнчлэн тооллого, судалгаа, захиргааны мэдээллийн задгай өгөгдөлд ажиллаж, дүн шинжилгээ хийх "Дата лаб"-ыг шинээр байгууллаа. Энэхүү дата лаб нь мэдээллийн аюулгүй байдлын стандартыг хангасан тусгай орчинд судалгаа шинжилгээ хийх боломжийг статистикийн байгууллагын ажилтнууд, судлаачдад олгосноороо онцлог юм.

Мөн Статистикийн мэдээллийн нэгдсэн санг ([www.1212.mn](http://www.1212.mn)) өнгөрсөн онд бүрэн шинэчилж, нээлттэй эх үүсвэрт шилжүүлснээр мэдээлэл

авах хурд нэмэгдэж, системийн тогтвортой байдал сайжирч, хөгжүүлэлт хөндлөнгийн байгууллагаас хараат бус боллоо.

**Мэдээллийн чанарыг сайжруулж, дотоодын нийт бүтээгдэхүүнийг хэлхээ индексийн аргаар тооцдог болов.** Статистикийн мэдээллийн чанарыг сайжруулах, арга зүйг шинэчлэх ажлын хүрээнд эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийг тухай бүр тусгах "Дотоодын нийт бүтээгдэхүүнийг хэлхээ индекс ашиглан зэрэгцүүлэх үнээр тооцох аргачлал"-ыг баталж, бүх салбарын үйлдвэрлэгчийн үнийн суурь оны тооцоог шинэчилж, дотоодын нийт бүтээгдэхүүний 2019-2024 оны улирал, жилийн гүйцэтгэлийг хэлхээ индексийн аргаар тооцлоо.

Мөн Ажиллах хүчний судалгаа болон Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаанд өндөр давтамжтай чанарын хяналт хийх программ нэвтрүүлснээр судалгааны өгөгдлийг богино хугацаанд хянаж, мэдээллийн чанарыг сайжруулах боломж бүрдлээ. "Дотоодын жуулчдын түүвэр судалгаа"-г улсын хэмжээнд анх удаа олон улсын нийтлэг арга зүйд тулгуурлан зохион байгууллаа. Дотоодын жуулчдын аяллын төлөв байдал, хэв маягийг тодорхойлж, аялал жуулчлалын салбарын эдийн засагт оруулж буй хувь нэмрийг тооцохоос гадна бодлого төлөвлөлт, хэрэгжилтийг дүгнэхэд шаардлагатай мэдээлэл бий болголоо.

**Олон улсын хамтын ажиллагаа, статистикийн чадавх бэхжүүлэхэд ажилд ахиц гарлаа.** Тухайлбал Монгол Улс НҮБ-ын Ази, Номхон далайн орнуудын Статистикийн институт болон Олон улсын өртгийн зэрэгцүүлэлтийн хөтөлбөрийн удирдах зөвлөлийн гишүүнээр шинээр сонгогдлоо. Мөн "PARIS21" байгууллагын Гүйцэтгэх хороо болон Ази, Америк, Номхон далайн орнуудын үндэсний статистик, тооллогын байгууллагын дарга нарын нийгэмлэгийн Удирдах зөвлөлийн гишүүнээр Үндэсний Статистикийн Хорооны дарга ажиллаж байна. Бидний гадаад хамтын ажиллагааны үр дүнд 2024-2027 онд статистикийн системийг бэхжүүлэх БНСУ-ын хөгжлийн албан ёсны тусламж, Азийн Хөгжлийн Банк, Австралийн Холбооны Улс, БНХАУ-ын чадавх бэхжүүлэх төслүүд тус хороонд хэрэгжиж байна.

ӨМНӨХ ҮГ

Дээрх ажлын үр дүнд "Open Data Watch" байгууллагын дэлхийн 193 орны статистикийн байгууллагын мэдээллийн нээлттэй, хүртээмжтэй байдлын үнэлгээгээр Монгол Улсын статистикийн систем дэлхийд 11 дүгээрт, Зүүн Азийн бүс нутагт 2 дугаарт эрэмбэлэгдэж, Дэлхийн Банкны статистикийн гүйцэтгэлийн үнэлгээгээр дэлхийд 47 дугаар байрт орж, 5 байраар урагшиллаа.

Бид ирэх жилүүдэд статистикийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлд хиймэл оюун, их өгөгдлийн ашиглалтыг нэмэгдүүлэх, мэдээллийн чанар, аргачлалыг шинэчлэхэд анхаарахаас гадна үндэсний хэмжээнд өгөгдлийн засаглал, экосистемийг бэхжүүлэх ажлыг эрчимжүүлэх болно.

Бидний үйл ажиллагааг дэмжиж, хамтран ажилладаг төрийн болон олон улсын байгууллагууд, статистикийн мэдээлэл боловсруулахад мэдээллийн найдвартай эх үүсвэр болдог иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд, статистикийн мэдээллийн эрхэм хэрэглэгчид, эрдэмтэн судлаач та бүхэндээ Үндэсний Статистикийн Хорооны нийт албан хаагчдын нэрийн өмнөөс талархал илэрхийлье.

## ҮСХ-НЫ ДАРГЫН ЗӨВЛӨЛ



Зүүн гар талаас:

Ц.Эрдэнэмөнх, ҮСХ-ны Даргын зөвлөлийн гишүүн, Мэдээллийн технологийн газрын дарга

Б.Лхагва, ҮСХ-ны Даргын зөвлөлийн гишүүн, Тамгын газрын дарга

М.Оюунцэцэг, ҮСХ-ны Даргын зөвлөлийн гишүүн, Нийгмийн статистикийн газрын дарга

Б.Батдаваа, ҮСХ-ны дарга, Зөвлөлийн дарга


М.Оюунжаргал, ҮСХ-ны Даргын зөвлөлийн гишүүн, Эдийн засгийн статистикийн газрын дарга


Д.Лхамсүрэн, ҮСХ-ны Даргын зөвлөлийн гишүүн, Дэд дарга

Н.Мөнхбаяр, ҮСХ-ны Даргын зөвлөлийн гишүүн, Дотоод аудит, эрсдэлийн удирдлагын газрын дарга

Ш.Ариунболд, ҮСХ-ны Даргын зөвлөлийн гишүүн, Тооллого, өгөгдлийн шинжилгээний газрын дарга

Ц.Тэгшжаргал, ҮСХ-ны Даргын зөвлөлийн гишүүн, Нэгдсэн статистикийн газрын дарга /зурганд байхгүй./





# 2025

## ОНЫ ОНЦЛОХ АЖЛУУД

## 1. ТӨРД БАЙГАА МЭДЭЭЛЛИЙН САНГУУДЫГ АШИГЛАН ТООЛЛОГО ЯВУУЛАХ СИСТЕМ ХӨГЖҮҮЛЛЭЭ


Үндэсний Статистикийн Хорооноос 2021 оноос эхлэн "Төрийн их өгөгдөл: Төрийн нэгдсэн мэдээллийн санг хөгжүүлэх" төсөл хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд төрийн 9 байгууллагын 12 мэдээллийн санг нэгтгэсэн "Төрийн нэгдсэн өгөгдлийн сан" (Data.nso.mn) болон төрийн байгууллагын өгөгдлийн сангийн үзүүлэлт, ангилал, маягтын мэдээлэл агуулсан "Төрийн мета өгөгдлийн нэгдсэн сан" (Metadata.nso.mn) цахим талбаруудыг ашиглалтад оруулсан. Улмаар төрийн 15 байгууллагын суурь болон төрөлжсөн мэдээллийн санг ашиглан "Хүн ам, орон сууцны 2025 оны завсрын тооллого"-ыг анх удаа бүртгэлд суурилсан хэлбэрээр зохион байгууллаа. Ингэснээр цаашид төрийн байгууллагуудын мэдээллийн санг ашиглан жил бүр хүн амын болон эдийн засгийн тооллого явуулах нөхцөл бүрдлээ.

## 2. СТАТИСТИКТ ХИЙМЭЛ ОЮУН АШИГЛАЖ ЭХЛЭВ

Статистикийн үйл ажиллагаанд хиймэл оюун, машин сургалт ашиглаж эхэллээ. Тухайлбал, хэрэглэгчдэд статистикийн мэдээллийг хялбар хүргэх зорилгоор хиймэл оюунд суурилсан статистикийн чат бот (MonStatGPT) нэвтрүүлсэн нь статистик мэдээллийг шуурхай, ойлгомжтой, хялбар хүргэх хөгжлийн шинэ үеийн эхлэл болох юм. Түүнчлэн 2025 оны мал тооллогод машин сургалт, хиймэл оюун ашиглах загварыг туршилтаар нэвтрүүллээ. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын дэргэдэх PARIS21 байгууллагатай Үндэсний Статистикийн Хороо болон Google Foundation хамтран Монгол Улсад статистикийн системийн хиймэл оюуны бэлэн байдлыг бэхжүүлэх төсөл эхлүүлээ.


## 3. МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫГ НЭВТРҮҮЛЖ, МАГАДЛАХ АУДИТ ХИЙЛГЭВ

Үндэсний Статистикийн Хороо "Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо (ISO 27001:2022) олон улсын стандарт"-ыг 2024 онд үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн нь мэдээллийн нууцлал, аюулгүй байдал, эрсдэлийн удирдлагын систем дэх томоохон ахиц байсан юм. 2025 онд энэхүү стандартын магадлах аудитыг хийлгэлээ.



**4. СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГИЙН СИСТЕМИЙГ БҮРЭН ШИНЭЧИЛЛЭЭ**

Хэрэглэгчдэд мэдээлэл хүргэдэг Статистикийн мэдээллийн нэгдсэн сан буюу [www.1212.mn](http://www.1212.mn) цахим хуудсыг 2013 онд олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр ашиглалтад оруулж байсан. Энэ онд тус системийг бүрэн шинэчилж, нээлттэй эх үүсвэрт шилжүүлснээр мэдээлэл авах хурдыг нэмэгдүүлж, системийн тогтвортой байдлыг сайжруулан, хөгжүүлэлтийг хөндлөнгийн байгууллагаас хараат бус болголоо.



**5. ГАР УТАСНЫ ӨГӨГДЛИЙГ СТАТИСТИКТ АШИГЛАХ ТӨСӨЛ ЭХЭЛЛЭЭ**

Үндэсний Статистикийн Хороо, Харилцаа Холбооны Зохицуулах Хороо болон Мобиком Корпорац хамтран гар утасны өгөгдлийг албан ёсны статистикт ашиглах боломжийг турших хамтын ажиллагааг эхлүүллээ. Ингэснээр Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр хүн амын шилжилт хөдөлгөөн, аялал жуулчлал, харилцаа холбооны салбарын статистикийг гар утасны өгөгдөл ашиглан боловсруулах зорилт тавин ажиллаж байна.



**6. СТАТИСТИКИЙН СИСТЕМД “ДАТА ЛАБ” НЭВТРҮҮЛЛЭЭ**

Тооллого, судалгаа, захиргааны мэдээллийн задгай өгөгдөлд ажиллаж, дүн шинжилгээ, судалгаа хийх “Дата лаб”-ыг шинээр нэвтрүүлээ. Энэхүү дата лаб нь мэдээллийн аюулгүй байдлын стандартыг хангасан тусгай орчинд судалгаа шинжилгээ хийх боломжийг статистикийн байгууллагын ажилтнууд, судлаачдад олгож байгаагаараа онцлог юм.



**7. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ХЭЛХЭЭ ИНДЕКСИЙН АРГААР ТООЦДОГ БОЛОВ**

Эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийг тухай бүр тусгах “Дотоодын нийт бүтээгдэхүүнийг хэлхээ индекс ашиглан зэрэгцүүлэх үнээр тооцох аргачлал”-ыг баталж, Дотоодын нийт бүтээгдэхүүний 2019-2024 оны улирал, жилийн гүйцэтгэлийг хэлхээ индексийн аргаар туршилтаар тооцлоо.



Түүнчлэн “Нөөц, ашиглалтын хүснэгт, Салбар хоорондын тэнцлийг 2024 оны гүйцэтгэлээр байгуулах судалгаа”, Хувиараа хөдөлмөр эрхлэлтийн судалгаа”-г зохион байгуулж, нөөц, ашиглалтын хүснэгт, салбар хоорондын тэнцэл байгуулах үндсэн мэдээллийг бүрдүүлж, эдийн засгийн салбаруудын харилцан уялдааг харуулах мэдээллийг шинэчиллээ.

### **8. НҮБ-ЫН АЗИ, НОМХОН ДАЛАЙН ОРНУУДЫН СТАТИСТИКИЙН ИНСТИТУТИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНЭЭР СОНГОГДЛОО.**

Үндэсний Статистикийн Хорооны дарга Б.Батдаваа НҮБ-ын Ази, Номхон Далайн ЭЗНК-ын Статистикийн хорооны хурлын даргаар 2022-2024 онд томилогдон ажилласан. 2025 онд НҮБ-ын Ази, Номхон далайн орнуудын Статистикийн институтийн Удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдлоо. Тус байгууллагын Удирдах зөвлөлд Япон, БНСУ, БНХАУ, Энэтхэг, Пакистан, Малайз, Тайланд улсын төлөөлөл багтдаг. Түүнчлэн PARIS21 байгууллага болон Ази, Америк, Номхон далайн орнуудын үндэсний статистик, тооллогын байгууллагын дарга нарын нийгэмлэгийн Удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллаж байна.

### **9. СТАТИСТИКИЙН БАЙГУУЛЛАГЫН ОЛОН УЛСЫН ҮНЭЛГЭЭ АХИЛАА**

Олон Улсын "Open Data Watch" байгууллагаас хоёр жил тутамд дэлхийн 193 орны статистикийн байгууллагын мэдээллийн нээлттэй, хүртээмжтэй байдлыг үнэлдэг. Үндэсний Статистикийн Хороо нь мэдээллийн хамрах хүрээ, нээлттэй байдлын үнэлгээгээр дэлхийд 11 дүгээрт, Зүүн Азийн бүс нутагт 2 дугаарт эрэмбэлэгдэж байна. Мөн Дэлхийн Банкны статистикийн гүйцэтгэлийн үнэлгээгээр дэлхийд 47 дугаар байрт орж, 5 байраар урагшиллаа.





1

# АЛБАН ЁСНЫ СТАТИСТИКИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 1.1 АРГАЧЛАЛ, АРГА ЗҮЙ

Статистикийн үзүүлэлт, арга зүйг олон улсын жишигт нийцүүлэх ҮСХ-ны Арга зүйн байнгын зөвлөл (АЗБЗ) нь үйл ажиллагаандаа албан ёсны статистикийн шинэчлэлийн загвар болох Статистикийн үйл ажиллагааны ерөнхий загвар (СҮАЕЗ)-ыг хэвшүүлэн ажиллаж байна.

Статистикийн мэдээ, тооллого, судалгааны мэдээллийг нэгтгэж, боловсруулахад 2025 оны байдлаар ҮСХ-оос баталж, зөвшөөрсөн 85 аргачлал, 14 ангиллыг мөрдөж байна. ҮСХ-оос статистикийн үзүүлэлт, аргачлалыг олон улсын стандартад нийцүүлэх ажлын хүрээнд 2025 онд 3 аргачлал, 1 ангилал, 7 тооллого, судалгааны үзэл баримтлал, асуулга, нөхөх заавар, 7 мэдээний маягт, нөхөх заавар, 3 гарын авлага, заавар нийт 21 арга зүйн баримт бичгийг шинээр болон шинэчлэн боловсруулж, баталсан (Хавсралт 1).



Зураг 1. ШИНЭЭР БАТАЛСАН АРГАЧЛАЛ, МАЯГТ, АСУУЛГА, НӨХӨХ ЗААВАР, ГАРЫН АВЛАГА



### 1.2 АЛБАН ЁСНЫ СТАТИСТИКИЙН МЭДЭЭ

ҮСХ нь Статистикийн тухай хуульд заасны дагуу албан ёсны статистикийн 48 багц үзүүлэлтийг анхан шатны бүртгэл, захиргааны болон албан ёсны статистикийн мэдээ, тооллого, түүвэр судалгаагаар нэгтгэн боловсруулж байна.

Статистикийн мэдээллийн нэгдсэн сан ([www.1212.mn](http://www.1212.mn))-д 6 бүлгийн 859 үзүүлэлтийг тогтмол нийтэлж байгаа бөгөөд 2025 онд бүсчилсэн хөгжлийн 216 үзүүлэлтийг шинээр нэмж орууллаа (Хавсралт 2,3).




Хүснэгт 1. СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНД ТАРХААЖ БУЙ ҮЗҮҮЛЭЛТ

|                            | Ангилал | Бүлгийн тоо | Үзүүлэлтийн тоо |
|----------------------------|---------|-------------|-----------------|
| Хүн ам, өрх                |         | 6           | 89              |
| Нийгэм, хөгжил             |         | 12          | 255             |
| Хөдөлмөр, бизнес           |         | 6           | 101             |
| Үйлдвэрлэл, үйлчилгээ      |         | 11          | 124             |
| Эдийн засаг, байгаль орчин |         | 12          | 168             |
| Боловсрол, эрүүл мэнд      |         | 9           | 122             |

Бид өнгөрсөн онд албан ёсны статистикийн мэдээ, тооллого судалгааны үр дүнг 7 хоног, 15 хоног, сар, улирал, хагас жил, жилийн давтамжтай боловсруулж, батлагдсан хуваарийн дагуу нийтэд мэдээлж, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдлын сарын 12 танилцуулга, жилийн эмхэтгэл, салбарын 28 танилцуулгыг боловсруулж, хэрэглэгчдэд тархаалаа (Хавсралт4).


Тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ)-ын хэрэгжилтийг хянах шалгуур үзүүлэлтүүдэд хийсэн 2025 оны цогц үнэлгээний үр дүнг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Статистикийн комиссын 56 дугаар чуулганаар хэлэлцэн баталснаар ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийн тоо 248-аас 251 болж нэмэгдсэн. Монгол Улс 2024 онд үүнээс 156 үзүүлэлтийн мэдээллийг тооцож байсан бол 2025 онд шинээр 6 үзүүлэлт, нийт 162 үзүүлэлт буюу 65 хувийг тооцох боломжтой болж, мэдээллийн бэлэн байдлыг нэмэгдүүллээ (Хавсралт5).

**Зураг 2.ТХЗ-ЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН МЭДЭЭЛЛИЙН БЭЛЭН БАЙДАЛ, 2025 он**



● Тооцож байгаа    ● Монгол Улсад хамааралгүй  
 ● Мэдээллийн эх үүсвэргүй

**Зураг 3.АЗИ, НОМХОН ДАЛАЙН БҮСИЙН УЛСУУДЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН МЭДЭЭЛЛИЙН БЭЛЭН БАЙДАЛ**



● Тоо мэдээлэл нь хангалттай    ● Тоо мэдээлэл нь хангалттай бус  
 ● Мэдээллийн эх үүсвэргүй    ● Тухайн улсад хамааралгүй

### 1.3 СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР

Өнгөрсөн онд бид Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдлын сар, улирал, жилийн статистик мэдээг бэлтгэхэд давхардсан тоогоор 34.0 мянган аж ахуйн нэгж, байгууллага, 30.1 мянган өрхөөс мэдээлэл цуглуулж, нэгтгэн боловсруулсан байна.

ҮСХ-нд албан ёсны болон захиргааны статистикийн мэдээ, тайлан ирүүлэх 2025 оны батлагдсан хуваарийн дагуу орон нутгийн статистикийн нэгжээс 47 маягт, 43 төрийн байгууллагаас захиргааны 415 маягтаар сарын давтамжтай 53, улирлын давтамжтай 27, жилийн давтамжтай 335 мэдээллийг нэгтгэн ажиллаж байна. Мөн өнгөрсөн онд бид статистик мэдээллийн хамралт, чанарыг сайжруулах зорилгоор уламжлалт бус мэдээллийг эх үүсвэрийг нэмэгдүүлсэн.

**Зураг 4. УЛАМЖЛАЛТ БУС МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭРИЙН АШИГЛАЛТ**



Scanner data:  
НӨАТ, НӨАТУС  
мэдээллийн сан



Web scrapping:  
Цахим хуудас  
ашиглалт

- Дотоод худалдаа: 23.6 мянган ААНБ
- Тээвэр: 1.7 мянган ААНБ
- Байр сууцаар хангах нийтийн хоол: 1.6 мянган ААНБ
- Холбоо: 1 мянга гаруй ААНБ

- Орон сууцны үнэ, түрээсийн үнэ:  
Зар мэдээллийн цахим хуудасны 3000-3500 зар мэдээллээс цахим хуудас шүүх аргаар орон сууцны үнэ сарын түрээсийн дундаж үнийг Улаанбаатар хотын дүүргээр тооцон, сар бүр тархааж байна.

## 1.4 ЗОХИОН БАЙГУУЛСАН ТООЛЛОГО, СУДАЛГАА

ҮСХ нь Статистикийн тухай хуульд заасны дагуу 2025 онд 2 тооллого, 9 түүвэр судалгааг зохион байгуулж явууллаа.

### 1.4.1 ТООЛЛОГО

#### 1. Хүн ам, орон сууцны 2025 оны завсрын тооллого

Үндэсний Статистикийн Хороо нь Статистикийн тухай болон Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хуульд заасны дагуу Хүн ам, орон сууцны завсрын тооллогыг 2025 онд төрийн 14 байгууллагын суурь болон төрөлжсөн 30 мэдээллийн санг ашиглаж, бүртгэлд суурилсан аргаар зохион байгууллаа.

Энэ удаагийн завсрын тооллогын хүрээнд төрийн байгууллагуудын суурь болон төрөлжсөн мэдээллийн санг тодорхойлж, чанарын үнэлгээ хийж, мэдээллийг нэгтгэх технологи, дэд бүтцийн орчныг бүрдүүлсэн бөгөөд ингэснээр хүн ам, орон сууцны мэдээллийг жил бүр цуглуулж, нэгтгэн боловсруулж, үр дүнг тогтмол тархах боломжийг бүрдүүлсэн.

Хүн ам, орон сууцны завсрын тооллогыг 2025 оны 4 дүгээр улиралд зохион байгуулсан бөгөөд тооллогоор Монгол Улсын хүн ам, өрхийн бүтэц, амьжиргаа, шилжилт хөдөлгөөн, орон сууцны суурь нөхцөл байдлын мэдээллийг улс, бүс, засаг захиргааны анхан шатны нэгжийн түвшинд бүрдүүлсэн.

Мөн тооллогын мэдээллийн чанарыг хангах хүрээнд Дан систем, утас болон биечлэн мэдээлэл цуглуулах аргаар улсын хэмжээнд 570.4 мянган өрхөөс өрх болон өрхийн гишүүдийн мэдээллийг нь цуглуулж, чанар, бодит байдлыг баталгаажуулсан.

#### Тооллогын үр дүнгээс:

Хүн ам, орон сууцны 2025 оны завсрын тооллогоор Монгол Улсын харьяат хүн ам 3,589,691 боллоо. Монгол Улсын хүн ам 2020 оноос 6.9 хувь, 1990 оноос 66.7 хувь, 1918 оноос 5.5 дахин өсжээ. Монгол Улсын суурин хүн ам 3 426 762, гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа хүн амын тоо 201 392 болсон. Харин Монгол Улсад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа гадаадын харьяат хүн 35 446, харьяалалгүй 18 хүн байна.



Хүснэгт 2. МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН ТОО, тооллогын оноор

| Тооллогын он | Хүн амын тоо (мян.хүн) |         |         | Хүйсийн харьцаа |
|--------------|------------------------|---------|---------|-----------------|
|              | Бүгд                   | Эрэгтэй | Эмэгтэй |                 |
| 1918         | 647.5                  | 330.2   | 317.3   | 104.1           |
| 1935         | 738.2                  | 370.8   | 367.4   | 100.9           |
| 1944         | 759.1                  | 371.3   | 387.8   | 95.7            |
| 1956         | 845.5                  | 420.3   | 425.2   | 98.8            |
| 1963         | 1,017.1                | 508.0   | 509.1   | 99.8            |
| 1969         | 1,197.6                | 597.4   | 600.2   | 99.5            |
| 1979         | 1,595.0                | 798.9   | 796.1   | 100.4           |
| 1989         | 2,044.0                | 1,020.7 | 1,023.3 | 99.7            |
| 2000         | 2,373.5                | 1,178.0 | 1,195.5 | 98.5            |
| 2010         | 2,754.7                | 1,363.9 | 1,390.8 | 98.1            |
| 2015         | 3,057.8                | 1,503.6 | 1,554.2 | 96.7            |
| 2020         | 3,296.9                | 1,619.6 | 1,677.3 | 96.6            |
| 2025         | 3,591.1                | 1,758.5 | 1,832.6 | 96.0            |

Монгол Улсын хүн амын суурьшлыг бүсээр ангилж үзэхэд нийт хүн амын 50.0 хувь нь Улаанбаатар хотод, 16.9 хувь нь Хангайн бүсэд, 14.8 хувь нь Төвийн бүсэд, 11.9 хувь нь Баруун бүсэд, 6.4 хувь нь Зүүн бүсэд оршин сууж байна.




Хүснэгт 3. МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН ТОО, аймаг, нийслэлээр

| Аймаг, нийслэл     | 2015           | 2020           | 2025           | 2015/2025 (%) | 2020/2025 (%) |
|--------------------|----------------|----------------|----------------|---------------|---------------|
| <b>Бүгд</b>        | 3,057.8        | 3,296.9        | 3,589.7        | 17.4          | 8.9           |
| <b>Баруун бүс</b>  | 390.6          | 412.0          | 425.8          | 9.0           | 3.3           |
| Баян-Өлгий         | 100.2          | 108.5          | 119.2          | 19.0          | 9.8           |
| Говь-Алтай         | 56.2           | 57.7           | 56.8           | 1.1           | -1.6          |
| Завхан             | 69.9           | 72.8           | 71.0           | 1.6           | -2.5          |
| Увс                | 80.8           | 83.2           | 85.4           | 5.7           | 2.6           |
| Ховд               | 83.5           | 89.7           | 93.4           | 11.8          | 4.1           |
| <b>Хангайн бүс</b> | 577.3          | 605.2          | 607.4          | 5.2           | 0.4           |
| Архангай           | 92.1           | 95.0           | 92.6           | 0.6           | -2.6          |
| Баянхонгор         | 83.9           | 88.7           | 89.4           | 6.5           | 0.8           |
| Булган             | 60.0           | 62.1           | 60.6           | 1.0           | -2.4          |
| Орхон              | 100.7          | 107.6          | 111.5          | 10.7          | 3.6           |
| Өвөрхангай         | 112.4          | 116.7          | 115.5          | 2.8           | -1.0          |
| Хөвсгөл            | 128.2          | 135.1          | 137.8          | 7.5           | 2.0           |
| <b>Төвийн бүс</b>  | 485.5          | 516.6          | 529.7          | 9.1           | 2.5           |
| Говьсүмбэр         | 16.5           | 17.9           | 18.7           | 13.4          | 4.5           |
| Дархан-Уул         | 100.9          | 107.0          | 111.2          | 10.2          | 3.9           |
| Дорноговь          | 65.3           | 71.0           | 72.5           | 11.0          | 2.1           |
| Дундговь           | 44.4           | 47.1           | 46.5           | 4.8           | -1.2          |
| Өмнөговь           | 61.7           | 69.2           | 79.0           | 28.1          | 14.2          |
| Сэлэнгэ            | 106.3          | 110.1          | 107.7          | 1.3           | -2.2          |
| Төв                | 90.4           | 94.3           | 94.0           | 4.0           | -0.3          |
| <b>Зүүн бүс</b>    | 208.1          | 223.2          | 231.5          | 11.2          | 3.7           |
| Дорнод             | 76.5           | 82.1           | 85.0           | 11.1          | 3.6           |
| Сүхбаатар          | 59.0           | 63.2           | 66.6           | 12.8          | 5.4           |
| Хэнтий             | 72.6           | 78.0           | 79.9           | 10.1          | 2.5           |
| <b>Улаанбаатар</b> | <b>1,396.3</b> | <b>1,539.8</b> | <b>1,795.3</b> | <b>28.6</b>   | <b>16.6</b>   |

Монгол Улсын хүн амын 49.0 хувь нь эрэгтэйчүүд, 51.0 хувь нь эмэгтэйчүүд байна. Хүйсийн харьцаа буюу 100 эмэгтэйд ногдох эрчүүдийн тоо 96.0 болж өмнөх тооллогын түвшнээс 0.6 нэгж хувиар буурав.



Зураг 5. ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА



## 2. Мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн тооллого

ҮСХ-оос Статистикийн тухай хуульд заасны дагуу орон нутгийн засаг захиргаатай хамтарч Мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн тооллогыг жил бүр зохион байгуулж, мал, амьтдын тоо, үйлдвэрлэл, малчдын мэдээллийг улс, бүс, засаг захиргааны анхан шатны нэгжийн түвшинд бүрдүүлж, нийтэд тархааж байна.

Энэ удаагийн мал тооллогыг 2025 оны 12 дугаар сарын 7-оос 17-ны өдрүүдэд зохион байгуулж, улсын төсвөөс 178.5 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 554.4 сая төгрөг, нийт 746.7 сая төгрөгийг зарцуулсан байна. Тооллогод аймаг, сумын нийт 2700 чиглэлд, 11.0 мянган хүн ажиллаж, тооллогын мэдээлэл цуглуулалт, хяналт, мэдээлэл шивэлтийн ажлыг гүйцэтгэж, үр дүнг өрх, баг, хороо, сум, дүүрэг, аймаг, нийслэл, улсын түвшинд нэгтгэн боловсруулсан.

Мал тооллогын мэдээлэл нь мал, амьтдын өсөлт, бууралт, сүргийн бүтцэд гарч байгаа өөрчлөлтөд дүн шинжилгээ хийх, МАА-н салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнийг тооцоход ашиглах гол мэдээлэл болдог. Мөн эдийн засгийн гол салбарын нэг болох хөдөө аж ахуйн талаарх нотолгоонд суурилсан шийдвэр гаргах, бодлого боловсруулахад үндсэн мэдээллийн сан болдог. Түүнчлэн, малчид, мал бүхий иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд малын бүртгэл мэдээллээ ашиглан нийгэм, эдийн засгийн үйлчилгээ авах, хөрөнгийн баталгаа болгох зэргээр ашиглаж байна.

### Тооллогын үр дүнгээс:

Улсын хэмжээнд 2025 онд, урьдчилсан дүнгээр 248.0 мянган малтай өрх тооллогод хамрагдаж, өмнөх оноос 1.5 мянган өрхөөр буюу 0.6 хувиар буурсан байна.

Тооллогоор нийт 58.1 сая толгой мал, үүнээс 5.1 сая адуу, 5.4 сая үхэр, 501.3 мянган тэмээ, 23.9 сая хонь, 23.2 сая ямаа тоологдов. Малын тоо өмнөх оноос 454.6 мянга (0.8%)-аар өссөн байна. Малын төрлөөр авч үзвэл, адуу 445.4 мянга (9.5%), үхэр 367.0 мянга (7.2%), ямаа 250.1 мянга (1.1%), тэмээ 20.7 мянга (4.3%)-аар тус тус өссөн бол хонь 628.7 мянга (2.6%) буурсан байна.



Хүснэгт 4. МАЛ ТООЛЛОГЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, 2025 он

| Үзүүлэлт                                      | Бүгд | Малын төрлөөр |      |       |      |      |
|---|------|---------------|------|-------|------|------|
|   |      | Адуу          | Үхэр | Тэмээ | Хонь | Ямаа |
| Малын тоо, сая.тол                            | 58.1 | 5.1           | 5.4  | 0.5   | 23.9 | 23.2 |
| Хээлтэгч мал, сая.тол                         | 25.3 | 1.8           | 2.2  | 0.2   | 11.0 | 10.0 |
| Төллөсөн хээлтэгч, сая.тол                    | 22.4 | 1.4           | 1.7  | 0.01  | 10.2 | 9.0  |
| Төллөлтийн хувь                               | 84.0 | 78.5          | 81.0 | 53.1  | 86.3 | 83.5 |
| Бойжуулсан төл, сая.тол                       | 21.7 | 1.3           | 1.7  | 0.09  | 9.9  | 9.7  |
| Бойжилтын хувь                                | 96.5 | 96.9          | 96.8 | 95.7  | 96.8 | 96.1 |
| Хорогдсон том мал, сая.тол                    | 0.4  | 0.04          | 0.05 | 0.002 | 0.1  | 0.1  |
| Оны эхний малд том малын хорогдлын эзлэх хувь | 0.6  | 0.8           | 0.9  | 0.4   | 0.6  | 0.6  |
| Малтай нэг өрхөд ногдох малын тоо, толгой     | 233  | 21            | 22   | 2     | 96   | 93   |
| Малчин нэг өрхөд ногдох малын тоо, толгой     | 272  | 23            | 24   | 2     | 112  | 110  |



## 1.4.2 ТҮҮВЭР СУДАЛГАА

### 1. Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа (ӨНЭЗС)

Статистикийн тухай хуульд заасны дагуу ҮСХ-оос ӨНЭЗС-ны мэдээлэл цуглуулалтыг сар бүр зохион байгуулж, үр дүнг улирал, жилээр тооцон тархааж байна. Судалгааны мэдээллээр хүн амын амьжиргааны түвшин, өрхийн сарын орлого, зарлагыг улирал болон жилээр тооцон хэрэглэгчдэд хүргэж байна. Тус судалгаа нь дотоодын нийт бүтээгдэхүүнийг эцсийн ашиглалтын аргаар тооцох, хэрэглээний үнийн индексийн тооцоонд ашиглах бараа, бүтээгдэхүүний сагсыг бүрдүүлэх болон тооцооны жинг шинэчлэх үндсэн мэдээлэл болохоос гадна Монгол Улсын ТХЗ-ын хэрэгжилтийг хэмжих, орлогыг орлуулан тооцох арга зүйг боловсруулах, жижиг нутаг дэвсгэрийн тооцоолол хийх, хүн амын амьжиргааг дэмжих чиглэлээр төрийн бодлого боловсруулах, дүн шинжилгээ хийх суурь мэдээлэл болдог.

Судалгааны мэдээлэл цуглуулалтад 2025 онд нээлттэй эх үүсвэрийн Survey Solution программыг нэвтрүүлж, өндөр давтамжтай мэдээллийн чанарын хяналтын программыг Tableau-д шилжүүллээ. Судалгааны мэдээллийг 2025 онд 876 түүврийн анхан шатны нэгжийн 8760 өрхөөс цахим төхөөрөмж (CAPI) болон нийслэл, аймгийн төвийн нэгжийн өрхийн хүнсний мэдээллийг өдрийн тэмдэглэл хөтлүүлэн цуглуулсан. Мөн нийслэл, аймгийн төвийн 504 түүврийн анхан шатны нэгжид нэмэлтээр 1008 өрхөөс хүнсний мэдээллийг сануулах аргаар цуглуулах туршилт судалгааг зохион байгуулсан.

#### Судалгааны үр дүнгээс:

Судалгааны 2025 оны 4 дүгээр улирлын дүнгээр өрхийн сарын дундаж нийт орлого, оны үнээр 3.0 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 371.2 (14.1%) мянган төгрөгөөр, өмнөх улирлаас 41.4 (1.4%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.



Хүснэгт 5. ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ НИЙТ ОРЛОГО, мянган төгрөгөөр

| Үзүүлэлт               | Жил           |         |         | Улирал        |               |               | 2025 X-XII/<br>2024 X-XII |      |
|------------------------|---------------|---------|---------|---------------|---------------|---------------|---------------------------|------|
|                        | 2022          | 2023    | 2024    | 2023<br>X-XII | 2024<br>X-XII | 2025<br>X-XII | дүн                       | хувь |
|                        | мянган төгрөг |         |         |               |               |               |                           |      |
| <b>Нэрлэсэн орлого</b> |               |         |         |               |               |               |                           |      |
| Нийт орлого            | 1 860.6       | 2 162.3 | 2 567.9 | 2 308.1       | 2 641.7       | 3 012.9       | 371.2                     | 14.1 |
| Мөнгөн орлого          | 1 728.9       | 2 022.0 | 2 409.8 | 2 168.7       | 2 486.5       | 2 841.6       | 355.1                     | 14.3 |
| <b>Бодит орлого</b>    |               |         |         |               |               |               |                           |      |
| Бодит нийт орлого      | 1 440.1       | 1 550.8 | 1 689.6 | 1 663.5       | 1 762.2       | 1 850.7       | 88.5                      | 5    |
| Бодит мөнгөн орлого    | 1 338.2       | 1 450.1 | 1 585.6 | 1 563.0       | 1 658.7       | 1 745.5       | 86.8                      | 5.2  |

Үнийн нөлөөллийг арилган тооцвол, 2020 оны үнээр илэрхийлэгдсэн нэг өрхийн сарын дундаж бодит нийт орлого 1.9 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 88.5 (5.0%) мянган төгрөгөөр нэмэгдэж, харин өмнөх улирлаас 9.5 (0.5%) мянган төгрөгөөр буурсан байна. Бодит орлогын өсөлтийг төрлөөр задалж үзвэл, өмнөх оны мөн үеэс цалин хөлсний орлого 54.1 (5.7%) мянган төгрөгөөр, хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого 17.8 (22.5%) мянган төгрөгөөр нэмэгдсэн нь бодит нийт орлого 5.0 хувиар нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

Судалгааны 2025 оны 4 дүгээр улирлын дүнгээр нэг өрхийн сарын дундаж нийт зарлага, оны үнээр 3.1 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 382.5 (14.1%) мянган төгрөгөөр, өмнөх улирлаас 10.0 (0.3%) мянган төгрөгөөр нэмэгджээ.



Хүснэгт 6. ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ НИЙТ ЗАРЛАГА, мянган төгрөгөөр

| Үзүүлэлт                | Жил           |         |         | Улирал        |               |               | 2025 X-XII/<br>2024 X-XII |      |
|-------------------------|---------------|---------|---------|---------------|---------------|---------------|---------------------------|------|
|                         | 2022          | 2023    | 2024    | 2023<br>X-XII | 2024<br>X-XII | 2025<br>X-XII | дүн                       | хувь |
|                         | мянган төгрөг |         |         |               |               |               |                           |      |
| <b>Нэрлэсэн зарлага</b> |               |         |         |               |               |               |                           |      |
| Нийт зарлага            | 1 851.6       | 2 196.6 | 2 631.7 | 2 309.5       | 2 721.3       | 3 103.8       | 382.5                     | 14.1 |
| Мөнгөн зарлага          | 1 720.0       | 2 056.2 | 2 473.6 | 2 170.0       | 2 566.1       | 2 932.4       | 366.3                     | 14.3 |
| <b>Бодит зарлага</b>    |               |         |         |               |               |               |                           |      |
| Бодит нийт зарлага      | 1 433.2       | 1 575.3 | 1 731.6 | 1 664.4       | 1 815.3       | 1 906.5       | 91.2                      | 5    |
| Бодит мөнгөн зарлага    | 1 331.2       | 1 474.6 | 1 627.6 | 1 564.0       | 1 711.8       | 1 801.3       | 89.5                      | 5.2  |

Үнийн нөлөөллийг арилган тооцвол, 2020 оны үнээр илэрхийлэгдсэн нэг өрхийн сарын дундаж бодит нийт зарлага 1.9 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 91.2 (5.0%) мянган төгрөгөөр нэмэгдэж, өмнөх улирлаас 30.2 (1.6%) мянган төгрөгөөр буурсан байна. Бодит зарлагын өсөлтийг төрлөөр задалж үзвэл, өмнөх оны мөн үеэс хүнсний бус бараа, үйлчилгээний зардал дунджаар 77.1 (6.6%) мянган төгрөгөөр нэмэгдсэн нь бодит нийт зарлага 5.0 хувиар нэмэгдэхэд нөлөөлсөн байна.



## 2. Ажиллах хүчний судалгаа (АХС)


ҮСХ нь Ажиллах хүчний судалгааг жил бүр зохион байгуулж, үр дүнг улирал, жилээр тооцон тархааж байна. Судалгааны зорилго нь хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөрийн зах зээл дэх оролцоо, ажиллах хүч, ажиллах хүчнээс гадуурх хүн ам, хөдөлмөрийн дутуу ашиглалтыг тодорхойлох юм.

2025 онд судалгааны мэдээллийг 695 түүврийн анхан шатны нэгжийн 15654 өрхөөс цахим төхөөрөмж (CAPI)-өөр цуглуулж, улс, бүс нутаг, аймаг, нийслэлийн түвшинд хүн амын хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн дутуу ашиглалтын үзүүлэлтийг тархаасан. Мөн ОУХБ-ын зөвлөмжийн дагуу түүврийн сэлгэлтийн 2:2:2 схем буюу 50 хувийг нь давтан сонгож, 50 хувьд нь сэлгэлт хийх зарчмаар 2026-2028 онд буюу 3 жилээр хийхээр түүврийн хуваарилалтыг шинэчлэн боловсруулсан. Ингэснээр хөдөлмөрийн зах зээлд гарч буй өөрчлөлтийг 3 жилийн хугацаанд давтан ажиглалт хийх ба хугацааны цуваан өөрчлөлтийг илүү нарийвчлалтай судлах нөхцөл бүрдэж байна.

**Судалгааны үр дүнгээс:**

Судалгааны 2025 оны 4 дүгээр улирлын үр дүнгээр, ажиллах хүчний 94.4 (1.4 сая) хувь нь ажиллагчид, 5.6 (82.7 мянга) хувь нь ажилгүй хүн байна. Ажиллах хүчнээс гадуур хүн ам (886.5 мянга)-ын 3.5 (31.4 мянга) хувь нь цалин хөлс, орлого олох ажил хайх эсвэл хийх нөхцөл нь бүрдвэл ажиллах хүчний эгнээнд шилжихэд бэлэн байгаа боломжит ажиллах хүч байна.

**Зураг 6.15 БА ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, улсын дүнгээр, улирлаар**



Ажиллах хүчний оролцооны түвшин 2025 оны 4 дүгээр улиралд 62.3 хувь болж, өмнөх улирлаас 0.3 нэгж хувиар буурсан бол өмнөх оны мөн үеэс 0.1 нэгж хувиар өссөн байна. Хөдөлмөрийн насны хүн амд ажиллагчдын эзлэх хувь буюу хөдөлмөр эрхлэлтийн түвшин 58.8 хувь болж, өмнөх улирлаас 0.4 нэгж хувиар, өмнөх оны мөн үеэс 0.1 нэгж хувиар тус тус буурсан байна.

**Зураг 7. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТҮВШИН, улирлаар**





Зураг 8. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ДУТУУ АШИГЛАЛТЫН ТҮВШИН, улирлаар



Хөдөлмөрийн дутуу ашиглалтыг үнэлэх 4 үзүүлэлт өмнөх оны мөн үетэй харьцуулахад, ажилгүйдлийн түвшин 0.3 нэгж хувиар, цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлт болон ажилгүйдлийн нэгдсэн түвшин 0.3 нэгж хувиар, ажилгүй хүн болон боломжит ажиллах хүчний нэгдсэн түвшин 1.6 нэгж хувиар тус тус өссөн байна.



### 3. Ардчилсан засаглал судалгаа

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтын "Хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх" 9 дэх зорилго, ТХЗ-ын хүрээнд дэвшүүлсэн "Чанартай боловсролыг дэмжих" 4 дүгээр зорилго, "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах" 5 дугаар зорилго, "Энх тайван, шударга ёсыг цогцлоох" 16 дугаар зорилго, "Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх" 17 дугаар зорилгуудын хэрэгжилтийг үнэлэх зарим шалгуур үзүүлэлтүүдийг улс, бүс нутгийн түвшинд тодорхойлох зорилгоор 2008 оны 3 дугаар улирлаас эхлэн уг судалгааг зохион байгуулж ирсэн.

Тус судалгааг 2025 онд ӨНЭЭС-ны хавсарга судалгаа хэлбэрээр зохион байгуулж, судалгаагаар 2560 өрхийн 3679 иргэнийг хамруулсан.



### 4. Дотоодын жуулчдын түүвэр судалгаа


ҮСХ-оос Статистикийн тухай хууль, Аялал жуулчлалын тухай хуульд заасны дагуу дотоодын аялал жуулчлалын шаардлагатай үзүүлэлтүүдийг бий болгох зорилгоор олон улсын нийтлэг арга зүйд үндэслэн Дотоодын жуулчдын түүвэр судалгааг 2025 онд анх удаа зохион байгуулсан. Судалгаанд улсын хэмжээнд 13.3 мянган иргэнийг санамсаргүй түүврийн аргаар сонгож, сүүлийн нэг жилийн хугацааны аяллын мэдээллийг компьютер ашиглан утсаар ярилцлага авах (CATI) аргаар цуглуулсан.

**Судалгааны үр дүнгээс:**

Судалгааны дүнгээр 2024 онд Монгол Улсын суурин хүн амын 49% буюу 1.7 сая хүн аялсан байна. Тухайлбал, хангайн бүсэд 1.5 сая жуулчин, баруун бүсэд 670.0 мянган жуулчин, төвийн бүсэд 600.0 мянган жуулчин, зүүн бүсэд 251.7 мянган жуулчин, Улаанбаатарт 230.1 мянган жуулчин тус тус аялсан байна




**Зураг 9. ДОТООДЫН ЖУУЛЧДЫН ТОО, аймаг, нийслэлээр, давхардсан тоогоор, мянган хүн**



Дотоодын жуулчид 7-8 саруудад хамгийн их аялал хийсэн бөгөөд нэг аялал дунджаар 7-8 хоног үргэлжилжээ.




**Зураг 10. ДОТООДЫН ЖУУЛЧДЫН ТОО, сараар, мянган хүн**



Дотоодын жуулчдын аяллын зорилгоор нь авч үзвэл нийт жуулчдын 1.4 сая жуулчин байгалийн дурсгалт газар үзэх зорилгоор, 555.2 мянган жуулчин найз нөхөд хамаатан садныдаа зочлох зорилгоор, 476.3 мянган жуулчин дамжин өнгөрөх зорилгоор, 496.7 мянган жуулчин баяр ёслолын амралт зугаалга, эрүүл мэндэд суурилсан эмчилгээ, рашаан сувиллын зорилгоор, 126.0 мянган жуулчин соёл, урлаг спортын арга хэмжээнд оролцох зорилгоор, 86.4 мянган жуулчин албан томилолт/ бизнесийн зорилгоор тус тус аялсан байна.



Зураг 11. ДОТООДЫН ЖУУЛЧДЫН ТОО, аялын зорилгоор, мянган хүн



## 5. Хувиараа хөдөлмөр эрхлэлтийн судалгаа (ХХЭС)

ҮСХ нь Нөөц ашиглалтын хүснэгтийг 2024 оны гүйцэтгэлээр байгуулах ажлын хүрээнд ХХЭС-г 2025 оны 5 дугаар сарын 19-ны өдрөөс 6 дугаар сарын 19-ний хооронд улсын хэмжээнд зохион байгуулж, өгөгдлийн шалгалт, засварлалт, дүн шинжилгээг хийж, судалгааны тайланг боловсруулсан. Судалгааны үр дүн нь албан бус эдийн засгийн хэмжээг шинэчлэн тооцох үндсэн мэдээллийн эх үүсвэр болсон бөгөөд үр дүнг 2024 оны суурьтай НАХ болон ДНБ-ий тооцоонд тусгахаар нэгтгэн боловсруулав.

### Судалгааны үр дүнгээс:

Хувиараа хөдөлмөр эрхлэлтийн 2024 оны судалгааны дүнгээс үзэхэд Монгол Улсад нийт 166.6 мянган хувиараа хөдөлмөр эрхлэгч нэгж (ХХЭН) үйл ажиллагаа явуулж байна. Эдгээрийн 42.4 хувь нь үйлчилгээ, 36.7 хувь нь худалдаа, 15.4 хувь нь үйлдвэрлэл, харин 5.5 хувь нь барилгын салбарт хамаарч байна.



Хүснэгт 7. ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧ НЭГЖИЙН ЖИЛИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, ЗАВСРЫН ХЭРЭГЛЭЭ, НЭМЭГДЭЛ ӨРТӨГ, эдийн засгийн салбараар

| Эдийн засгийн үйл ажиллагааны салбар   | Нийт үйлдвэрлэлт (тэрбум төг) | Завсрын хэрэглээ (тэрбум төг) | Нэмэгдэл өртөг (тэрбум төг) | Нэг нэгжид ногдох нэмэгдэл өртөг (сая.төг) | Нийт нэмэгдэл өртгийн дүнд салбаруудын эзлэх хувь |
|--|-------------------------------|-------------------------------|-----------------------------|--|---|
| Бүгд дүн   | 6 170.5                       | 2 249.8                       | 3 920.7                     | 23.5                                       | 100   |
| Хөдөө аж ахуй  | 244.3                         | 85.5                          | 158.8                       | 22.6                                       | 4   |
| Боловсруулах үйлдвэр   | 950.8                         | 434.9                         | 515.9                       | 20.4                                       | 13.2  |
| Усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа | 6.0                           | 4.5                           | 1.5                         | 4.7  | 0   |
| Барилга  | 490.2                         | 90.7                          | 399.5                       | 43.7                                       | 10.2  |
| Бөөний, жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ                | 2 425.6                       | 743.8                         | 1 681.8                     | 27.5                                       | 42.9  |
| Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа  | 933.7                         | 403.9                         | 529.8                       | 15.7                                       | 13.5  |
| Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа                           | 476.0                         | 239.1                         | 236.8                       | 31.2                                       | 6   |
| Мэдээлэл, холбоо   | 19.7                          | 4.1                           | 15.6                        | 10.4                                       | 0.4   |



**Зураг 12. ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧ НЭГЖИЙН НЭМЭГДЭЛ ӨРТГИЙН ДНБ-Д ЭЗЛЭХ ХУВЬ, ЭДИЙН ЗАСГИЙН САЛБАРААР**



Хувиараа хөдөлмөр эрхлэгч нэгжүүд 2024 онд нийт 3.9 их наяд төгрөгийн нэмэгдэл өртөг бий болгож, энэ нь ДНБ-ий 4.9 хувийг бүрдүүлж байна. Нэмэгдэл өртгийн энэхүү хувь хэмжээг салбараар нь авч үзвэл үсчин, гоо сайхан, гутал болон гэр ахуйн засвар, шашны үйлчилгээ хамаарах үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбар хамгийн өндөр буюу тухайн салбарын ДНБ-ий 75.0 хувийг бүрдүүлж байна.



## 6. Нөөц, ашиглалтын хүснэгт, Салбар хоорондын тэнцлийг 2024 оны гүйцэтгэлээр байгуулах судалгаа

Судалгааны мэдээлэл цуглуулалтыг 2025 оны 5 дугаар сарын 12-ны өдрөөс 6 дугаар сарын 30-ны өдрүүдэд зохион байгуулж, цахим программд оруулсан мэдээллийг шалган баталгаажуулж, НАХ, СХТ байгуулах суурь мэдээллийг бүрдүүлэв.

Судалгаагаар цуглуулсан мэдээлэл болон жилийн эцсийн гүйцэтгэлд үндэслэн нийт үйлдвэрлэл, завсрын хэрэглээ, эцсийн хэрэглээ, хөрөнгийн хуримтлал, гадаад худалдааны матрицуудыг 2024 оны гүйцэтгэлээр 325x205 хэмжээстэйгээр байгуулж, НАХ, СХТ байгуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, үр дүнг 2026 оны эхний улиралд багтаан хэрэглэгчдэд хүргэхээр ажиллаж байна.

## 7. Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа нэмэх (I шат)

НҮБ-ын Хүүхдийн сангаас 1996, 2000, 2005, 2010, 2013, 2018, 2023 онд нийт 7 удаагийн Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгааны хөтөлбөрийг боловсруулан гаргасан. Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгааны (ОУБТС) хөтөлбөрийн зорилго нь хүүхэд, эмэгтэйчүүд болон өрхийн амьжиргааны нөхцөл байдлыг тодорхойлох олон улсад харьцуулах боломжтой, чанартай статистик мэдээллийг тогтмол цуглуулж, боловсруулах, тархаах замаар нотолгоонд суурилсан бодлого, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд улс орнуудад дэмжлэг үзүүлэхэд оршино. Мөн тус хөтөлбөр нь улс орнуудын статистикийн чадавхыг бэхжүүлэх, тогтвортой хөгжлийн зорилтууд болон хүүхдийн эрх, сайн сайхны талаарх олон улсын үүрэг амлалтыг хянахад шаардлагатай мэдээллийн суурийг бүрдүүлэхэд чиглэдэг.

Уг судалгаа нь НҮТС-нд хамрагдсан өрхүүдээс утсаар мэдээлэл цуглуулж, үр дүнг богино хугацаанд боловсруулан бодлого боловсруулагч, хэрэглэгчдэд тархаадгаараа онцлог юм. Монгол Улс анх КОВИД-19 цар тахлын үед 2020-2021 онд 7 шаттай, 2022-2023 онд 6 шаттайгаар уг судалгааг зохион байгуулсан бөгөөд өрх, гэр бүлийн амьжиргааны түвшин дэх өөрчлөлт, хүүхдийн нөхцөл байдалтай холбоотой боловсролын цахим сургалтын хүртээмж, хоол тэжээлийн байдал, эрүүл мэнд, дархлаажуулалт зэрэг чухал мэдээллийг цуглуулж, шийдвэр гаргагчид болон оролцогч талуудыг мэдээллээр хангаж ажилласан.

Энэ удаагийн судалгааны зорилго нь сүүлийн жилүүдэд төрөлт буурч буй хүчин зүйлсийг тодорхойлж, улмаар хүн амын өсөлт, төрөлтийг дэмжих бодлого боловсруулахад шаардлагатай тоон мэдээллийг бий болгох юм. Судалгааг Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын санаачилгын дагуу зохион байгуулсан бөгөөд 2023 оны НҮТС-нд хамрагдсан өрхөөс 3000 өрхийг санамсаргүй түүврийн аргаар сонгон судалгааны I шатны мэдээлэл цуглуулалтыг 2025 оны 10-аас 11 дүгээр сард зохион байгуулж, үр дүнг гаргаад байна.

## 8. Хагас жилийн мал тооллого, түүврийн аргаар

Хагас жилийн мал тооллогыг түүврийн аргаар 2025 оны 6 дугаар сарын 4-ний өдрөөс 10-ны өдрүүдэд зохион байгуулсан. Тооллогод 2024 оны жилийн эцсийн мал тооллогод хамрагдсан өрх, ААНБ-ын 20 хувь буюу 50468 нэгж түүвэрлэгдэн сонгогдсоноос 99.9 хувь буюу 50405 нэгж нь хамрагдав.

### Тооллогын үр дүнгээс:



**Хүснэгт 8. МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР АВСАН МАЛЧИН, ОЛГОСОН НӨХӨН ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ**

| Үзүүлэлт                      | 2022-2023 | 2023-2024 | 2024-2025 |
|-------------------------------|-----------|-----------|-----------|
| Нөхөн төлбөр авсан малчны тоо | 13 930    | 22 034    | 52        |
| Нөхөн төлбөр, сая төгрөг      | 4 177.9   | 16 817.7  | 1.6       |

2025 оны хагас жилийн мал тооллогын үр дүнгээр нийт малын 0.4 хувийг эзлэх 255.2 мянган толгой том мал зүй бусаар хорогдсон ба 7 аймгийн 10 суманд хорогдлын босго 5 хувиас давсан байна.

## 9. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн судалгаа

Хэрэглээний сагс гэдэг нь үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн дундаж өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалтыг ойлгоно. Хэрэглээний сагсанд хүн амын үйлдвэрлэлийн бус зориулалтаар худалдаж авсан бараа, үйлчилгээ ордог. Хэрэглээний үнийн индексийг "Хувийн зориулалттай хэрэглээний бараа, үйлчилгээний ангилал-2019"-ын дагуу ӨНЭЗС-ны зардлаар жигнэж, Ласпейресийн хувиргасан индексийн томъёогоор тооцож байна.

ҮСХ нь хэрэглээний үнийн мэдээг улсын хэмжээнд 21 аймаг, 112 сум, нийслэлийн төвийн 6 дүүргээс ойролцоогоор 2000 гаруй худалдааны төв болон цэгээс цуглуулж, нэгтгэн шалгаж, сар бүр тархааж байна.



## Хүснэгт 9. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭ

| Бараа, үйлчилгээний бүлэг                           | 2024 XII |         | 2025 XII |         | Өмнөх сараас |         |
|---|----------|---------|----------|---------|--------------|---------|
|   | Хувь     | Оролцоо | Хувь     | Оролцоо | Хувь         | Оролцоо |
| Ерөнхий индекс                                      | 8.3      | 100.0   | 7.5      | 100.0   | 0.6          | 100.0   |
| Хүнсний бараа, ундаа, ус                            | 2.3      | 28.0    | 3.0      | 39.8    | 0.4          | 73.1    |
| Согтууруулах ундаа, тамхи                           | 0.0      | 0.3     | 0.1      | 0.9     | 0.0          | 2.3     |
| Хувцас, бөс бараа, гутал                            | 1.2      | 14.7    | 0.9      | 12.1    | 0.1          | 13.2    |
| Орон сууц, ус, цахилгаан, түлш                      | 2.0      | 24.1    | 0.5      | 6.5     | 0.0          | 2.6     |
| Гэр ахуйн тавилга, бараа                            | 0.3      | 3.7     | 0.3      | 4.4     | 0.0          | 1.7     |
| Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ                      | 0.3      | 3.6     | 0.4      | 5.8     | 0.0          | 6.9     |
| Тээвэр  | 0.1      | 0.7     | 0.3      | 4.5     | -0.1         | -15.3   |
| Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ             | 0.1      | 1.0     | 0.1      | 1.1     | 0.0          | 1.1     |
| Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ         | 0.1      | 1.2     | 0.1      | 1.4     | 0.0          | 0.4     |
| Боловсролын үйлчилгээ                               | 1.0      | 12.4    | 0.8      | 10.5    | 0.0          | 0.0     |
| Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ | 0.3      | 3.3     | 0.3      | 3.5     | 0.0          | 2.5     |
| Даатгал, санхүүгийн үйлчилгээ                       | 0.0      | 0.1     | 0.1      | 0.8     | 0.0          | 0.0     |
| Бусад бараа, үйлчилгээ                              | 0.6      | 7.0     | 0.6      | 8.6     | 0.1          | 11.3    |

Инфляцын түвшин буюу хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2024 оны 12 дугаар сард 8.3 хувь байсан бол 2025 оны 12 дугаар сард 7.5 хувь болж, өсөлтийн хурдац өмнөх оны мөн үеэс 0.8 нэгж хувиар буурсан байна.



### 1.4.3 ГҮНЗГИЙРҮҮЛСЭН ШИНЖИЛГЭЭ

#### 1. Жижиг нутаг дэвсгэрийн шинжилгээ: Монгол Улсын ядуурал ба хөдөлмөр эрхлэлтийн зураглал

ҮСХ нь Дэлхийн банктай хамтарч Жижиг нутаг дэвсгэрийн тооцооллын Фэй-Хэрриотын загварт суурилсан аргачлалыг ашиглан Монгол Улсын ядуурал ба хөдөлмөр эрхлэлтийн 2022 оны түвшнийг сум, дүүргийн түвшинд нарийвчлан тооцлоо.




#### Шинжилгээний үр дүнгээс

Фэй-Хэрриот загварын вариацийн коэффициентийг шууд тооцооллынхтой харьцуулахад илүү нарийвчлалтай, найдвартай байгааг дараах үр дүнгүүд илтгэж байна.




Зураг 13. ФЭЙ-ХЭРРИОТ БА ШУУД ТООЦООЛЛЫН ХАРЬЦУУЛАЛТ, ТҮҮВРИЙН ХЭМЖЭЭ



Шууд тооцооллын вариацийн коэффициент нь 31.0 хувь байгаа бол Фэй-Хэрриот загварынх 19.0 хувь байна. Вариацийн коэффициент нь 30 хувиас доош байгаа сумдын эзлэх хувь нь шууд тооцооллоор 60.0 хувь байсан бол Фэй-Хэрриотын загвараар 93.0 хувь болж өссөн байна.




Зураг 14. ФЭЙ-ХЭРРИОТ ТООЦООЛОЛ: ҮНДЭСНИЙ ЯДУУРЛЫН ТҮВШИН





Зураг 15. ФЭЙ-ХЭРРИОТ ЗАГВАРААРХ УЛААНБААТАР ХОТЫН ЯДУУРЛЫН ТҮВШИН, дүүргээр



## 2. Монгол Улсын нийгмийн халамжийн арга хэмжээний ядуурал, тэгш бус байдлыг бууруулахад үзүүлж буй нөлөөллийн судалгаа

ҮСХ нь Дэлхийн банктай хамтран Монгол Улсын нийгмийн халамжийн арга хэмжээнүүдийн ядуурал болон тэгш бус байдлыг бууруулахад үзүүлж буй нөлөөг үнэлэх зорилготой шинжилгээний ажлыг зохион байгууллаа.

Энэхүү шинжилгээний ажлыг өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа (ӨНЭЗС)-нд тулгуурласан тоон мэдээлэл болон нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийн талаарх өгөгдлийг ашиглан, төсвийн дахин хуваарилалтын нөлөөг “Шударга байдлын амлалт” (Commitment to Equity) аргачлалаар хийсэн. Уг аргачлал нь татвар, шилжүүлэг, халамжийн нөлөөг өрхийн орлогын үе шат бүрээр авч үзэх замаар ядуурал, тэгш бус байдлын өөрчлөлтийг үнэлэх боломж олгодог.

### Шинжилгээний үр дүн:

Монгол Улс зорилтот бүлэг, төрөл, давтамж, хүргэх механизмын хувьд харилцан адилгүй 40 орчим төрлийн халамжийг олгодог байна. Тухайлбал, зарим халамжийн хөтөлбөр нь хүн ам зүйн болон хүн амын амьдралын мөчлөгийн онцлогоос хамааран бүх нийтийг хамруулах шинжтэй байна. Харин зарим хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээл, ажилгүйдэл зэргээс хамааран олгогдож байна.

Халамжийн хөтөлбөрүүд нь мөнгөн шилжүүлэг, ваучер зэрэг хөнгөлөлт, биет тусламж гэх мэт хэлбэртэй байна. Эдгээр хөтөлбөрүүдийг яам, агентлагууд нь өөр өөрийн эрх үүргийн хүрээнд холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж байгаа боловч эдгээрийн зорилго, зорилтот бүлгүүд нь давхцаж, уялдаа холбоогүй байх нь нийтлэг байна. Энэхүү төвөгтэй байдал нь нийгмийн халамжийн тогтолцоог удаан, уялдаа холбоогүй болгон зардлын үр ашгийг сулруулж, ил тод байдлыг хангах, стратегийн шинэчлэлийг хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж байна.




Зураг 16. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ЗАРДАЛ, хөтөлбөрөөр, 2024 он, тэрбум төгрөгөөр



Монгол Улсын нийгмийн халамжийн системийн хоёрдмол шинж чанар дараахаас харагдана. Нэг талаас зарим хөтөлбөрийн хувьд зорилтот бүлгээ оновчтой тодорхойлсон ч хамрах хүрээ сул, тэтгэмжийн мөнгөн дүн бага байгаа бол зарим хөтөлбөрийн хувьд зорилтот бүлгээ хэт өргөн хүрээг хамруулсан тодорхойлноос үүдэн, эмзэг бүлгийн өрхүүдэд хүрч чадахгүй байна.



Зураг 17. ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХАД НӨЛӨӨЛЖ БУЙ АХИУ НӨЛӨӨ



### 3. Гар утасны өгөгдлийг албан ёсны статистикт ашиглах туршилт тооцоо

ҮСХ нь Дэлхийн банкны техникийн туслалцаатайгаар “Өөрчлөлт, шинэчлэлд гар утасны өгөгдлийг ашиглах нь: Нотолгоонд суурилсан бодлого боловсруулах чадавхыг бэхжүүлэх нь” төслийг хэрэгжүүлэх 18 орны нэгээр сонгогдсон.

Төслийн хүрээнд гар утасны өгөгдлийг статистикийн зорилгоор ашиглах эрх зүйн орчин, арга зүй, мэдээллийн аюулгүй байдал, хүний эрхийн нөлөөллийн үнэлгээг хийсэн.

## 1. АЛБАН ЁСНЫ СТАТИСТИКИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Мөнгө оруулалтын өсөлт, хөгжлийг хамтран боловсруулж, Мобиком корпорац ХХК-ийн мэдээллийн санд бүртгэлтэй, идэвхтэй төлөвтэй хэрэглэгчдийн 5 хувийг санамсаргүй түүврийн аргаар сонгон мэдээллийн эзнийг тодорхойлох боломжгүй болгож, Үндэсний дата төвийн УТҮГ-т байршуулж, туршилтын тооцооллыг хийж эхлээд байна. Тооцооны үр дүнг 2026 оны эхний улиралд гаргах ба энэхүү ажлын хүрээнд бүрдсэн өгөгдөлд үндэслэн дотоодын аялал жуулчлалын тооцооллыг төлөвлөж байна.

### 1.5 СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН ТАРХААЛТ, ХЭРЭГЛЭЭ

ҮСХ нь статистик мэдээллээр хэрэглэгчдэд үйлчлэх, мэдээллийг хүртээмжтэй, ойлгомжтой хэлбэрээр тархахад анхааран ажиллаж байна. 2025 онд СМНС-д статистикийн жилийн эмхэтгэл, сарын мэдээний танилцуулга, тооллого, түүвэр судалгааны үр дүн, нийгэм, эдийн засаг, байгаль орчин зэрэг салбарын танилцуулгын үр дүнг байршуулж хэрэглэгчдийн хүртээл болгов.



Зураг 18. МЭДЭЭЛЭЛ ТАРХААЛТЫН СУВГУУД



Статистикийн мэдээллийн нэгдсэн санд 6 бүлгийн 60 дэд бүлгийн 859 үзүүлэлтийг нийтэлж, хэрэглэгчдэд тархааж байгаа бөгөөд 2025 онд хүн ам, нийгэм, эдийн засгийн 216 үзүүлэлтийг шинэчилсэн бүсээр болон аймаг, нийслэлээр задалж шинэчлэн тооцлоо (Хавсралт 3).

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдлын сарын танилцуулгыг тархах хэвлэлийн хурлыг сар бүр зохион байгуулж, мэдээлэл тархах хуваарийн дагуу Статистикийн мэдээллийн нэгдсэн санд байршуулж, хэрэглэгчдэд хүргэж байна. Мөн статистикийн 7 хоног, 15 хоног, сар, улирал, хагас жил, жилийн мэдээллийг Facebook, Viber, Telegram, LinkedIn, X, Instagram хуудсаар хэрэглэгчдэд мэдээллийг тархааж байна.

ҮСХ-ны лавлах утас, цахим шуудан, нийгмийн сүлжээний хуудсанд 2025 онд хэрэглэгчдээс нийт 2571 дуудлага, хүсэлт ирүүлсний 76.1 (1957) хувьд нь утсаар, 18.8 (484) хувьд нь цахим шуудангаар, 4.6 (118) хувьд нь нийгмийн сүлжээгээр хариу хүргүүлж, 0.5 (12) хувьд нь биечлэн шаардлагатай мэдээллээр үйлчилсэн байна.



**2**

**АРГА ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ,  
ЧАНАРЫН УДИРДЛАГА**

## 2.1 АРГА ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ

ҮСХ нь статистик мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хангах, тооцоолол, аргачлал, өгөгдлийн чанарт илэрсэн алдаа, зөрүүг засварлах, олон улсын стандарт, арга зүйтэй нийцүүлэх, улмаар статистикийн мэдээллийн ашиглалт, бодлого төлөвлөлтөд үзүүлэх ач холбогдлыг нэмэгдүүлэх зорилгоор дараах салбаруудын аргачлал, арга зүйг шинэчлэн тоо мэдээллийг засварлах, дахин тооцоолох ажлыг хийлээ.

### 1. Дотоодын нийт бүтээгдэхүүний хэлхээ индекс арга ашигласан зэрэгцүүлэх үнээрх тооцоо


Үндэсний тооцооны үндсэн үзүүлэлт болох бодит ДНБ-ий хэмжигдэхүүний мэдээллийн чанарыг сайжруулах үүднээс арга зүйн өөрчлөлтүүдийг нэвтрүүлж байна. ДНБ-ий биет хэмжээг “тогтмол” оны үнээр (2015 оны зэрэгцүүлэх суурь оны үнээр) үнэлж байсан бөгөөд 2025 онд шинээр хэлхээ индексийн арга зүйг нэвтрүүллээ.

Хэлхээ индексийн аргаар үйлдвэрлэлийн болон эцсийн ашиглалтын аргаарх ДНБ-ий 2019-2024 оны тооцооллыг хийсэн бөгөөд ДНБ-ийг хэлхээ суурь оноор тооцох ажил хоёр хэсгээс бүрдсэн. Үүнд:

- Оны үнийн тооцоо - зарим суурь судалгааны үр дүнг ашиглан шинэчилсэн.
- Зэрэгцүүлэх үнийн тооцоо - хэлхээ индексийн аргыг ашигласан.

Манай улс 2020-2024 онд Хөдөө аж ахуйн тооллого, судалгаа, Хүн ам, орон сууцны тооллого, Бичил уурхайн судалгааг хийж, үр дүнг тархаасан. Эдгээр тооллого, судалгааны үр дүнгээр холбогдох үзүүлэлтүүдийг тооцож, ДНБ-ийг 2019 оноос шинэчлэн тооцсон. ДНБ-ий шинэчилсэн тооцоогоор оны үнээрх 2024 оны ДНБ 2025 оны 8 дугаар сард тархаасан гүйцэтгэлтэй харьцуулахад дунджаар 0.7 хувиар нэмэгдсэн байна. ДНБ-ий 2019-2024 оны өөрчлөлт нь -0.1 хувиас 1.6 хувийн хооронд хэлбэлзэж байна.

 Зургаг 19. ДНБ-ий жилийн өөрчлөлтийн харьцуулалт



Тайлбар - \* шинэчилсэн гүйцэтгэл

Хэлхээ суурь онд шилжихтэй холбоотой арга зүй, хэлхээ индексийн тооцооны үр дүнг танилцуулах 2 удаагийн уулзалт, хэлэлцүүлгийг Төсвийн Тогтвортой Байдлын Зөвлөл, Монголбанк, Сангийн Яам, Эдийн Засаг, Хөгжлийн Яам, Санхүүгийн Зохицуулах Хороо, Татварын Ерөнхий Газар, Олон Улсын Валютын Сан, Дэлхийн Банк, Азийн Хөгжлийн Банк зэрэг байгууллагын төлөөллийг оролцуулан 2025 оны 6, 7 дугаар сард зохион байгуулсан.

“Дотоодын нийт бүтээгдэхүүнийг хэлхээ индекс ашиглан зэрэгцүүлэх үнээр тооцох аргачлал”-ыг боловсруулж, эдийн засгийн төв байгууллагуудад хүргүүлж, санал зөвлөмжийг авч сайжруулан 2025 оны 12 дугаар сард батлан мөрдөж байна.

## 2. Үйлдвэрлэгчийн үнийн индексийн шинэчилсэн тооцоо

Үйлдвэрлэгчийн үнийн индексийг 2015 оны суурьтай тооцож байсныг эдийн засгийн салбарын бүтцэд гарч буй өөрчлөлт, ДНБ-ийг хэлхээ индексийн аргаар тооцох суурь нөхцөлийг бүрдүүлэх, салбарын бодит өсөлтийн тооцоонд ашиглахад нийцүүлж 2024 оны сууриар шинэчлэн тооцлоо. Энэ хүрээнд аж үйлдвэр, тээвэр, мэдээлэл холбоо, зочид буудал, нийтийн хоол зэрэг салбарын үйлдвэрлэгчийн үнийн индексийн сагс, жинг шинэчилж, үр дүнг үндэсний тооцоонд ашиглахаас гадна хэрэглэгчдэд тархааж байна.

Үйлдвэрлэгчийн үнийн индексийн аргачлал, түүвэрлэлт болон тооцооллын чанарыг сайжруулах чиглэлээр олон улсын аргачлалыг судлахаас гадна Олон Улсын Валютын Сан, Дэлхийн Банк, НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын зөвлөхүүдтэй хамтран ажилласан. Зөвлөмжийн дагуу үйлдвэрлэгчийн үнийн тооцоонд ашиглах арга зүй, суурь он, сагс, жингийн мэдээллийг бүрэн шинэчилж, тооцооллын нарийвчлал нэмэгдсэн болно.



Хүснэгт 10. ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН САЛБАРУУДЫН ЖИНГИЙН ӨӨРЧЛӨЛТ

| Тээврийн салбар   | Жин             |                 |
|---|-----------------|-----------------|
|   | 2015=100        | 2024=100        |
| Ерөнхий индекс  | 100.00          | 100.00          |
| 49. Хуурай замын болон хий дамжуулах хоолойн тээвэрлэлт   | 60.25           | 68.17           |
| 50. Усан замын тээвэр   | 0.04            | 0.01            |
| 51. Агаарын тээвэр  | 34.27           | 9.97            |
| 52. Агуулахын болон тээврийн туслах үйл ажиллагаа   | 5.18            | 21.28           |
| 53. Шуудан, зарлага, элчийн үйл ажиллагаа   | 0.26            | 0.58            |
| <b>Мэдээлэл, холбооны салбар</b>  | <b>2015=100</b> | <b>2024=100</b> |
| Ерөнхий индекс  | 100.00          | 100.00          |
| 58. Эх бэлтгэх, нийтлэх үйл ажиллагаа   | 7.20            | 2.48            |
| 59. Кино, видео, телевизийн хөтөлбөрийн үйлдвэрлэл, бичлэг хийх болон хөгжим, ая зохиох үйл ажиллагаа | 2.37            | 3.10            |
| 60. Өргөн нэвтрүүлэг бэлтгэх, дамжуулах үйл ажиллагаа   | 3.96            | 16.88           |
| 61. Цахилгаан холбоо  | 84.37           | 52.95           |
| 62. Компьютер программчлал, зөвлөгөө болон түүнд холбогдох үйл ажиллагаа                              | 1.25            | 21.21           |
| 63. Мэдээллээр үйлчлэх үйл ажиллагаа  | 0.84            | 3.38            |
| <b>Аж үйлдвэрийн салбар</b>   | <b>2015=100</b> | <b>2024=100</b> |
| Ерөнхий индекс  | 100.00          | 100.00          |
| В. Уул уурхай олборлолт   | 77.95           | 65.70           |
| С. Боловсруулах үйлдвэрлэл  | 14.56           | 24.70           |
| Д. Цахилгаан, хий, уур, агааржуулалт  | 6.72            | 8.60            |
| Е. Ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа         | 0.78            | 1.01            |
| <b>Зочид буудал, байр, сууцаар үйлчлэх үйлчилгээний салбар</b>  | <b>2015=100</b> | <b>2024=100</b> |
| Ерөнхий индекс  | 100.00          | 100.00          |
| Нийслэл   | 87.94           | 82.33           |
| Аймаг   | 12.06           | 17.67           |
| <b>Нийтийн хоолны салбар</b>  | <b>2015=100</b> | <b>2024=100</b> |
| Ерөнхий индекс  | 100.00          | 100.00          |
| Нийслэл   | 87.55           | 80.93           |
| Аймаг   | 12.45           | 19.07           |

### 3. Олон хэмжээст ядуурлын индексийн аргачлал

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ), Оксфордын Ядуурал, хүний хөгжлийн санаачилга байгууллагын дэмжлэгтэйгээр Бүгд Найрамдах Солонгос Улсын Гадаад харилцааны яамны санхүүжилтээр Үндэстний олон хэмжээст ядуурлын индексийн туршилт тооцооллыг хийж, үр дүнг яам, төрийн байгууллага, эрдэмтэн судлаач нарт танилцуулав.

Олон хэмжээст ядуурлын индекс (ОХЯИ) нь мөнгөн бус хэмжигдэхүүнээр өрх, хүн амын ядуурлыг тодорхойлж, тэдэнд тулгарч буй гачигдлуудыг нарийвчлан ойлгох боломжийг олгодог цогц хэмжигдэхүүн бөгөөд эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр болон амьдрах орчны нөхцөлийг хамруулсан 15 үзүүлэлтээр Алкайр-Фостерийн арга зүйг ашиглан туршилт тооцооллыг хийлээ.

### 4. Хүний хөгжлийн индекс тооцох аргачлал

Хүний хөгжлийн индекс тооцох аргачлалыг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн "Хүний хөгжлийн тайлан 2023/2024: Техникийн тайлбар"-т тусгасан хүний хөгжлийн индекс тооцох аргачлалын дагуу өөрчлөн сайжруулж, 2015-2024 оны тооцоог шинэчилсэн аргачлалын дагуу дахин тооцож, өмнөх хугацааны цувааг засварласан.

### 5. Мал аж ахуйн тооцоо

Мал аж ахуйн салбарын нийт үйлдвэрлэл, нэмэгдэл өртгийн тооцоог сайжруулах ажлын хүрээнд малын ашиг шим, нэмүү өртгийн түүвэр судалгааг 2023, 2024 онуудад зохион байгуулсан. Судалгааны үр дүнгээр мал аж ахуй эрхэлдэг өрхийн нэмэгдэл өртөг, завсрын хэрэглээний бүтцийг шинэчлэх, малын гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэгчийн үнийг 2024 оноор цуглуулж, 2019-2024 оны үйлдвэрлэгчийн үнийг 2024 оны зэрэгцүүлэх үнээр шинэчилснээс гадна нэг малаас авах гарцын хэмжээг аймгаар тооцсон.

#### Засварласан үр дүнгээс:

- 2024 онд мал аж ахуйн салбарын нийт үйлдвэрлэл 7.0 их наяд төгрөг байсан бол шинэчилсэн тооцоогоор 5.8 их наяд төгрөг болж 18.5 хувиар буурсан. Энэхүү бууралтад сүүний үйлдвэрлэлд саальд хамрагдалтын түвшин буурсан, МАА эрхэлдэг өрхийн завсрын хэрэглээ буюу зардлын өсөлт голлон нөлөөлсөн. Харин уламжлалт аргаар бэлтгэсэн мах, арьс, шир, сүүн бүтээгдэхүүн боловсруулах салбарын нийт үйлдвэрлэл 3.3 их наяд байсан бол 4.9 их наяд төгрөг болж 48.7 хувиар өссөн. Энэхүү өсөлтөд махны үнийн өсөлт голлон нөлөөлсөн болно.
- Хөдөө аж ахуйн салбарын эдийн засагт эзлэх хувийг шинэчлэн тооцоход 2024 онд 7.3 хувиас 5.3 хувь болж буурч байгаа бол боловсруулах салбарын эзлэх хувь 6.6 хувиас 8.1 хувь болж өсөж байна.



Хүснэгт 11. ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ЭДИЙН ЗАСАГТ ЭЗЛЭХ ХУВЬ

| Салбар   | 2019  | 2020  | 2021  | 2022  | 2023  | 2024  |
|--|-------|-------|-------|-------|-------|-------|
|  | хувь  |       |       |       |       |       |
| Хуучин тооцоо, 2015 оны зэрэгцүүлэх үнийн тооцоогоор     |       |       |       |       |       |       |
| Дотоодын нийт бүтээгдэхүүн                               | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| Хөдөө аж ахуй  | 11.5  | 12.8  | 13.0  | 12.8  | 9.8   | 7.3   |
| Уул уурхай   | 25.8  | 24.1  | 25.4  | 23.6  | 28.7  | 27.9  |
| Боловсруулах   | 8.6   | 9.2   | 8.5   | 8.6   | 7.3   | 6.6   |
| Барилга, үйлдвэрлэлийн бусад                             | 6.5   | 6.9   | 6.2   | 6.0   | 5.6   | 5.9   |
| Үйлчилгээ  | 47.6  | 46.9  | 47.0  | 49.0  | 48.5  | 52.4  |
| Шинэчилсэн тооцоо, 2024 оны зэрэгцүүлэх үнийн тооцоогоор |       |       |       |       |       |       |
| Дотоодын нийт бүтээгдэхүүн                               | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| Хөдөө аж ахуй  | 8.2   | 9.2   | 9.5   | 9.2   | 7.0   | 5.3   |
| Уул уурхай   | 25.7  | 23.8  | 25.3  | 23.7  | 28.4  | 27.7  |
| Боловсруулах   | 11.0  | 12.4  | 10.8  | 10.6  | 9.9   | 8.1   |
| Барилга, үйлдвэрлэлийн бусад                             | 6.5   | 6.8   | 6.1   | 6.0   | 5.6   | 5.8   |
| Үйлчилгээ  | 48.7  | 47.8  | 48.3  | 50.5  | 49.2  | 53.2  |

## 6. Хөдөлмөрийн статистик

Хөдөлмөрийн статистик үзүүлэлтийн тооцооллын нарийвчлалыг сайжруулах болон түүврийн бус алдааг бууруулах зорилгоор ҮСХ нь Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ОУХБ)-тай хамтран түүврийн жингийн тооцоололд олон улсад өргөн хэрэглэгддэг "Calibration-Raking" арга зүйг 2024 онд нэвтрүүлсэн. Улмаар АХС-ны 2019-2024 оны улирал, жилийн хөдөлмөрийн статистикийн үзүүлэлтүүдийг 2025 онд шинэчлэн тооцож тархаасан.

## 7. Дундаж цалин

Дундаж цалингийн аргачлалыг 2024 онд Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагаас гаргасан аргачлалын дагуу шинэчлэн, сайжруулсан. Статистик мэдээллийг шуурхай, үнэн зөв гаргах зорилгоор Нийгмийн Даатгалын Ерөнхий Газрын нийгмийн даатгалын шимтгэл төлсөн аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын цалингийн мэдээллийн санг 2025 оноос эхлэн дундын серверт байршуулан тооцоолол хийж эхэллээ. Тус мэдээллийн санг ашиглан цалингийн статистикийг сарын дундаж нэрлэсэн цалин, голч цалин, үндсэн цалинг салбар, бүс, аймаг, байгууллагын төрөл зэрэг ангиллаар илүү нарийвчлан тооцож, үр дүнг хэрэглэгчдэд шуурхай хүргэх боломжийг бүрдүүллээ.

## 8. Орон сууцны үнэ, түрээсийн үнэ

2025 оны 8 дугаар сараас эхлэн зар мэдээллийн цахим хуудасны 3000-3500 зар мэдээллээс цахим хуудас шүүх аргаар орон сууцны үнэ, сарын түрээсийн дундаж үнийг Улаанбаатар хотын дүүргээр тооцож, сар бүр тархааж байна. Мөн энэхүү үзүүлэлтээ хэрэглээний үнийн мэдээнд ашиглан тооцооны хамралт, чанарыг сайжруулсан.

## 9. Бусад салбарын статистик мэдээний чанарыг сайжруулах арга хэмжээ

Эдийн засгийн салбарын мэдээний чанар, хамралтыг сайжруулах чиглэлээр Байр сууц, нийтийн хоол, тээвэр, холбоо, дотоод худалдааны салбаруудын сар, улирлын мэдээнд хамрагддаг ААНБ-ын тоо 2024 онд 24.9 мянга байсан бол 2025 онд 28.5 мянга болж 15 хувиар нэмэгдсэн. Үүнээс 27.2 мянган (79%) ААНБ-ын сар, улирлын борлуулалтын орлогын мэдээллийг Татварын Ерөнхий газрын нэмэгдсэн өртгийн албан татварын мэдээллийн сантай холбож мэдээлэл цуглуулалтын ачааллыг бууруулсан. Түүнчлэн, аж үйлдвэрийн салбарын сарын мэдээнд хамрагддаг ААНБ-ын үндсэн үзүүлэлтүүдийг Гадаад худалдааны мэдээллийн сан, НӨАТ-ын мэдээллийн сантай тулган, шалгалт тодруулга хийж, шаардлагатай засварыг хийж ажиллалаа.

## 2.2 ЧАНАРЫН УДИРДЛАГА

НҮБ-ын Чанарын баталгаажуулалтын үндэсний хүрээнд үндэслэн "Монгол Улсын албан ёсны статистикийн чанарын удирдлагын хүрээ, хэм хэмжээ"-г 2023 онд шинэчлэн баталсан. Энэхүү баримт бичиг нь Монгол Улсын албан ёсны статистикийн үйл ажиллагаанд чанарын удирдлагын тогтолцоо, олон улсын стандартыг нэвтрүүлэх зорилгоор удирдлагын манлайлал, статистикийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг хангах, тасралтгүй сайжруулахад чиглэгдэнэ.

Чанарын стандартад нийцсэн статистикийн мэдээллээр хэрэглэгчдийг хангахын тулд үйл ажиллагааг жил бүр сайжруулан ажиллаж байна. Өнгөрсөн онд статистикийн бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэв.

- НҮБ-ын чанарын баталгаажуулалтын шалгах хуудасны дагуу ҮСХ-оос мэдээлэл цуглуулж боловсруулдаг 65 статистикийн үйл ажиллагаанд анхны иж бүрэн өөрийн үнэлгээг НҮБ-ын АНДЭЗНХ-той хамтран хийлээ. Өөрийн үнэлгээг зохион байгуулснаар үйл ажиллагааны дутагдалтай талыг тодорхойлох, үнэлгээ хийж буй албан хаагчид эрхлэн гаргаж буй статистикийн мэдээллийн чанарт шүүмжлэлтэй хандах хандлагыг төлөвшүүлэх ач холбогдолтой юм.

## 2. АРГА ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ, ЧАНАРЫН УДИРДЛАГА

- Өөрийн үнэлгээний үр дүнгээс үйл ажиллагаанд тавигдах шаардлагаар нэгтгэсэн дундаж оноо доогуур, хэрэглэгчдийн эрэлт ихтэй, стратегийн ач холбогдол зэргийг харгалзан аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн индекс, үйлдвэрлэгчийн үнийн индекс нэгтгэн боловсруулах үйл ажиллагаанд гүнзгийрүүлсэн үнэлгээ хийж, сайжруулах зөвлөмж боловсруулав. Зөвлөмжийн дагуу эдгээр үйл ажиллагаа болон бусад үйл ажиллагааг үе шаттай сайжруулахаар төлөвлөн ажиллаж байна.
- Статистикийн мэдээллийг эрхлэн гаргах үйл ажиллагааны гүйцэтгэл, чанарыг хугацааны явцад хянах, үнэлэх, давуу болон сул талыг тодорхойлох, чанарыг сайжруулах арга хэмжээг төлөвлөхөд ашиглагддаг дотоодын чухал хэрэгслийн нэг нь үйлдвэрлэгчид зориулсан чанарын тайлан юм. Энэхүү тайлан боловсруулах гар ажиллагааг багасгах зорилгоор НҮБ-ын АНДЭЗНК-ын зөвлөмжийн дагуу (<https://gsbpm.app.nso.mn/>) өгөгдлийн санг туршилтаар байгуулж, 61 үйлдвэрлэгчид зориулсан чанарын тайланг оруулаад байна. 2026 онд сан болон чанарын тайланг илүү боловсронгуй болгоно.



### Хүснэгт 12. СТАТИСТИКИЙН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛД 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

| № | Зарчим                               | Шаардлага   | Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа  |
|---|--------------------------------------|---|---|
| 1 | Хэрэглэгчийн хэрэгцээнд нийцсэн байх | <ul style="list-style-type: none"> <li>• Хэрэглэгчидтэй зөвлөлдөх</li> <li>• Шинэ хэрэгцээг тодорхойлох</li> <li>• Хэрэгцээг эрэмбэлэх</li> <li>• Нийгмийн мэдээллийн хэрэгцээнд нийцүүлэх</li> <li>• Сэтгэл ханамжийг судлах</li> </ul>                                      | <ul style="list-style-type: none"> <li>• Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг жил бүр зохион байгуулж хэвшсэн.</li> <li>• 2025 онд хүн ам, нийгэм, эдийн засгийн 216 үзүүлэлтийг шинэчилсэн бүсээр задалж шинэчлэн тооцлоо.</li> <li>• Уламжлалт бус мэдээллийн эх үүсвэр ашиглаж туршилт судалгаа явуулав. (гар утас, сансрын зураг, НӨАТ-ын баримт, цахим хуудасны өгөгдөл зэрэг)</li> </ul>   |
| 2 | Бодитой, найдвартай байх             | <ul style="list-style-type: none"> <li>• Эх үүсвэр, завсрын, эцсийн үр дүнг тогтмол хянах</li> <li>• Түүврийн болон түүврийн бус алдааг тооцох, баримтжуулах</li> <li>• Шинэчлэлт, өөрчлөлт, залруулгад тогтмол дүн шинжилгээ хийх</li> </ul>                                 | <ul style="list-style-type: none"> <li>• Статистикийн мэдээллийн эх үүсвэрийг тогтмол хянаж боломжит эх үүсвэрийг ашиглахаар ажиллаж байна. Тухайлбал орон сууцны үнэ, түрээсийн үнэ зэргийг веб цахим хуудас шүүх аргыг ашиглаж цуглуулж эхэлснээр төсөв хэмнэх чухал ач холбогдолтой байв. Завсрын болон эцсийн бүтээгдэхүүний хяналтыг тогтсон хяналтын хуваарийн дагуу хянан баталгаажуулж хэвшсэн.</li> <li>• Үйлдвэрлэгчийн үнийн статистикийн чанарыг мэдээлэл цуглуулах үйл ажиллагаа, тооцох арга зүйг шинэчлэн сайжруулсан.</li> <li>• Түүврийн алдааг жил бүр тооцож тархааж хэвшсэн.</li> <li>• Статистикийн үзүүлэлт, аргачлалыг олон улсын стандартад нийцүүлэх ажлын хүрээнд 2025 онд 3 аргачлал, 1 ангилал, 7 тооллого, судалгааны үзэл баримтлал, асуулга, нөхөх заавар, 7 мэдээний маягт, нөхөх заавар, 3 гарын авлага, заавар нийт 21 арга зүйн баримт бичгийг шинээр болон шинэчлэн боловсруулж, баталсан.</li> </ul> |
| 3 | Шуурхай, цаг хугацаандаа байх        | <ul style="list-style-type: none"> <li>• Шуурхай байдал нь ОУ-ын стандартад нийцэх</li> <li>• Мэдээлэл цуглуулах хугацааг тархаалттай уялдуулах</li> <li>• Хүлээн зөвшөөрөгдсөн тохиолдолд урьдчилсан үр дүнг зарлах</li> <li>• Графикт хугацаандаа тархаасан эсэх</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>• Зарим салбарын мэдээг сараар тооцож тархааж эхлэв. (Эдийн засгийн өсөлт, тээвэр, холбоо, байр сууцаар хангах, нийтийн хоолны салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс, барилга байгууламжийн өртгийн индекс)</li> <li>• Статистикийн мэдээллийг тархаах хуваарийн дагуу тархаасан мэдээ 90 хувийг эзэлж байна.</li> </ul>  |

| № | Зарчим                         | Шаардлага   | Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа  |
|---|--------------------------------|---|---|
| 4 | Хүртээмжтэй, ил тод байх       | <ul style="list-style-type: none"> <li>Зөв тайлбарлах</li> <li>Харьцуулалт хийхэд хялбар танилцуулах</li> <li>Тархаах стратеги нь ил тод байх</li> <li>Статистикийн мэдээллийг хялбар олж авах боломж</li> <li>Задгай өгөгдөл ашиглуулах</li> <li>Хэрэглэгчийн мэдлэг боловсролыг тогтмол дээшлүүлэх</li> <li>Хэрэглэгчийн асуултад тухай бүр хариулах</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>Статистикийн мэдээллийн нэгдсэн санд 6 бүлгийн 60 дэд бүлгийн 859 үзүүлэлтийг гаргаж, мета өгөгдлийн хамт хэрэглэгчдэд тархааж байна.</li> <li>Жил бүр тархаах хуваарийг баталж Статистикийн мэдээллийн нэгдсэн санд байршуулж хэвшсэн.</li> <li>Статистикийн мэдээллийн нэгдсэн сангийн системийн шинэчлэлтийн үр дүнд статистик мэдээллийг хайж олоход хялбар, ойлгомжтой байдлаар харах боломжтой болсон.</li> <li>Тооллогын 10 хувь, түүвэр судалгааны бүх задгай өгөгдлийн нууцлалыг хангаж нэгдсэн санд байршуулж хэвшсэн</li> <li>Хэрэглэгчдэд зориулж цахим сургалтын систем хөгжүүлэв.</li> <li>Хэрэглэгчийн асуулт, санал хүсэлтэд тогтмол хариу өгч ажиллаж байна. (лавлах утасны 1843 дуудлага, information@nso.mn цахим шууданд ирсэн 604 зурвас, пэйж хуудаст ирсэн 251 зурвас)</li> </ul> |
| 5 | Нийцтэй, харьцуулагдахуйц байх | <ul style="list-style-type: none"> <li>Статистикийн мэдээллийн ойлголт, тодорхойлолт, нэгж, хувьсагч, ангилалд олон улсын стандарт ашиглах</li> <li>Салбар хооронд уялдуулах, нийцтэй байдлыг хянах</li> <li>Статистикийн мэдээллийг газар зүйн байршлаар харьцуулах боломжтой байх</li> </ul>  | <ul style="list-style-type: none"> <li>Төрийн 11 байгууллагын 13 мэдээллийн санд оролтын чанарын үнэлгээг 63 шалгуур үзүүлэлтийн дагуу зохион байгуулав. Энэхүү үнэлгээ нь өгөгдлийн бүрэн байдал, цаг хугацаанд нь шинэчлэгддэг байдал, нарийвчлал, нийцтэй байдал, хүртээмж, мета өгөгдөл зэрэг чанарын үндсэн хэмжээсийг хамарсан.</li> <li>Төв, орон нутгийн нэгжийн хийсэн хагас болон бүтэн жилийн мэдээний баримтжуулалт, уялдааг хангах үзүүлэлтийг нэгтгэж дүн шинжилгээ хийж, холбогдох статистикийн үр дүнд сайжруулах ажлыг жил бүр зохион байгуулан ажиллаж байна</li> </ul>   |
| 6 | Мета өгөгдлийг бүрдүүлсэн байх | <ul style="list-style-type: none"> <li>Мета өгөгдлийн удирдлагын тогтолцоо</li> <li>Мета өгөгдлийг Олон Улсын стандартын дагуу архивлах</li> <li>Мета өгөгдлийн талаар албан хаагчдыг сургах хөтөлбөр хэрэгжүүлэх</li> </ul>  | <ul style="list-style-type: none"> <li>Төрийн 43 байгууллагатай хамтран 116 өгөгдлийн сан, 657 хүснэгт, 10703 үзүүлэлт, статистикийн мэдээний 41 маягтын мета мэдээллийг Төрийн мета өгөгдлийн нэгдсэн сан (metadata.nso.mn)-д оруулаад байна.</li> </ul>   |

### Статистикийн бүтээгдэхүүн үйлчилгээний чанарт өгсөн хэрэглэгчдийн үнэлгээ

ҮСХ нь статистик мэдээллийн чанарыг үнэлэх, хүртээмжийг сайжруулах, хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлага, цаашдын чиг хандлагыг тодорхойлох зорилгоор "Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа"-г жил бүр зохион байгуулдаг. 2025 онд статистик мэдээллийн чанарыг хэрэглэгчдийн 14.3 хувь нь "маш сайн", 52.1 хувь нь "сайн", 28.6 хувь нь "дунд", 3.1 хувь нь "муу", 1.9 хувь нь "маш муу" гэж үнэлсэн байна. Хэрэглэгчдийн дийлэнх нь статистик мэдээллийн чанарыг "сайн", "маш сайн" гэж 2025 онд үнэлсэн бол 2026 онд 27.5 хувь нь "маш сайн", 35.4 хувь нь "сайн", 28.4 хувь нь "дунд", 6.5 хувь нь "муу", 2.2 хувь нь "маш муу" гэж үнэлжээ.



Хүснэгт 13. СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН ЧАНАРТ ӨГСӨН ҮНЭЛГЭЭ, чанарын үзүүлэлтээр, маш сайн, сайн үнэлгээний нийт дүнд эзлэх хувиар

| № | Чанарын үзүүлэлт                         | 2025     |      |      |     |         | 2026     |      |      |     |         |
|---|--|----------|------|------|-----|---------|----------|------|------|-----|---------|
|   |  | Маш сайн | Сайн | Дунд | Муу | Маш муу | Маш сайн | Сайн | Дунд | Муу | Маш муу |
| 1 | Чанарт өгсөн ерөнхий үнэлгээ             | 14.3     | 52.1 | 28.6 | 3.1 | 1.9     | 27.5     | 35.4 | 28.4 | 6.5 | 2.2     |
| 2 | Мэдээллийн шуурхай, цаг үеэ олсон байдал | 10.3     | 49.1 | 31.8 | 2.2 | 1.1     | 12.1     | 47.7 | 31.9 | 3   | 1       |
| 3 | Тоон мэдээллийн бүрэн гүйцэд байдал      | 10.1     | 48.1 | 31.2 | 3.1 | 1.1     | 11.2     | 46.7 | 32   | 4   | 1.1     |
| 4 | Харьцуулахад боломжтой эсэх              | 10.1     | 47   | 32   | 2.9 | 0.9     | 10.9     | 45.8 | 32.2 | 3.3 | 1       |
| 5 | Мэдээллийн ил тод байдал                 | 11.4     | 47.6 | 30.2 | 4   | 1.2     | 13.2     | 45.9 | 30.7 | 3.9 | 1.3     |
| 6 | Мэдээлэл авахад ойлгомжтой эсэх          | 12.1     | 48.8 | 30.2 | 3.2 | 0.9     | 12.8     | 46.2 | 32.1 | 4   | 1       |
| 7 | Тоон мэдээллийн бодитой байдал           | 9.6      | 46   | 32.3 | 3.4 | 1.2     | 11.3     | 44.2 | 33.1 | 4.4 | 1.2     |

Хэрэглэгчээс статистикийн мэдээллийн чанар, тархаалт, мэдээ мэдээллийн давтамжтай холбоотой 387 хэрэглэгч санал, хүсэлт ирүүлснийг нэгтгэн дүгнэхэд:

#### Статистик мэдээллийн тархаалт:

- Ил тод, хүртээмжтэй байдал: Эдийн засаг, хөдөө аж ахуй, нийгмийн статистик зэрэг салбарын мэдээллийг илүү нарийвчилж, тогтмол шинэчилж, нээлттэй, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх, мета өгөгдлийг сайжруулах
- Цаг хугацааны хоцрогдолгүй байдал: Мэдээллийн хэрэгцээ ихтэй салбарын хувьд нарийн дүн шинжилгээ хийх боломжийг олгохын тулд өгөгдлийг нарийвчилсан задаргаатай тогтмол шинэчилж байх, мөн хуваарьт хугацаандаа мэдээллээ тархааж байх

#### Мэдээ тархаалтын суваг:

- Статистикийн мэдээллийн нэгдсэн сан ([www.1212.mn](http://www.1212.mn))-гийн цахим хуудсыг сайжруулах: Хэрэглэгч мэдээлэл олж авахад гардаг хүндрэл, бэрхшээлийг бууруулахын тулд мэдээллийн санг ашиглахад илүү ойлгомжтой байдлаар загварчлах, мэдээллийн санг хэрэглэх заавар бичлэг, цахим гарын авлага бэлтгэж тархаах
- Цахим платформын хэрэглээ: Гол үзүүлэлтээр статистик мэдээллийг инфографик, дүрс бичлэг байдлаар тогтмол гаргаж, нийгмийн сүлжээ, мэдээллийн цахим хуудсуудаар тархаах

#### Дотоод ба гадаад үйл ажиллагаа:

- Албан тушаалтнуудад зориулсан сургалт: Албан хаагчдыг чадавхжуулах, мэдлэгийг дээшлүүлэх сургалт тогтмол зохион байгуулах
- Олон нийтэд зориулсан сургалт: Цахим хуудас ашиглах заавар бичлэг, гарын авлага бэлтгэн тархааж, статистикийн мэдээлэл хэрэглэгчдийн мэдээлэл хүлээн авах байдлыг хялбарчлах, цаашлаад статистик мэдээллийн ач холбогдол, бодлого боловсруулахад гүйцэтгэх үүргийн талаарх иргэдийн мэдлэгийг дээшлүүлэхийн тулд танхимын, зайн сургалт явуулах, статистик мэдээллийн ач холбогдлыг таниулан сурталчлах

- Олон нийтийн санал хүсэлтийг хүлээн авах: Статистикийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахын тулд эрдэмтэн, судлаачид, олон нийтийн санал хүсэлтийг тогтмол хүлээн авч, цаашдын үйл ажиллагаанд тусгах

### Олон улсын үнэлгээ

Нээлттэй мэдээллийн цаг (ODIN) олон улсын ашгийн бус байгууллагаас улс орнуудын статистикийн байгууллагуудын мэдээллийн хамрах хүрээ, нээлттэй байдалд хийсэн 2024 оны үнэлгээгээр Монгол Улс хамрах хүрээ үзүүлэлтээр дэлхийд 12 дугаар байр, Зүүн Азийн бүс нутагт 2 дугаар байр, нээлттэй байдлын үзүүлэлтээр дэлхийд 15 дугаар байр, Зүүн Азийн бүс нутагт 2 дугаар байр, нэгдсэн дүнгээр дэлхийд 11 дүгээр байр, Зүүн Азийн бүс нутагт 2 дугаар байр эзэлсэн.

Open Data Watch байгууллагын 2024 оны үнэлгээний нээлттэй мэдээлэл болон хамрах хүрээний үнэлгээнд Статистикийн мэдээллийн нэгдсэн сангийн аргачлал, тодорхойлолт хэсгийг дутуу үнэлснийг тус байгууллагад цахим шуудангаар мэдэгдсэн бөгөөд цаашид энэхүү сангийн хэвийн, найдвартай ажиллагааг тогтмол хянаж, статистикийн мэдээллийн нээлттэй, хүртээмжтэй байдлыг сайжруулах төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Дэлхийн Банкнаас Статистикийн гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийн үнэлгээ (SPI)-г өгөгдлийн хэрэглээ, өгөгдлийн үйлчилгээ, өгөгдлийн бүтээгдэхүүн, өгөгдлийн эх үүсвэр, өгөгдлийн дэд бүтэц гэсэн 5 дэд бүлгийн хүрээнд хийдэг. Манай улсын хувьд 2024 оны үнэлгээгээр 83.87 оноогоор дэлхийд 47 дугаар байрт эрэмбэлэгдсэн. Үүнд: Өгөгдлийн хэрэглээ 90, өгөгдлийн үйлчилгээ 96, өгөгдлийн бүтээгдэхүүн 80, өгөгдлийн эх сурвалж 81, өгөгдлийн дэд бүтэц 70 оноог тус тус авсан.




Зураг 20. МЭДЭЭЛЛИЙН НЭЭЛТТЭЙ ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ, 2024

Зүүн Азийн бүсэд II байр

Дэлхийд XI байр







**3**

**ӨГӨГДЛИЙН  
ЭКОСИСТЕМ**

Бид Монгол Улсын статистикийн салбарыг 2026-2030 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөөнд “Тогтолцоо, хамтын ажиллагааг бэхжүүлэх” зорилгын хүрээнд “Өгөгдлийн засаглалыг сайжруулах” зорилт тусгасан. Тус зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнд: Өгөгдлийн засаглалын бодлого, дүрэм, стандартыг боловсруулах; Өгөгдлийн нөмчлөл, өгөгдлийн урсгалын удирдлага, хариуцлагын загвар (Data Stewardship Model)-ыг нэвтрүүлэх; Өгөгдлийн нууцлал, хандалтын эрхийн удирдлага, өгөгдөл солилцох эрх зүйн зохицуулалтыг сайжруулах зэрэг ажлууд багтсан. Өгөгдлийн засаглалыг бүрдүүлэх үйл ажиллагааны хүрээнд ҮСХ нь 2026 онд өгөгдлийн засаглалын бодлогын төслийг боловсруулж, хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

 **Зураг 21. ӨГӨГДЛИЙН ЭКОСИСТЕМ ИЙН ЗУРАГЛАЛ**




### 3.1 АНГИЛАЛ, СТАНДАРТ

Статистикийн мэдээ, тооллого, судалгааны мэдээллийг нэгтгэж, боловсруулахад 2025 оны байдлаар УСХ-оос баталж, зөвшөөрсөн 14 ангиллыг мөрдөж байгаа бөгөөд өнгөрсөн онд 2 ангиллыг шинэчлэн боловсруулсан. Үүнд:

1. Гэмт хэргийн статистикийг сайжруулах хүрээнд НҮБ-ын Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газрын судалгаанд хамрагдсан 292 үзүүлэлтээс 192 буюу 65.8 хувь нь үндэсний түвшинд мэдээлэлгүй байгааг тогтоож, уг зөрүүг арилгах зорилгоор гэмт хэргийн статистикийн үндэсний ангиллыг боловсруулж, баталсан.
2. Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллын олон улсын шинэчилсэн ангиллын 4, 5 дугаар хувилбаруудыг харьцуулж, шинэчлэлт, өөрчлөлтийг тодорхойлж, ангиллыг боловсруулсан.

Бараа, бүтээгдэхүүний бүртгэлийн нэгдсэн хяналтын систем (data.ebarimt.mn)-д 2050 бараа бүтээгдэхүүнийг бүтээгдэхүүний нэгдсэн ангиллаар кодолж, баталгаажуулсан.

 **Зураг 22. БАРАА БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН СИСТЕМ**



Бангууллаас ирсэн хүсэлт

- Хүтэглэж байгаа: 292
- Зөвшөөрсөн: 108
- Татгалзсан: 1314
- Баталгаажсан: 7168

| №  | Бараа        | Бүтээгдэхүүний нэр     | Классификаци | Классификаци | Хувиар гаргасны нэр | ҮН-Төлөвлөгөөний дүрмээ | Дэлгэр баяа үнэ | С-гийн код            | Хэргийн ажил        | Дараагч гаргасан | Хувиартай төлөв |
|----|--------------|------------------------|--------------|--------------|---------------------|-------------------------|-----------------|-----------------------|---------------------|------------------|-----------------|
| 1  | 652235451199 | Hyundai Tucson 2019    | 310          | HT           | Тээвэр              | 7223275                 | 2886450         | skhataa@gmail.com     | 2025-05-28 15:17:48 | HT               | Тогтвортой      |
| 2  | 50124050945  | Beats Solo3 wireless   | 700          | HT           | Бүтэцтэй            | 643153                  | 8910407         | fulltime regional.com | 2025-03-24 10:43:33 | HT               | Тогтвортой      |
| 3  | 1992626      | Монгол гудамж тасар    | 4            | HT           | Цэвэрлэх            | 7180795                 | 4096019         | hummelkorea@gmail.com | 2025-02-24 10:53:54 | HT               | Тогтвортой      |
| 4  | 1090400      | Монгол гудамж тасар    | 4            | HT           | Цэвэрлэх            | 7180795                 | 4096019         | hummelkorea@gmail.com | 2025-02-24 10:25:28 | HT               | Тогтвортой      |
| 5  | 430100009405 | Vanessa 3-дугаар сэд   | 0.75         | HT           | Тээвэр              | 2545420                 | 9006400         | khataa_380@yahoo.com  | 2025-02-24 10:55:30 | HT               | Тогтвортой      |
| 6  | 430100000030 | Chaitanya 3-дугаар сэд | 0.75         | HT           | Тээвэр              | 2545420                 | 9006400         | khataa_380@yahoo.com  | 2025-02-24 10:50:14 | HT               | Тогтвортой      |
| 7  | 430100001156 | Schibumna 3-дугаар сэд | 0.75         | HT           | Тээвэр              | 2545420                 | 9006400         | khataa_380@yahoo.com  | 2025-02-24 10:49:28 | HT               | Тогтвортой      |
| 8  | 430100000000 | Schibumna 3-дугаар сэд | 0.75         | HT           | Тээвэр              | 2545420                 | 9006400         | khataa_380@yahoo.com  | 2025-02-24 10:48:44 | HT               | Тогтвортой      |
| 9  | 430100000040 | Schibumna 3-дугаар сэд | 0.75         | HT           | Тээвэр              | 2545420                 | 9006400         | khataa_380@yahoo.com  | 2025-02-24 10:47:51 | HT               | Тогтвортой      |
| 10 | 430100000001 | Schibumna 3-дугаар сэд | 0.75         | HT           | Тээвэр              | 2545420                 | 9006400         | khataa_380@yahoo.com  | 2025-02-24 10:47:08 | HT               | Тогтвортой      |
| 11 | 430100000000 | Schibumna 3-дугаар сэд | 0.75         | HT           | Тээвэр              | 2545420                 | 9006400         | khataa_380@yahoo.com  | 2025-02-24 10:46:01 | HT               | Тогтвортой      |
| 12 | 430100000000 | Schibumna 3-дугаар сэд | 0.75         | HT           | Тээвэр              | 2545420                 | 9006400         | khataa_380@yahoo.com  | 2025-02-24 10:45:08 | HT               | Тогтвортой      |
| 13 | 430100000000 | Schibumna 3-дугаар сэд | 0.75         | HT           | Тээвэр              | 2545420                 | 9006400         | khataa_380@yahoo.com  | 2025-02-24 10:43:44 | HT               | Тогтвортой      |
| 14 | 430100000000 | Vanessa 3-дугаар сэд   | 0.75         | HT           | Тээвэр              | 2545420                 | 9006400         | khataa_380@yahoo.com  | 2025-02-24 10:42:33 | HT               | Тогтвортой      |
| 15 | 430100000000 | Vanessa 3-дугаар сэд   | 0.75         | HT           | Тээвэр              | 2545420                 | 9006400         | khataa_380@yahoo.com  | 2025-02-24 10:42:09 | HT               | Тогтвортой      |
| 16 | 430100000000 | Vanessa 3-дугаар сэд   | 0.75         | HT           | Тээвэр              | 2545420                 | 9006400         | khataa_380@yahoo.com  | 2025-02-24 10:41:08 | HT               | Тогтвортой      |
| 17 | 430100000000 | Vanessa 3-дугаар сэд   | 0.75         | HT           | Тээвэр              | 2545420                 | 9006400         | khataa_380@yahoo.com  | 2025-02-24 10:40:07 | HT               | Тогтвортой      |
| 18 | 430100000000 | Vanessa 3-дугаар сэд   | 0.75         | HT           | Тээвэр              | 2545420                 | 9006400         | khataa_380@yahoo.com  | 2025-02-24 10:35:57 | HT               | Тогтвортой      |
| 19 | 430100000000 | Chaitanya 3-дугаар сэд | 0.75         | HT           | Тээвэр              | 2545420                 | 9006400         | khataa_380@yahoo.com  | 2025-02-24 00:34:14 | HT               | Тогтвортой      |


Статистикийн үзүүлэлт, аргачлалыг олон улсын ангилал, аргачлал, стандартын жишигт нийцүүлэн гаргаж, мөрдүүлэх хүрээнд “Статистикийн мэдээллийн маягт, нөхөх заавар”-ын стандартыг шинэчилж боловсруулсан.

### 3.2 МЕТА ӨГӨГДӨЛ

#### Төрийн мета өгөгдлийн нэгдсэн сангийн мэдээллийн бүрдүүлэлт

Монгол Улсын төрийн мета өгөгдлийн нэгдсэн сан нь төрийн байгууллагуудын өгөгдлийн сангийн мета мэдээллийг нэг стандарт, цахим талбарт төвлөрүүлэн бүртгэх, хадгалах, түгээх систем юм.

 **Зураг 23. ТӨРИЙН МЕТА ӨГӨГДЛИЙН НЭГДСЭН САН**



Энэхүү системд төрийн байгууллагуудын өгөгдлийн сангийн мета мэдээллийг оруулж, тухай бүр шинэчлэх, үүний үр дүнд төрийн байгууллагуудын цуглуулж буй үзүүлэлт, ангиллын уялдаа холбоо, давхардлыг тодорхойлох нөхцөл бүрдэнэ.


Энэ хүрээнд ҮСХ нь ЦХИХХЯ, төрийн байгууллагуудтай хамтран 2025 онд төрийн 30 байгууллагын 50 албан хаагчид зориулсан сургалт, уулзалтыг зохион байгуулж, мета өгөгдлийг ашиглах, шинэчлэх, хяналт хийх чадавхыг бэхжүүлсэн. Мөн төрийн 43 байгууллагатай хамтран 116 өгөгдлийн сан, 657 хүснэгт, 10703 үзүүлэлт, статистикийн мэдээний 41 маягтын мета мэдээллийг төрийн мета өгөгдлийн нэгдсэн санд оруулсан байна.

**Төрийн мета өгөгдлийн нэгдсэн сангийн үнэлгээ**

ҮСХ нь төрийн мета өгөгдлийн нэгдсэн санд нийт 43 байгууллагын 136 өгөгдлийн сан бүртгэлтэй байгаагаас мэдээллээ бүрэн оруулж, ҮСХ-оос баталгаажуулсан 31 байгууллагын 65 өгөгдлийн сангийн мета өгөгдөлд иж бүрдэл, чанар, уялдаа холбооны үнэлгээг хийлээ.

Эдгээрийн 49.0 хувь нь өөрийн серверт өгөгдлөө хадгалж, 70.0 хувь нь өгөгдлийн сангийн удирдлагадаа MSSQL, MySQL, PostgreSQL зэрэг системүүдийг ашиглаж байна.

 **Зураг 24. ӨГӨГДЛИЙН САНГИЙН УДИРДЛАГЫН СИСТЕМИЙН ТӨРӨЛ**



Үнэлгээнд хамрагдсан 65 өгөгдлийн санд 561 хүснэгтийн мета өгөгдөл тусгагдсан ба 9287 үзүүлэлттэй, эдгээрийн 1142 нь ангилал кодтой байна.

Үзүүлэлтийн мета өгөгдлийн давхардлыг шалгахад үзүүлэлтийн нэр давхардсан 960 үзүүлэлт байгаа бөгөөд нэршил оновчгүй, тодорхойлолт бүрэн бус, уялдаагүй байна. Тухайлбал, аймаг, нийслэлийг аймаг, аймаг/ хот, хаягийн аймаг гэх мэт, хүний нэрийг, иргэний нэр, даатгуулагчийн нэр, өөрийн нэр, бүтэн нэр гэх мэтээр нэрлэсэн байна.

Ангилал, кодын мета өгөгдлийн уялдааг шалгахад нийт 1142 үзүүлэлт ангилал, кодтой гэж бүртгэгдсэнээс батлагдсан 500 ангилал, кодыг ашиглаж байна. Эдгээр ангилал, кодыг 16 байгууллага баталсан бөгөөд үүнээс Стандарт, хэмжил зүйн газар хамгийн их буюу 262 үзүүлэлтийн ангилал, код баталсан байна. Батлагдсан ангилал, кодоос хамгийн их буюу 10-аас дээш ашиглагдсан ангилал, кодуудыг харьцуулахад дараах ангилал, кодын код болон тодорхойлолтууд нь буруу бичигдсэн эсвэл код зөрүүтэй байна.



**Хүснэгт 14. ХАМГИЙН ИХ БУЮУ 10-ААС ДЭЭШ ДАВХАРДСАН АНГИЛАЛ, КОДЫН ЖАГСААЛТ**

| № | Ангилал, кодын нэр              | Давхардсан тоо |
|---|---------------------------------|----------------|
| 1 | Аймаг, нийслэл                  | 45             |
| 2 | Сум, дүүрэг                     | 42             |
| 3 | Хүйс                            | 21             |
| 4 | ICD10 өвчний олон улсын ангилал | 20             |
| 5 | Боловсролын түвшин              | 17             |
| 6 | Ажил, мэргэжлийн ангилал        | 15             |
| 7 | Баг, хороо                      | 11             |

Мэдээлэл хариуцагч байгууллагуудын мета өгөгдлийн талаарх ойлголт, хариуцлага хангалтгүй байгаа бөгөөд цаашид мета өгөгдлийн чанар, ашиглалтыг сайжруулах шаардлагатай байна.

Бүрдүүлсэн өгөгдлийн сангийн бүрдэл, хамралт нь хангалттай сайн бүрдсэн байна. Харин байгууллага доторх сангуудын уялдаа сайн хэдий ч төрийн байгууллагууд хоорондын сангуудын уялдаа хангалтгүй байна. Цаашид дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Үүнд:


- Мета өгөгдлийн мэдээллийг сайжруулах, мэдээлэл хоорондын уялдааг хангах;
- Бичвэрийн зөрүүтэй байдлын уялдуулах, үзүүлэлт, ангиллын давхардлыг тодорхойлох боломжийг бүрдүүлэх;
- Ангилал, кодын батлагдсан байдлыг нягталж, баримт материалыг хавсаргах;
- Мэдээлэл хариуцагч байгууллагуудын мета өгөгдлийн талаарх ойлголтыг сайжруулах, хариуцлагыг нэмэгдүүлэх;
- Суурь болон төрөлжсөн мэдээллийн сангийн бүртгэлийн системтэй нэгтгэх.

### Төрийн байгууллагуудын суурь болон төрөлжсөн мэдээллийн сангийн үнэлгээ

Хүн ам, орон сууцны завсрын тооллогод ашиглах төрийн байгууллагуудын суурь болон төрөлжсөн мэдээллийн санг тодорхойлж, чанарын үнэлгээ хийж, мэдээллийг нэгтгэх технологи, дэд бүтцийн орчныг бүрдүүлэн ажилласан. Үүнд дараах үндсэн үйл ажиллагаанууд багтсан:



Зураг 25. ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН



- 1. Өгөгдлийн чанарын үнэлгээ:** Төрийн 11 байгууллагын 13 мэдээллийн санд оролтын чанарын үнэлгээг олон улсын сайн туршлагад нийцүүлэн боловсруулсан 63 шалгуур үзүүлэлтийн дагуу хийсэн. Энэхүү үнэлгээ нь өгөгдлийн бүрэн байдал, цаг хугацаанд нь шинэчлэгддэг байдал, нарийвчлал, нийцтэй байдал, хүртээмж, мета өгөгдөл зэрэг чанарын үндсэн хэмжээсүүдийг хамарсан. Үнэлгээний үр дүнгээр мэдээллийн сангуудын дийлэнх нь "Сайн" (3.0-4.0) үнэлгээ авсан нь тооллогод ашиглахад тохиромжтойг харуулж байгаа ч зарим мэдээллийн сангийн өгөгдлийн хүртээмж, стандарттай нийцэх байдал, харилцан уялдааг сайжруулах шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан.
- 2. Хууль эрх зүйн зохицуулалт.** Төрийн байгууллагуудын суурь болон төрөлжсөн мэдээллийн сангаас тооллогын өгөгдөл бүрдүүлэх эрх зүйн үндсийг тодорхой болгох зорилгоор Засгийн газрын 2025 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 260 дугаар тогтоолыг гаргуулсан. Тус тогтоолоор төрийн байгууллагууд Хүн ам, орон сууцны тооллогод шаардлагатай суурь болон төрөлжсөн мэдээллийн сангийн өгөгдлийг хууль тогтоомжийн хүрээнд төрийн мэдээлэл солилцооны үндсэн системээр дамжуулан Үндэсний Статистикийн Хороонд тухай бүр нийлүүлэх үүрэг хүлээсэн. Энэ нь өгөгдөл солилцооны тогтвортой, зохион байгуулалттай механизмыг бүрдүүлсэн.
- 3. Өгөгдөл цуглуулах.** Тооллогын зорилгоор төрийн 14 байгууллагын суурь болон төрөлжсөн мэдээллийн сангаас "ХҮР" төрийн мэдээлэл солилцооны нэгдсэн системээр дамжуулан иргэдийн холбогдох өгөгдлийг хүлээн авсан. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн дагуу E-Mongolia төрийн цахим үйлчилгээний нэгдсэн системээр дамжуулан мэдээллийг нь тооллогын зорилгоор ашигласан талаарх мэдэгдлийг мэдээллийн эзэнд хүргүүлсэн.
- 4. Өгөгдөл боловсруулах.** Төрийн байгууллагуудаас хүлээн авсан олон эх сурвалжийн өгөгдлийг нэгтгэх, цэвэрлэх, стандартчилах, тооллогын хувьсагчдыг үүсгэх бүх үе шатыг ETL (Extract-Transform-Load) хэрэгсэл ашиглан автоматжуулсан. Автоматжуулснаар өгөгдөл боловсруулах хугацааг богиносгох, хүний оролцооны алдааг бууруулах, тооллогын үр дүнг богино хугацаанд гаргах боломжийг бүрдүүлсэн.

### 3.3 ТӨРИЙН НЭГДСЭН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ХӨГЖҮҮЛЭЛТ

Төрийн байгууллагууд өөрсдөө системээр дамжуулан мэдээллийн эзнийг таних боломжгүй болгох системийг sha-256, reverse, vowel, abbreviation, replace digits аргуудыг ашиглан "И-Монгол академи" Улсын төсөвт үйлдвэрийн газраас хөгжүүлж, турших орчин, виртуал машиныг үүсгэж, туршсан.


Хүн ам, орон сууцны тооллого, Аж ахуйн нэгжийн тооллогод суурилсан нэгдсэн өгөгдлийн санг үүсгэж, ашиглахад бэлэн болгосон.

### 3. ӨГӨГДЛИЙН ЭКОСИСТЕМ

Суурь болон төрөлжсөн мэдээллийн сангийн чанарыг үнэлэх хүрээнд мэдээллийн эх үүсвэрийн үнэлгээний чанарын хэмжүүр, түүнд хамаарах асуулгын хуудас, арга зүйг боловсруулж, мэдээллийн сангийн чанарын өгөгдлийн үнэлгээний гарын авлагыг боловсрууллаа.

Захиргааны өгөгдлийг ашиглан өгөгдлийн чанарыг үнэлэх аргачлалын төслийг боловсруулах хүрээнд ӨНЭЗС, АХС-ны өгөгдлийг төрийн байгууллагын өгөгдлийн сантай холбогдох үзүүлэлтүүдийн чанарыг шалгах ажлыг эхлүүлж, АХС, ӨНЭЗС-ны 2025 оны эхний 2 улирлын мэдээллийг ХАОСЗТ-ын хүрээнд авсан төрийн байгууллагуудын өгөгдөлтэй холбож, харьцуулалт хийж, үр дүнг боловсруулсан.


 **Зураг 26. АНХАН ШАТНЫ ӨГӨГДЛИЙН ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ, холболтын төрөл, эх үүсвэрээр**




### Төрөлжсөн бүртгэлийн нэгдсэн сангийн хөгжүүлэлт

Төрийн байгууллагуудын мэдээллийн сангийн ил тод байдал, уялдаа холбоо, ашиглалт сайжруулах хүрээнд Төрөлжсөн бүртгэлийн нэгдсэн санг байгуулах, хөгжүүлэхэд ЦХИХХЯ-нд дэмжлэг үзүүлж ажиллалаа.

Системийн бүтэц, зохион байгуулалт, хэвийн үйл ажиллагааг хангах саналыг боловсруулж, "Төрийн мета өгөгдлийн нэгдсэн сан"-д бүртгэгдсэн 116 өгөгдлийн сангийн бүртгэл, түүний мета өгөгдлийг системд оруулахад бэлтгэсэн.

 **Зураг 27. ТӨРӨЛЖСӨН БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН СИСТЕМ**



### 3.4 МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ТАСРАЛТГҮЙ АЖИЛЛАГАА

Үндэсний Статистикийн Хороо нь Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо (МАБМТ)-ны ISO 27001:2022 олон улсын стандартыг нэвтрүүлэх ажлыг 2024 оноос эхлүүлж, эхний шатны шаардлагуудыг бүрэн ханган анхан шатны баталгаажуулалтын гэрчилгээг авсан. 2025 онд МАБМТ-г хэрэгжүүлэх, мэдээллийн аюулгүй байдлын хэвийн болон тасралтгүй үйл ажиллагааг хангах, сайжруулах зорилтын хүрээнд дотоод аудитыг хагас жил тутам хийж, МАБМТ-ны хэрэгжилт болон аюулгүй байдлын хяналтын үр нөлөөг үнэлсэн. Мөн хяналт шалгалтыг улирал бүр хийж, стандартын хэрэгжилт, мэдээллийн аюулгүй байдлын түвшин болон эрсдэлийн удирдлагын байдлыг үнэлж, шаардлагатай сайжруулалтыг хийж ажиллалаа.

Мэдээллийн нууцлалыг хамгаалах, байгууллагын нууц болон ангилагдсан мэдээллийн хөрөнгийг хамгаалах хүрээнд нууц мэдээлэлтэй ажиллах "Өгөгдлийн дата лаб"-ын орчныг үүсгэн 20 зохиомол серверийг үүсгэн ажиллаж байна. МАБ-ын эрсдэлийг тодорхойлох, илрүүлэх систем, эмзэг мэдээлэл болон төгсгөлийн төхөөрөмжийн өгөгдлийн урсгалыг хянах DLP систем, нөөцлөлтийн системүүдийг нэвтрүүлэн ашиглаж байна.

Мэдээллийн аюулгүй байдлын тоног төхөөрөмж (галт хана болон цахим хуудасны галт хана, Fortitoken, Tenable Nessus Expert, Solarwinds, Zecurion DLP, онлайн системүүдийн ssl сертификат) бусад программ хангамжийн (MSDN, Office 365, Kaspersky End Point, Tableau, Package manager, ETL, Stata 18, Vmix, Болорсофт Kimo, Болорсофт Алдаа шалгагч программ) лицензийг сунгаж ажилласан.

Тагнуулын Ерөнхий Газрын Мэдээллийн аюулгүй байдлын газраар МАБ-ын эрсдэлийн үнэлгээ хийлгэж, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч ажиллалаа.

Байгууллагын аюулгүй байдлын төхөөрөмжүүдэд өдөрт дунджаар 100-200 ширхэг халдлагын төлөвтэй хандалтыг илрүүлэн лог бүртгэгдэж эрсдэлийн түвшнээс шалтгаалан хянах, хаах гэх мэт хариу арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна.

Мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдал, хүртээмжийг хангах чиглэлээр холбогдох бодлого, журмыг шинэчилж эхэлсэн бөгөөд батлагдан мөрдөгдөж буй 24 баримт бичгээс 20 баримт бичгийн заалт, давхардал, агуулгыг хянаж сайжруулан, стандартын хөндлөнгийн аудитын зөвлөмжид туссан анхаарах хэсгийн дагуу "Төсөл, хөтөлбөр өөрчлөлтийн удирдлагын журам"-д шаардлагатай өөрчлөлтийг оруулан шинэчлэн батлуулсан.

Эдгээр ажлын үр дүнд 2025 онд хөндлөнгийн магадлах аудитаар баталгаажуулалтын гэрчилгээг амжилттай шинэчлэн сунгуулж, МАБМТ-ны хэрэгжилтийг олон улсын шаардлагын дагуу тогтвортой, тасралтгүй ханган ажиллаж байна.

 **Зураг 28. ҮСХ-НЫ МАБ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗУРАГЛАЛ**





**4**

**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ШИНЭЧЛЭЛ,  
ЦАХИМЖИЛТ**


Статистикийн салбарын 2021-2025 оны стратеги төлөвлөгөөний “Дэд бүтцийг сайжруулах” зорилтын хүрээнд мэдээллийн технологийн дэд бүтцийг бэхжүүлж, мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн.

### 4.1 МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ, ДЭД БҮТЭЦ


Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, статистикийн зорилгоор цуглуулсан тооллого, судалгааны өгөгдөл болон төрийн байгууллагуудын өгөгдлийн мэдээллийн эзнийг тодорхойлох боломжгүй болгосон орчинд статистик боловсруулалт, дүн шинжилгээ хийх боломжийг бүрдүүлэн өгөгдөлтэй ажиллах 20 хэрэглэгчтэй дотоод сүлжээ бүхий өгөгдлийн лабораторийн сүлжээ, серверийн зохион байгуулалтыг хийж үйл ажиллагаанд нэвтрүүлээ. Үүнийг Хүн ам, орон сууцны завсрын тооллогын мэдээлэл боловсруулалтад ашигласан.



Зураг 29. ДАТАЛАБЫН АЖИЛЛАХ ЗАРЧИМ



| Name       | State   | CPU Usage | Assigned Memory | Options      | Status |
|------------|---------|-----------|-----------------|--------------|--------|
| Datalab-01 | Running | 0%        | 184.32 MB       | 88 01 14 40  |        |
| Datalab-02 | Running | 0%        | 225.28 MB       | 310 04 29 06 |        |
| Datalab-03 | Running | 0%        | 436.00 MB       | 3 22 53 09   |        |
| Datalab-04 | Running | 0%        | 184.32 MB       | 25 05 02 11  |        |
| Datalab-05 | Running | 0%        | 184.32 MB       | 63 00 18 36  |        |
| Datalab-06 | Running | 0%        | 184.32 MB       | 131 15 06 48 |        |
| Datalab-07 | Running | 0%        | 184.32 MB       | 134 05 37 38 |        |
| Datalab-08 | Running | 0%        | 32 760 MB       | 88 21 14 23  |        |
| Datalab-09 | Running | 0%        | 184.32 MB       | 162 05 00 09 |        |
| Datalab-10 | Running | 0%        | 184.32 MB       | 134 05 46 16 |        |
| Datalab-11 | Running | 0%        | 184.32 MB       | 20 04 05 29  |        |
| Datalab-12 | Running | 0%        | 184.32 MB       | 134 05 36 59 |        |
| Datalab-13 | Running | 0%        | 225.28 MB       | 74 16 59 49  |        |
| Datalab-14 | Running | 0%        | 32 768 MB       | 32 06 53 17  |        |
| Datalab-15 | Running | 0%        | 184.32 MB       | 73 01 39 38  |        |
| Datalab-16 | Running | 0%        | 204.00 MB       | 72 23 59 46  |        |
| Datalab-17 | Running | 0%        | 184.32 MB       | 131 15 32 10 |        |
| Datalab-18 | Running | 0%        | 184.32 MB       | 13 22 14 43  |        |
| Datalab-19 | Running | 0%        | 184.32 MB       | 164 04 52 06 |        |
| Datalab-20 | Running | 0%        | 184.32 MB       | 130 19 40 03 |        |



Мэдээллийн сангийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор 2025 онд 6 ширхэг сервер компьютер нэмж авснаар сервер компьютерийн нийт хүчин чадал 300.22 ТБ багтаамж, 3264 ГБ санах ойтой болон өргөжсөн байна.

2025 онд төсвийн хөрөнгө оруулалтаар 1 нөөцлөлтийн сервер, 1 сервер компьютер, 2 хамгаалалтын төхөөрөмж буюу галт хана, мөн төслийн хөрөнгө оруулалтаар 4 сервер компьютерийг тус тус худалдан авч серверийн хүчин чадал, тоног төхөөрөмжийн сайжруулалт хийсэн. Мөн 2 цаг тог барих хүчин чадал бүхий Easy UPS 2 ширхэг тог баригчийг худалдан авч суурилуулалт, тохиргоог бүрэн хийж, ашиглалтад оруулсан. Ингэснээр ҮСХ-ны байранд цахилгаан тасрах, доголдох үед серверийн өрөөний тоног төхөөрөмжүүдийн хэвийн үйл ажиллагааг 2 цаг хангах боломжтой болсон.



Хүснэгт 15. АШИГЛАЖ БАЙГАА СИСТЕМҮҮД

| Нэр                   | Тоо ширэг | Тайлбар  |
|-----------------------|-----------|--|
| Microsoft 365         | 400       | Ажлын хэрэглээний программ хангамж   |
| Kaspersky EP          | 500       | Хэрэглэгчийн компьютерт зориулсан халдлага, болон вирусээс хамгаалсан программ хангамж |
| DLP                   | 120       | Дата алдагдахаас сэргийлэх программ  |
| Tenable Nessus Expert | 1         | Сүлжээ, системийн эмзэг байдлыг илрүүлэх программ                                      |
| SolarWinds            | 1         | Сүлжээ, системийн хяналт, мониторингийн систем   |
| MSDN subscription     | 1         | Майкрософтын багц бүтээгдэхүүн   |
| FortiToken            | 50        | Алсын зайнаас хандалтыг давхар танин баталгаажуулах                                    |

### Мэдээллийн сан, нөөцлөлт

Мэдээллийн сан, нөөцлөлтийн хувьд 2025 оны жилийн эцсийн байдлаар ҮСХ-ны бүх системүүдийн мэдээллийн сан 4.2ТВ байна. Энэ нь өмнөх жилээс 11.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Системүүдийн мэдээллийн санг тухайн мэдээний мэдээлэл цуглуулах давтамжаас хамаарч нөөцөлж байгаа бөгөөд ХАӨМС, БРС, Мал тооллогын мэдээллийн санг жилийн эцэст нэг удаа нөөцлөлтийг хийж байна. ҮСХ-ны системүүдийн мэдээллийн сангийн нөөцлөлтийг 2 байршилд авч байгаа бөгөөд ҮСХ-ны нөөцлөлтийн серверт 10ТВ, Үндэсний дата төв УТҮГ-н нөөцлөлтийн серверт 6.4ТВ өгөгдөл нөөцлөөд байна.

## 4.2 СТАТИСТИКИЙН МЭДЭЭНИЙ СИСТЕМ

Албан ёсны статистикийн 7 хоног, сар, улирал, хагас жил, жилийн мэдээг батлагдсан хуваарийн дагуу цуглуулах, тархаахад программ хангамжийн хэвийн найдвартай, ажиллагааг хангаж, орчин үеийн технологийн шийдлийг нэвтрүүлж, Статистикийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн систем (SPS)-ээс Мэдээний нэгдсэн систем (medee.app.nso.mn)-рүү бүх мэдээний программуудыг бүрэн шилжүүллээ.

Үүний үр дүнд аж ахуйн нэгж байгууллагууд өөрөө бүртгэл үүсгэх, бүртгэлтэй цахим шуудангаа өөрчилж шинэчлэх, мэдээгээ шивэх, салбарынхаа статистик дашбоард болон салбартаа эзлэх байр суурь гэх мэт статистик мэдээллийг авах боломжийг бүрдүүлсэн.




Зураг 30. СТАТИСТИКИЙН МЭДЭЭНИЙ СИСТЕМИЙН ДАШБОАРД




### 1. Түүвэр судалгааны цахим хяналтын систем


ҮСХ-оос зохион байгуулж буй судалгаануудад хяналт, мониторингийн системийг нэвтрүүлэх ажлыг 2023 оноос эхлүүлсэн. Энэхүү цахим хяналтын систем нь тухайн судалгааны түүвэрт сонгогдсон өрхөд мэдээлэл цуглуулагч очиж судалгаа авсан эсэхийг судалгаа авсан байршлын цэг (GPS)-ийн мэдээллээр хянах, тухайн өрхийн судалгааг хэдий хугацаанд авсан, ямар асуулт дээр хамгийн их, хамгийн бага хугацаа зарцуулсан зэрэг мэдээллүүдэд шинжилгээ хийх боломж бүрдсэн. Уг систем нэвтэрснээр судалгааны мэдээлэл цуглуулагч тус бүрээр ажлын гүйцэтгэлийг богино хугацаанд хянах, шаардлагатай засвар, тодруулгыг хугацаа алдалгүй хийх боломж бүрдсэн. Мөн судлаачийн аюулгүй байдал, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд зөвхөн судалгааны тээврийн хэрэгслийн ашиглалтыг хянах системийг нэвтрүүлсэн.

 **Зураг 31. СУДАЛГААНЫ ЦАХИМ ХЯНАЛТЫН СИСТЕМ**



Мөн АХС, ӨНЭЭС-ны мэдээлэл цуглуулалтын явцыг хянах, богино хугацаанд мэдээлэл цуглуулагчийн түвшинд хянах өндөр давтамжтай чанарын хяналтын дашбоардыг Python, Tableau программ ашиглан боловсруулж, нэвтрүүлсэн.

 **Зураг 32. ӨНЭЭС БОЛОН АХС-НЫ ДАШБОАРД**




## 2. Хүн ам, орон сууцны завсрын тооллогын программ хөгжүүлэлт

Хүн ам, орон сууцны 2025 оны завсрын тооллогын хүрээнд биечлэн тодруулга болон өрхийн гишүүн тодруулгын программ (zd.2025.mn), утсан тодруулгын программ (todruulga.2025.mn), Монгол Улсад оршин суугаа иргэдийн цахим тодруулгын программ (www.2025.mn), гадаад улсад оршин суугаа Монгол Улсын иргэдийн бүртгэлийн программ (citizen.2025.mn) зэрэг программуудыг хөгжүүлэн мэдээллийг амжилттай цуглуулсан.



Зураг 33. ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ ЗАВСРЫН ТООЛЛОГЫН ПРОГРАММ



## 3. Мал тооллогыг сайжруулах, боловсронгуй болгох

ҮСХ-оос мал тооллогыг цахим бүртгэлд шилжүүлэх, мэдээллийг хянах, баталгаажуулахад ашиглах дүрс бичлэгийг боловсруулах, нисгэгчгүй нисэх төхөөрөмж ашиглах, тооллогын үр дүнг уялдуулах, хянахад хиймэл дагуул, сансрын зургийн мэдээлэл ашиглах боломжийг турших зэрэг ажлуудыг 2023 оноос үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд 2025 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

### а. Мал тооллогод хиймэл дагуул, сансрын зураг ашиглах чиглэлээр:

Тооллогын мэдээллийг хянах, уялдуулан шалгахад хиймэл дагуулын мэдээлэл, сансрын зураг ашиглах боломжийг тогтоох, малын төрлийг таниулах, малчдын байршлыг тогтоох, ялгах боломжит үзүүлэлтийг тодорхойлох туршилтыг Архангай аймагт 2024 онд XXI зууны хөгжлийн төлөөх статистикийн түншлэл байгууллага (ПАРИС21)-ын дэмжлэгтэйгээр хийж, үр дүнг гаргав.

Өндөр нарийвчлалтай (30 см) хиймэл дагуулын зураг ашигласан тохиолдолд бод малыг таних нарийвчлалын түвшин 81.63 хувьтай гарсан, харин бог малыг хиймэл дагуулын зургаас ялгах боломжгүй гэж дүгнэсэн. Энэ үр дүнд үндэслэн мал тооллогын хяналтад сансрын зураг ашиглахад өндөр нарийвчлалтай сансрын зураг худалдан авч, нэгтгэхэд зардал өндөр байна. Харин өрхийн байршил, гэр сууцыг танихад нарийвчлалын түвшин 98.11 хувь байсан нь цаашид байшин, орон сууцны тооллогод сансрын зураг ашиглах боломжтой гэж дүгнэсэн.



Зураг 34. 30 CM-ЫН НАРИЙВЧЛАЛТАЙ ЗУРАГЛАЛД ГЭР ТАНИУЛСАН БАЙДАЛ, сумын төв, хөдөөгийн байршлаар



**б. Мал тооллогыг цахимжуулах чиглэлээр:**

“Мал тооллогын мэдээллийн сан”-г ХХААХҮЯ-ны “Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сан”-гийн мэдээлэлтэй уялдуулан шалгах, хянаж, тулгах, зөрүүг арилгах, хөтлөлтийг сайжруулах ажлыг 2023 оноос эхлүүлсэн. Энэ ажлын хүрээд 2023 оны жилийн эцсийн мал тооллогын мэдээллийг ашиглан хоёр сангийн мэдээллийг харьцуулж, зөрүү, түүний шалтгаан, хүндрэл бэрхшээлийг тодорхойлж, хөтлөлтийг сайжруулах санал, зөвлөмжийг яаманд хүргүүлж, 2024-2025 онд сангийн хөтлөлт, бүртгэлийн чанарыг сайжруулах, ажилтнуудын мэдлэг, чадавхыг нэмэгдүүлэх сургалт зохион байгуулах, программ хангамжийг шинэчлэх зэрэг арга хэмжээг авч, хамтран ажилласан.


2024 оны мал, тэжээвэр амьтан, хашаа худгийн тооллогын үеэр сонгогдсон өрхүүдэд бэлчээрт байгаа мал болон малчны хотонд байгаа малын бичлэгийг дронеор хийж бичлэгүүдийг зураг болгон таван хошуу малаар лэйбэл үүсгэн хиймэл оюун ухааны моделийг сурган турших ажлыг хийсэн. Туршилтын модельд үндэслэсэн AI-д суурилсан аппликэйшныг 2025 оны мал, тэжээвэр амьтан, хашаа худгийн тооллогоор амжилттай туршиж мэдээллийг цуглуулсан.

**в. Мал тооллогод шинэ технологи машин сургалт, хиймэл оюуныг нэвтрүүлэх чиглэлээр:**

ҮСХ, аймаг, сум, дүүрэг, хорооны тооллогын ажлын хэсэг, статистикийн хэлтэс, газраас 2024 оны мал тооллогын мэдээлэл цуглуулалтын явцад 4500 орчим, 2025 оны хагас жилийн түүвэр судалгаагаар 1500 орчим мал тоолж байгаа видео бичлэгийг цуглуулсан. 2025 онд нийт 5568 бичлэгээс 116.2 мянган зурагт бог малыг, 20.0 мянган бод малын (тэмээнээс бусад) зургийг малын төрлөөр ялган тэмдэглэж, машин сургалтын туршилтын программыг хөгжүүлсэн. Мал тооллогын явцад малыг төрлөөр ялган тоолох туршилтын аппликэйшныг хөгжүүлэн, 2025 оны мал тооллогын хяналтад ашигласан. Цаашид тус машин сургалтын алгоритмыг сайжруулж, малын төрлийг таних чадварыг нэмэгдүүлэх, гар утасны аппликэйшныг интернэтгүй орчинд ажиллах боломжийг нэвтрүүлэх ажлыг 2026 онд хэрэгжүүлнэ.



Зураг 35. МАЛ ТООЛЛОГЫН AI АППЛИКЕЙШН




### 4.3 СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН


Статистикийн мэдээллийг эрхлэн гаргах ажиллагааг боловсронгуй болгох зорилтын хүрээнд тооллого, судалгааны мэдээлэл цуглуулах, үр дүнг нэгтгэх 24 программыг шинээр хөгжүүлж, 24 программд шаардлагатай засвар өөрчлөлтийг хийж шинэчиллээ (Хавсралт 8).

Статистикийн мэдээллийн нэгдсэн сан (www.1212.mn)-гийн 2012 оноос ашиглаж байсан суурь технологийг Европын статистикийн байгууллагуудын ашиглаж буй PXWeb нээлттэй эх сурвалжийн платформуор шинэчлэн хөгжүүлж, үйл ажиллагаандаа ашиглаж эхэллээ.

Систем шинэчлэлийн үр дүнд хэрэглэгчид статистик мэдээллийг хайхад хялбар, ойлгомжтой байдлаар харах боломжтой болсон бөгөөд статистик мэдээлэл, хайлтын үр дүнг харуулах хурд өмнөх хувилбараас 50 дахин нэмэгдсэн.

Мөн Статистикийн мэдээллийн нэгдсэн сангийн шинэчлэлтийн хүрээнд бүх хүснэгтийг PXWeb систем рүү хөрвүүлэн нээлттэй сервис API-ийг ашиглан хиймэл оюунд суурилсан “Эгүнэ” үндэсний үлэмж хэлний загвар дээр сургаж, MonStatGPT чатботыг хөгжүүлж нэвтрүүлсэн. Энэхүү хиймэл оюунт чатботын гол давуу тал нь хэрэглэгчийн асуултад хиймэл оюуны алгоритмаар статистикийн их өгөгдлөөс хайлт хийж хэрэглэгчийн хүссэн тоон мэдээллийг богино хугацаанд олж хариулах юм.

 Зураг 36. СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГИЙН ШИНЭЧЛЭЛ





**5**

**ОЛОН УЛСЫН  
ХАМТЫН  
АЖИЛЛАГАА**

## 5. ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Үндэсний Статистикийн Хороо нь Статистикийн салбарын 2021-2025 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж түүний дотор статистикийн системийн болон салбарын чадавхыг бэхжүүлэхэд гадаад харилцаа, хамтын ажиллагааг чиглүүлж ажиллаа. Энэ хүрээнд 2025 онд олон улсын болон улс орнуудын статистикийн байгууллагуудтай хамтран 10 төсөл хөтөлбөр хэрэгжүүлж, 30 гаруй уулзалт зохион байгууллаа.

### Зургаг 37. ХАМТЫН АЖИЛЛАГААТАЙ БАЙГУУЛЛАГУУД

Олон талт хамтын ажиллагаа



Хоёр талтай хамтын ажиллагаа



### 5.1 ОЛОН ТАЛТ ХАМТЫН АЖИЛЛАГАА

НҮБ-ын Статистикийн комиссын 56 дугаар чуулганаар хэлэлцэж, мэдээлэх 32 асуудалд санал бэлтгэн НҮБ-ын Статистикийн хэлтэст хүргүүлж, чуулганы үеэр олон улсын 8 байгууллага болон, бусад улс орны статистикийн 8 байгууллагатай хоёр талт уулзалт зохион байгуулсан.

2025 оны байдлаар ҮСХ-ны албан хаагчид олон улсын 10 байгууллагын 12 ажлын хэсэг, шинжээчдийн бүлгийн гишүүнээр ажиллаж байгаа бөгөөд 2025 онд НҮБ-ын Статистикийн хэлтсийн Чанарын баталгааны үндэсний хүрээний мэргэжилтнүүдийн бүлэг, НҮБ-ын Хүн амын сан, Эмэгтэйчүүдийн байгууллагын санаачлан хэрэгжүүлж буй "Технологи ашиглан үйлдэгдэж буй эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг хэмжих нь" бүсийн техникийн ажлын хэсэг, НҮБ-ын Эмэгтэйчүүдийн байгууллагын "Байгаль орчин, эдийн засгийн дансны системийг хэрэгжүүлэх" мэргэшсэн бүлэг, НҮБ-ын АНДЭЗНК-ын Өгөгдөл, статистикийн хэтийн төлөв багийн ажлын хэсэг, ПАРИС21 байгууллагын Хиймэл оюуны ажлын хэсгийн гишүүнээр тус тус шинээр элсэн ажиллаж байна.

Мөн "21 дүгээр зууны Хөгжлийн Төлөөх Статистикийн Түншлэл" байгууллага (ПАРИС21)-тай хиймэл оюуны чиглэлээр хамтран ажиллах хүсэлт хүргүүлсний дагуу "Үндэсний статистикийн системийн хиймэл оюуны бэлэн байдлыг бэхжүүлэх нь" төслийг хэрэгжүүлэх таван улсын нэгээр Монгол Улс сонгогдлоо.

НҮБ-ын Ази, Номхон далайн орнуудын Эдийн засаг, Нийгмийн комиссын 81 дүгээр чуулганы үеэр зохион байгуулагдсан НҮБ-ын Ази, Номхон далайн орнуудын статистикийн институтын Удирдах зөвлөлийн гишүүний сонгуульд Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо оролцож, гишүүнээр сонгогдлоо.

ҮСХ-оос 2025 онд олон улсын хэмжээнд зохион байгуулагдсан нийт 57 удаагийн сургалт, арга хэмжээнд давхардсан тоогоор 182 албан хаагч оролцож, илтгэл танилцуулж, туршлагаа хуваалцаж ажилласан байна.

**Азийн Хөгжлийн Банк:** АХБ-ны техникийн туслалцааны "57028-001:Уур амьсгалын өөрчлөлтийг дэвшилтэт статистикаар дэмжих нь" төслийн хүрээнд үндэсний тооцоо, БОЭЗДС-ийн чиглэл, түүнчлэн АХБ-аас ажилласан зөвлөхүүдтэй БОЭЗДС-ийн газрын бүрхэвчийн данс болон усны данс байгуулах ажлын хүрээнд хамтран ажиллаж, цаашдын чиглэлийг хэлэлцэв. Мөн тус төслийн хүрээнд Статистикийн бизнес бүртгэлийг боловсронгуй болгох чиглэлээр бизнес регистрийн мэдээллийн сангийн программ хангамжийг хөгжүүлэхэд хамтран ажиллаа.

**Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ази, Номхон далайн орнуудын Эдийн засаг, Нийгмийн комисс:** ҮСХ, НҮБ-ын АНДОЭЗНК-ын Статистикийн хэлтэстэй хамтран "Үндэсний өгөгдлийн хүч" санаачилгын нээлт болон "Өгөгдлийн хүч" төслийн нээлтийн хэлэлцүүлгийг Улаанбаатар хотноо зохион байгуулав.

АНДОЭЗНК-ын Статистикийн хэлтэстэй "НҮБ-ын Чанарын баталгаажуулалтын үндэсний хүрээ" баримт бичгийн дагуу ҮСХ-ны статистикийн бүх арга ажиллагаанд цогц өөрийн үнэлгээ, зарим салбарт гүнзгийрүүлсэн үнэлгээ хийж, албан ёсны статистикийн чанарыг хангах стратегийг тодорхойлж авлаа.

**ПАРИС21:** ПАРИС21 байгууллага, Дэлхийн банк болон Google Foundation-ийн дэмжлэгтэйгээр "Үндэсний статистикийн системийн хиймэл оюуны бэлэн байдлыг бэхжүүлэх нь" төслийн нээлтийг Улаанбаатар хотод зохион байгуулж, төслийг хэрэгжүүлж эхэллээ.

**НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр:** НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр болон Оксфордын их сургуулийн "Ядуурал хүний хөгжлийн санаачилга"-ын Эдийн засгийн судалгааны төвтэй хамтран "Үндэсний олон хэмжээт ядуурлын индекс" тооцох арга зүйг боловсруулж, туршилт тооцоо хийлээ.

**НҮБ-ын Хүүхдийн сан:** НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр "НҮТС нэмэх" судалгаа, Ардчилсан засаглал судалгаа, Ажиллах хүчний судалгааны мэдээллийг утсаар цуглуулах туршилт судалгаа, Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны хүнсний мэдээлэл цуглуулалтын арга зүйг үнэлэх параллель судалгааг зохион байгуулав.

**НҮБ-ын Эмэгтэйчүүдийн байгууллага:** НҮБ-ын Эмэгтэйчүүдийн байгууллагатай хамтран "Захиргааны мэдээллийн санд чанарын үнэлгээ хийх арга зүй"-н асуудлаар өгөгдлийн чанарын үнэлгээ хийх сургалтыг ҮСХ-нд зохион байгуулж, үр дүнд үндэслэн "Суурь болон төрөлжсөн мэдээллийн сангийн мэдээллийн чанарын үнэлгээ"-ний эх үүсвэрийн үнэлгээний тайлан, дүрмийг сайжруулсан.

**Дэлхийн банк:** Дэлхийн банкны техникийн туслалцаатайгаар "Өөрчлөлт шинэчлэлд гар утасны өгөгдлийг ашиглах нь: Монгол Улсад нотолгоонд суурилсан бодлого боловсруулах чадавхыг бэхжүүлэх нь" төслийн эхний шатны үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлж, хоёр дахь шатны үйл ажиллагааг эхлүүлж, гар утасны өгөгдлийг албан ёсны статистикийн мэдээллийг эрхлэн гаргахад туршилтаар ашиглаж эхлэв.

**Бусад:** Ази, Номхон далайн орнуудын Иргэний бүртгэл, хүн амын ердийн хөдөлгөөний статистикийн мэдээллийн асуудлаарх Сайд нарын түвшний гуравдугаар хуралд Норвегийн Хаант Улсын Засгийн газрын санхүүжилтээр ҮСХ-ны төлөөлөгч илтгэл тавьж оролцлоо.

Мөн ҮСХ нь Монгол Улс дахь олон улсын байгууллагууд, дипломат төлөөлөгчийн газруудад Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдлыг танилцуулж, мэдээлэл өгч хамтран ажиллаж байна.

## 5.2 ХОЁР ТАЛТ ХАМТЫН АЖИЛЛАГАА


**Австралийн Статистикийн товчоо:** 2025 онд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд ҮСХ-ны дэд дарга тэргүүтэй төлөөлөгчид түүврийн арга зүйн асуудлаар 2025 оны 5 дугаар сарын 7-оос 9-ний өдрүүдэд Австралийн Статистикийн товчоонд айлчилж, туршлага солилцлоо.

**БНСУ-ын Өгөгдөл, статистикийн яам:** БНСУ-ын Хөгжлийн албан ёсны тусламжаар хэрэгжүүлж буй “Монгол Улсын статистикийн чадавхыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд захиргааны мэдээллийн нэгдсэн удирдлагын системийг хөгжүүлж, төрийн байгууллагуудын захиргааны өгөгдлийг нэгтгэж, давхардлыг арилгах, автоматжуулсан байдлаар өгөгдөл дамжуулж, мэдээлэл боловсруулах хугацааг богиносгох, өгөгдлийг стандартчилж, баталгаажуулах замаар статистикийн мэдээллийн чанарыг дээшлүүлэх, мета өгөгдлийн стандартыг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх үндэс суурийг тавилаа.

**БНХАУ-ын Үндэсний статистикийн товчоо:** БНХАУ-ын Үндэсний статистикийн товчооны дэд комиссараар ахлуулсан төлөөлөгчдийг ҮСХ-нд хүлээн авав. Мөн 2026 онд БНХАУ-д “Хөдөө аж ахуйн статистикийг сайжруулах”, Монгол Улсад “Зайнаас тандан судлах аргыг газар тариалангийн статистикт ашиглах нь” сэдэвт сургалтуудыг зохион байгуулахаар тохиролцлоо. БНХАУ дахь НҮБ-ын Их өгөгдлийн төвтэй хамтын ажиллагааг эхлүүлж, Төв аймгийн зайнаас тандан судлах арга зүйн тодруулга мэдээллийг хүргүүлж, санхүүжилтийн асуудлыг тодорхой болгохоор ажиллаж байна.

**БНПУ-ын Статистикийн газар:** Бүгд Найрамдах Польш Улсын статистикийн газартай байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд туршлага судлах цахим уулзалтуудыг амжилттай зохион байгууллаа. Энэ хүрээнд “Хүний нөөцийг сайжруулах үйл ажиллагаа”, “Хүн амын тооллогыг тодорхойлох нь” (бүртгэл ба хүн амын тооллого, хүн амын тооллогын чанарыг хэмжих, хүн амын тооллогын мэдээллийг нэгтгэх), “Эрсдэлийн удирдлага, дотоод аудит” сэдвээр туршлага судлах цахим уулзалтыг тус тус зохион байгуулж давхардсан тоогоор ҮСХ-ны 24 албан хаагч хамрагдав.

**Норвегийн Статистикийн байгууллага:** Норвегийн статистикийн байгууллагатай Бүртгэлд суурилсан хүн ам, орон сууцны тооллогын талаар туршлага судлах уулзалтыг 3 удаа зохион байгуулж, холбогдох газрын нэгжийн мэргэжилтнүүд оролцож, туршлага судалж ажиллалаа.



6


## НӨӨЦИЙН УДИРДЛАГА

### 6.1 БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Статистикийн салбар нь 2025 онд Үндэсний Статистикийн Хорооны 7 газар, 16 хэлтэст 132, Нийслэлийн Статистикийн газар, 9 дүүрэгт 59, 21 аймгийн Статистикийн хэлтэст 129, нийт 320 албан хаагчийн орон тоотой ажилласан. Албан хаагчдын чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх хүрээнд нэгжийн болон албан хаагчдын ажлын байрны чиг үүргийн шинжилгээг хийж, албан тушаалын тодорхойлолтын төсөл, бүтэц, орон тоог 9 хувь бууруулах шийдвэрийг гаргалаа. Ингэснээр 2026 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс орон тоо 298 болж, 22 орон тоог цомхотгов.



Зураг 38. БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



#### Үндэсний Статистикийн Хорооны зөвлөлийн үйл ажиллагаа

Монгол Улсын Их Хурлын 2025 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн 8 дугаар тогтоолоор Үндэсний Статистикийн Хорооны зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. Статистикийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2-т заасны дагуу зөвлөлийн даргаар ҮСХ-ны дарга ажиллаж байна. Тус тогтоолоор дараах гишүүдийг томилсон.



Хүснэгт 16. ҮСХ-НЫ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

| Д/д | Гишүүний овог, нэр        | Албан тушаал  |
|-----|---------------------------|---|
| 1   | Төмөрбаатарын Гарамжүгдэр | "Эй Би Эй Жи Скрийнин" ХХК-ийн Гүйцэтгэх захирал                                    |
| 2   | Дорждэрэмийн Цолмон       | Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга  |
| 3   | Ганболдын Золбоо          | Сангийн Яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга                               |
| 4   | Идэшийн Батхүү            | Эдийн Засгийн Хөгжлийн Яамны Төрийн нарийн бичгийн дарга                            |
| 5   | Дамдиндоржийн Мягмарцэрэн | Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх      |
| 6   | Авирмэдийн Даваасүрэн     | ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, зөвлөх |

ҮСХ-ны зөвлөлийн ээлжит хурлыг 2025 оны 3 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулж, ҮСХ-ны үйл ажиллагаа, 2024 оны үйл ажиллагааны тайлан, 2025 оны төлөвлөгөө, Статистикийн тухай хуулийн шинэчлэл, Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн 2025 оны судалгааны үр дүнг тус тус танилцуулсан.



#### Хүснэгт 17. ЗӨВЛӨЛИЙН ХУРЛААС ГАРСАН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

| № | Зөвлөмж  | Хэрэгжилт  |
|---|--|--|
| 1 | Салбар хоорондын тэнцлийн тооцооллыг төлөвлөсөн хугацаанд нь гаргах.   | Судалгаагаар цуглуулсан мэдээлэл болон жилийн эцсийн гүйцэтгэлд үндэслэн нийт үйлдвэрлэл, завсрын хэрэглээ, эцсийн хэрэглээ, хөрөнгийн хуримтлал, гадаад худалдааны матрицуудыг 2024 оны гүйцэтгэлээр 325x205 хэмжээстэйгээр байгуулж, НАХ, СХТ байгуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, үр дүнг 2026 оны эхний улиралд багтаан хэрэглэгчдэд хүргэхээр ажиллаж байна. |
| 2 | Статистикийн мэдээлэлд суурилсан ChatGPT хөгжүүлэлтийг сайжруулж, хэрэглэгчдэд ашиглахад хялбар болгох.                | Статистикийн мэдээллийн нэгдсэн сангийн хүснэгт тус бүрээр асуултын санг баяжуулж, сайжруулалт хийж, шинэ моделиор сургасан.   |
| 3 | МУИС болон бусад их, дээд сургуулиудтай хамтран статистикийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх.                            | Статистикийн салбарыг 2026-2030 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөөнд оруулахаар судалгаа хийсэн боловч ҮСХ-ны эрхлэх асуудалд хамаарахгүй тул холбогдох байгууллагуудтай тухай бүр уулзалт зохион байгуулахаар болсон.  |
| 4 | Хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, ашиглахад хялбар, нарийвчлалтай статистикийн мэдээллийг тогтмол эрхлэн гаргах. | Төрийн нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлснээр нарийвчлалтай мэдээлэл тархах боломж бүрдэх юм. Мөн Статистикийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Статистикийн салбарыг 2026-2030 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөөнд тусгаж тогтмол сайжруулахаар ажиллаж байна.   |
| 5 | ҮСХ-ны 2024 оны үйл ажиллагааны тайланг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны хурлаар хэлэлцүүлэх.      | ҮСХ-ны 2024 оны үйл ажиллагааны тайланг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлж, Улсын их хурлаар хугацаанд нь хэлэлцүүлсэн.   |

## 6.2 ХҮНИЙ НӨӨЦ, СУРГАЛТ

Хүний нөөцийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 26 арга хэмжээг тусган хэрэгжүүлж, биелэлт 88.4 хувь байна.

Байгууллагын дотоод үйл ажиллагааны зохион байгуулалт болон албан хаагчдын нийгмийн баталгааг сайжруулах, эрх, үүрэг, ёс зүйн хэм хэмжээ, хөдөлмөр эрхлэлтийн харилцааг нарийвчлан тодорхойлох зорилгоор Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

ҮСХ-ны дэргэдэх Төрийн албаны салбар зөвлөлөөс сул орон тооны 54 албан тушаалыг зарлан 85 иргэн бүртгүүлсэн бөгөөд төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулах 8 удаагийн тусгай шалгалтыг зохион байгуулж, шалгалтад тэнцсэн 29 иргэнийг нэр дэвшүүлэн, албан тушаалд томилсон (Хавсралт7).

Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 20 арга хэмжээг тусган хэрэгжүүлж ажилласнаас тайлант хугацаанд 97.0 хувийн хэрэгжилттэй байна.

Ерөнхийлөгчийн зарлигаар удирдах албан тушаалын 5 албан хаагчид тэргүүн түшмэл зэрэг дэв, Ерөнхий сайдын тогтоолоор 8 албан хаагчид эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв, ҮСХ-ны даргын тушаалаар 38 албан хаагчид ахлах түшмэлийн зэрэг дэв, 40 албан хаагчид дэс түшмэлийн зэрэг дэв, нийт 91 албан хаагчийн зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгосон.

6. НӨӨЦИЙН УДИРДЛАГА

ҮСХ-оос 2025 онд гадаад улсад зохион байгуулагдсан 57 удаагийн цахим болон биечилсэн сургалт, арга хэмжээнд давхардсан тоогоор 182 албан хаагч оролцож, илтгэл хэлэлцүүлж, туршлага солилцож, мэдлэг чадвараа дээшлүүлсэн.



Хүснэгт 18. ГАДААД СУРГАЛТ АРГА ХЭМЖЭЭНД ХАМГИЙН ИХ ХАМРАГДСАН УЛС

| № | Хамрагдсан Улс               | Сургалт, зөвлөгөөний нэр  | Хамрагдсан албан хаагчдын тоо |
|---|------------------------------|---|-------------------------------|
| 1 | Бүгд Найрамдах Хятад Ард Улс | "Статистикт хиймэл оюун ухааныг ашиглах нь" сургалт   | 19                            |
|   |                              | "Соёлын статистик" сургалт  | 1                             |
|   |                              | "Хөдөө аж ахуйн статистикийн шинэлэг арга, технологи" сургалт   | 2                             |
| 2 | Бүгд Найрамдах Солонгос Улс  | "Захиргааны мэдээлэл, статистикийн бүртгэлийн ашиглалт" сургалт   | 7                             |
|   |                              | "Статистикийн дүн шинжилгээ" сургалт  | 7                             |
|   |                              | "Тогтвортой хөгжлийн зорилгын хяналт шинжилгээ, бодлого боловсруулалт, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд жендерийн өгөгдлийг ашиглах нь" бүсийн сургалт | 1                             |
| 3 | Япон Улс                     | Гамшгийн статистик бүсийн зөвлөгөөн   | 1                             |
|   |                              | "Байгаль орчин эдийн засгийн дансны системийн тогтвортой хөгжилтэй холбоотой хөрөнгийн данс" бүсийн сургалт                                       | 1                             |
|   |                              | "Хөдөө аж ахуйн статистикийн чадавх бэхжүүлэх" сургалт  | 1                             |
| 4 | Бүгд Найрамдах Казахстан Улс | Далд эдийн засаг бүсийн сургалт   | 4                             |
|   |                              | "Уур амьсгалын өөрчлөлтийн макро эдийн засаг" сургалт   | 1                             |
|   |                              | Тогтвортой хөгжлийн зорилт-Санхүүжилтийн хэрэгсэл   | 1                             |
|   |                              | "Хэрэглээний үнийн мэдээнд мэдээллийн алтернатив эх үүсвэрийг ашиглах" бүсийн сургалт   | 2                             |
| 5 | Тайландын Хаант Улс          | "Үндэсний тооцооны систем 2025/Төлбөрийн тэнцлийн гарын авлага 7-ын хэрэгжилт" сэдэвт уулзалт   | 1                             |
|   |                              | Өрхийн хэрэглээний үнэ болон орон сууцны түрээсийн судалгааны үнийн бүсийн техникийн зөвлөгөөн  | 2                             |
|   |                              | "Засгийн газрын цалин хөлсний бүтцийн судалгаа болон дотоодын нийт бүтээгдэхүүний эцсийн ашиглалтын тооцоолол хийх сэдэвт" сургалт                | 2                             |
|   |                              | Өрхийн хэрэглээний үнийн судалгааны мэдээллийн баталгаажуулалт хийх бүсийн зөвлөгөөн  | 1                             |
|   |                              | Барилга, машин тоног төхөөрөмжийн судалгааны мэдээллийн баталгаажуулалт хийх бүсийн зөвлөгөөн   | 2                             |
|   |                              | Ази, Номхон Далайн бүс нутгийн албан ёсны статистикийн ирээдүйн чиглэлийн тухай мэргэжилтнүүдийн зөвлөлдөх уулзалт                                | 1                             |
|   |                              | Машин тоног төхөөрөмж, барилгын материалын үнийн судалгааны мэдээллийн баталгаажуулалт хийх бүсийн зөвлөгөөн                                      | 1                             |

Салбарын албан хаагчдыг хөгжүүлэх сургалтын хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2025 оны төлөвлөгөөний дагуу дотоодод 33 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 1654 албан хаагчийг тус тус хамруулж, мэдлэг, чадварыг дээшлүүлж ажилласан (Хавсралт8).

Сургалтын цахим системийн үйл ажиллагааг жигдрүүлж, ашиглалтыг нэмэгдүүлэх хүрээнд 2025 онд 120 албан хаагч цахим сургалтын системийн 5 программын хичээлийг анхан, дунд, ахисан түвшинд судалж байна. 2025 онд цахим сургалтын системийн албан хаагч цэсэд 3 чиглэлийн 85 хичээл, хэрэглэгч цэсэд 4 чиглэлийн 23 хичээлийг тус тус байршуулсан.



Зураг 39. СУРГАЛТЫН ЦАХИМ СИСТЕМИЙН БҮТЭЦ



Зураг 40. СУРГАЛТЫН ЦАХИМ СИСТЕМД БАЙРШУУЛСАН ХИЧЭЭЛҮҮД

- 1. Python программ анхан дунд түвшний сургалт**
  - Python программын анхан шат
  - Python программын дунд шат
- 2. EXCEL программын сургалт**
  - EXCEL программын анхан шат
  - EXCEL программын дунд шат
  - EXCEL программын ахисан шат
  - EXCEL программын VBA & Macro ашиглах сургалт
- 3. Tableau desktop программ анхан түвшний сургалт**
  - Tableau Desktop программын анхан шат
- 4. Power BI программын анхан түвшний сургалт**
  - Power BI программын анхан шат
- 5. Stata программын анхан, дунд түвшний сургалт**
  - Stata программын анхан шат
  - Stata программын дунд шат
- 6. SQL программын анхан, дунд, ахисан түвшний сургалт**
  - SQL программын анхан шат
  - SQL программын дунд шат
  - SQL программын ахисан шат
- 7. Google Earth Engine программын сургалт**
  - Google Earth Engine программын сургалт



### 6.3 САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Үндэсний Статистикийн Хорооны 2025 оны үйл ажиллагааны урсгал төсөв 28,102.8 сая төгрөг батлагдсан, үүнээс 25,716.8 сая төгрөгийн гүйцэтгэлийг санхүүжүүлэн 95.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардал 2.0 тэрбум төгрөг батлагдаж 1,797.2 сая төгрөгийн санхүүжилтийг зарцууллаа.



Хүснэгт 19. ТӨСВИЙН УРСГАЛ ЗАРДЛЫН ЗАРЦУУЛАЛТ, эдийн засгийн ангиллаар, сая төгрөг

| Эдийн засгийн ангилал   | 2025 он         |                 |
|---|-----------------|-----------------|
|   | Төсөв           | Гүйцэтгэл       |
| <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>  | <b>28,102.9</b> | <b>25,716.9</b> |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил   | 15,954.7        | 15,117.0        |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл  | 1,993.5         | 1,935.7         |
| <b>Хангамж, бараа материалын зардал</b>   | <b>294.7</b>    | <b>228.7</b>    |
| Бичиг хэрэг   | 76.9            | 58.7            |
| Тээвэр, шатахуун  | 80.5            | 62.9            |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр  | 78.0            | 66.9            |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс   | 59.3            | 40.2            |
| <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>  | <b>159.2</b>    | <b>110.3</b>    |
| Багаж, техник, хэрэгсэл   | 10.0            | 5.0             |
| Урсгал засвар   | 149.2           | 105.3           |
| Томилолт, зочны зардал  | 87.9            | 57.4            |
| Дотоод албан томилолт   | 87.9            | 57.4            |
| <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>                       | <b>9,064.0</b>  | <b>7,984.3</b>  |
| Тооллого, судалгааны зардал   | 8,246.6         | 7,323.0         |
| Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох  | 15.2            | 14.7            |
| Даатгалын үйлчилгээ   | 26.8            | 7.6             |
| Тээврийн хэрэгслийн татвар  | 4.7             | 1.7             |
| Тээврийн хэрэгслийн оношилгоо   | 0.7             | 0.2             |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ   | 600.1           | 528.6           |
| Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх  | 170.0           | 108.3           |
| Бараа үйлчилгээний бусад зардал   | 174.30          | 122.4           |
| Бараа үйлчилгээний бусад зардал   | 48.1            | 31.6            |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх   | 126.1           | 90.8            |
| <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>   | <b>374.60</b>   | <b>161.1</b>    |
| Засгийн газрын урсгал шилжүүлэг   | 36.5            | 0               |
| Засгийн газрын гадаад шилжүүлэг   | 36.5            | 0               |
| <b>Бусад урсгал шилжүүлэг</b>   | <b>338.1</b>    | <b>161.1</b>    |
| Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал  | 50.5            | 44.9            |
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж                                   | 147.1           | 33.7            |
| Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 44.4            | 34.4            |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал   | 96.1            | 48.1            |
| <b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>   | <b>2,000.0</b>  | <b>1,797.2</b>  |
| Тоног төхөөрөмж   | 1,804.2         | 1,797.2         |

Азийн Хөгжлийн Банк, НҮБ-ын Хүүхдийн сан, БНСУ-ын Статистикийн газрын буцалтгүй тусламжаар 451.7 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил хүлээн авсан. Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс 2025 онд 712.4 сая төгрөгийн санхүүжилт авч, үүнээс 513.5 сая төгрөгийг зарцуулсан байна. (Хавсралт 9).



Хүснэгт 20. НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ

| №               | Төслийн нэр                | Тоо ширхэг | Мөнгөн дүн /сая төгрөг/ | Хөрөнгийн нэр                                |
|-----------------|----------------------------|------------|-------------------------|--|
| 1               | Азийн Хөгжлийн Банк        | 20         | 257.9                   | Компьютер, тоног төхөөрөмж                   |
| 2               | БНСУ-ын Статистикийн газар | 4          | 121.9                   | Сервер                                       |
| 3               | НҮБ Хүүхдийн сан           | 42         | 71.9                    | Компьютер тоног төхөөрөмж, тавилга эд хогшил |
| <b>Нийт дүн</b> |                            | <b>66</b>  | <b>451.7</b>            |  |


## 6.4 ДОТООД АУДИТ

Тус хорооны Дотоод аудит, эрсдэлийн удирдлагын газар нь 2025 онд 5 сэдвийн хүрээнд 13 удаагийн аудит хийж гүйцэтгэсэн байна. Үүний 46.2% нь санхүүгийн аудит, 23.1% нь гүйцэтгэлийн аудит, 15.4% нь нийцлийн аудит, 15.4% нь МАБМТ-ны хэрэгжилтэд хийсэн аудит байна. Мөн 2025 онд 23 хяналт шалгалтыг хийж гүйцэтгэснээс 6 нь төлөвлөгөөт, 7 нь төлөвлөгөөт бус, 10 нь ҮСХ-нд ирүүлсэн өргөдөл, гомдлын хүрээнд хийсэн хяналт шалгалт байна.




Зураг 41. 2025 ОНД ХИЙСЭН ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТ




**Дотоод аудит, хяналт шалгалтын үр дүн:****Зураг 42. ШИЛЭН ДАНСАНД ОРЛОГО, ЗАРЛАГЫН ГҮЙЛГЭЭГ МЭДЭЭЛСЭН БАЙДАЛ, хувиар**

ҮСХ-ны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын хэмжээнд 2024 онд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагыг шилэн дансанд үнэн зөв мэдээлсэн байдал өмнөх оноос 0.9 нэгж хувиар буурсан байна.

**Зураг 43. ХУДАЛДАН АВАЛТЫГ МЭДЭЭЛСЭН БАЙДАЛ, ХУВИАР**

Худалдан авалтыг мэдээлсэн байдлыг 2022 онтой харьцуулахад 5.8 нэгж хувиар буурсан байна.

\*Тайлбар: 2023 онд Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын 8 дугаар хавсралтаар баталсан "Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ"-г мэдээлэх хүснэгтийг хассан байсан тул бүх төсвийн захирагч нь худалдан авалтыг мэдээлээгүй болно.

**Зураг 44. ШИЛЭН ДАНСАНД МЭДЭЭЛЭХ ХУУЛИЙН ХУГАЦААГ ХОЦРООСОН БАЙДАЛ, хувиар**

Хөрөнгө зарцуулах аливаа шийдвэрийг мэдээлсэн байдал өмнөх оноос 0.4 нэгж хувиар өссөн байна.

ДАЭУГ нь 2025 онд дараах 8 сэдвийн хүрээнд нийт 23 хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- **Мэдээллийн аюулгүй байдлын үйл ажиллагаа:** 2025 онд ҮСХ-ны мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр 4 удаагийн төлөвлөгөөт хяналт шалгалт хийж гүйцэтгэсэн. Энэ хүрээнд удирдлагын хавтасны иж бүрдэл, Хандах эрхийн хяналт хийх журмын хэрэгжилт, мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоонд хийсэн дотоод аудитын зөвлөмжийн хэрэгжилт болон Гуравдагч талд мэдээллийн аюулгүй байдлыг хангуулах журмын хэрэгжилтийг шалгаж, холбогдох нэгжүүдэд сайжруулах зөвлөмж хүргүүлсэн.
- **МАБМТ-ны дотоод аудит:** ISO/IEC 27001:2022 стандартад нийцүүлэн нийт 121 асуудлын хүрээнд (28 шалгуур, 93 хяналт) дотоод аудит хийв. Аудитын үр дүнгээр нийт 35 үл тохирол (9 их, 26 бага) болон 21 анхаарах асуудал илрүүлж, холбогдох зөвлөмжийг хүргүүлсэн. Баталгаажуулалтын аудитын байгууллагаас тодорхойлсон анхаарах асуудлуудын сайжруулалтын хэрэгжилтийг үнэлсэн.
- **Тамгын газрын үйл ажиллагаа:** ҮСХ-ны Тамгын газрын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг төлөвлөгөөний дагуу хийж, "Сайжруулах шаардлагатай" дүгнэлтийг өгсөн. Хяналт шалгалтын ажлыг 27 чиг үүргийг хамруулан хийж, 17 зөвлөмж хүргүүлсэн. Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг 75 хувиар хангуулсан.
- **Салбарын хэмжээнд мөрдөж байгаа хууль, дүрэм, журам, зааврын хэрэгжилт:** Заавар, журам шинэчлэх давтамж, мөрдөж эхлэх хугацаа тодорхойгүй зэрэг хугацаа, хэрэгжилт, хяналтын зохицуулалт дутуу
- **Үндэсний аудитын газраас Төсвийн ерөнхийлөн болон шууд захирагчийн 2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилт:** Үндэсний аудитын газраас төсвийн ерөнхийлөн болон шууд захирагчийн 2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын дүгнэлтээр 12 байгууллага зөрчил гаргасан бөгөөд нийт 0.1 сая төгрөгийн 1 акт, 474.8 сая төгрөгийн 7 албан шаардлага, 55.9 сая төгрөгийн 18 зөвлөмжийг хүлээн авсан. Зөрчил гаргасан 12 байгууллагаас зөвлөмжийн хэрэгжилтийг гаргуулан авч нэгтгэн ҮАГ-т хүргүүлсэн.
- **Статистикийн мэдээллийн тархаалт:** Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, Статистикийн эмхэтгэл, сарын танилцуулгад орсон тоон мэдээллийг шалгаж, илэрсэн алдааг арилгуулсан.
- **Албан ёсны статистикийн мэдээ, тайлан:** Барилгын салбарын статистикийн мэдээллийн чанарт шалгалт хийж, захиргааны мэдээлэл ашиглах талаар холбогдох газар, хэлтэст зөвлөмж хүргүүлсэн.
- **Хүн ам, орон сууцны 2025 оны завсрын тооллогын бэлтгэл ажил хангасан байдал, мэдээлэл цуглуулалтын явц:** Дархан-Уул, Төв, Дундговь, Булган, Орхон, Хэнтий, Дорнод аймгийн Статистикийн хэлтсүүдэд ХАОСЗТ-ын бэлтгэл ажил, мэдээлэл цуглуулалтын явцад хяналт шалгалт хийж, үр дүнг ҮСХ-ны даргад танилцуулсан. Тооллогын явцыг нэмэгдүүлэх, мэдээллийн чанарыг сайжруулах зорилгоор нийт 37 зөвлөмжийг аймгийн статистикийн хэлтсүүдэд өгч, ажилласан.
- **ҮСХ-нд ирүүлсэн өргөдөл, гомдол:** ҮСХ-нд ирүүлсэн өргөдөл, гомдлын дагуу асуудлыг бүрэн хамруулан шалгаж дүгнэлт гарган, хуулийн хугацаанд хариуг өгсөн.

#### Статистикийн улсын байцаагчийн үйл ажиллагаа

Статистикийн улсын байцаагч нь төрийн захиргааны холбогдох байгууллагуудтай хамтран нийслэл, дүүрэг, аймаг, сумын анхан шатны нэгжид ажиллаж буй статистикийн мэдээлэгч, аж ахуйн нэгж, байгууллагын анхан шатны бүртгэл болон мэдээлэл цуглуулалтын үнэн зөв байдалд хяналт шалгалт хийж ажилласан бөгөөд шалгалтын дүнгээр нийт 797 зөрчлийг арилгуулж, 75 албан шаардлага хүргүүлэн, торгууль шийтгэлийн 4 арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна.

## 6. НӨӨЦИЙН УДИРДЛАГА

Улсын байцаагчдын зүгээс захиргааны болон албан ёсны статистикийн мэдээллийн чанар, хамралтыг сайжруулах, анхдагч мэдээллийн үнэн зөв, чанартай байдлыг хангах чиглэлээр хугацаатай үүрэг даалгавар өгч, хэрэгжилтэд нь тогтмол хяналт тавин ажиллаж байна.

### 6.5 ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Статистикийн салбарын 2021-2025 оны стратеги төлөвлөгөө болон ҮСХ-ны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний "Хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилтын хүрээнд "Үйл ажиллагааны эрсдэлийн мэдээллийн санд эрсдэлтэй тохиолдлыг цаг алдалгүй, үнэн зөв оруулсан эсэхэд хяналт тавьж, учирч болзошгүй хохирлоос урьдчилан сэргийлэх" арга хэмжээг төлөвлөсөн.



Зураг 45. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, 2025



Дээрх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлээд байна. Үүнд:

- **Эрсдэлийн засаглал ба соёлын хүрээнд (бүтэц, зохион байгуулалт):** ҮСХ болон аймаг, нийслэлийн статистикийн газар, хэлтсийн дарга нарт үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг холбогдох хууль тогтоомж, бодлого, журмын дагуу зохион байгуулж, хэрэгжүүлэх үүргийг хүлээлгэн, орон нутгийн оролцоог хангасан 11 хүний бүрэлдэхүүнтэй Эрсдэлийн зөвлөлийг байгуулан ажиллаж байна. Түүнчлэн ҮСХ болон нийслэл, аймгийн статистикийн газар, хэлтэст "Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын орон тооны бус нэгж"-ийг байгуулан, тогтмол үйл ажиллагаа явуулж байна.
- **Эрсдэлийн удирдлагын үйл явцын хүрээнд:** Эрсдэлийг илрүүлэх, шинжлэх, үнэлэх, хариу арга хэмжээ авах, эргэн хянах үйл явцыг системтэйгээр хэрэгжүүлэх зорилгоор 2022 оноос жилээр, 2025 оноос эхлэн сарын давтамжтайгаар эрсдэлийг бүртгэн үнэлж, хариу арга хэмжээг төлөвлөж, хэрэгжилтэд нь үнэлгээ хийж байна. ҮСХ, нийслэл болон аймгийн статистикийн газар, хэлтсийн түвшинд 2025 оны эцсийн байдлаар нийт 252 эрсдэлийг тодорхойлноос 55 нь (21.8 хувь) анхны тодорхойлолтоороо хяналтад байлгах эрсдэл, 197 нь (78.1 хувь) хариу арга хэмжээ хэрэгжүүлэх түвшний эрсдэлд хамаарч байна. Хариу арга хэмжээ хэрэгжүүлэх түвшний 197 эрсдэлээс 186 (94.4 хувь) эрсдэлийг 2025 онд хэрэгжүүлж дуусахаар төлөвлөсөн бөгөөд оны эцсийн байдлаар 80 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, холбогдох эрсдэлүүдийг хяналтад шилжүүлсэн байна. Үүний үр дүнд хариу арга хэмжээний хэрэгжилтийн түвшин 43.0 хувьтай байна.
- **Эрсдэлийн мэдээлэл, харилцаа холбооны хүрээнд:** Эрсдэлийн удирдлагын үйл явцыг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор эрсдэлийн мэдээлэл, харилцаа холбооны нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, "Эрсдэлийн удирдлагын систем"-ийг хөгжүүлсэн. Уг системд ҮСХ болон нийслэл, аймгийн статистикийн газар, хэлтсийн эрсдэлийн мэдээллийг бүртгэж, эрсдэлийн удирдлагатай холбоотой бүх үйл ажиллагааг нэгтгэн зохицуулахаар төлөвлөж байна.

Мөн Статистикийн салбарын 2026-2030 оны стратеги төлөвлөгөөнд ҮСХ-ны эрсдэлийн удирдлагын тогтолцооны төлөвшлийн түвшнийг дээшлүүлэх зорилтыг тусгаж, хэрэгжилтийг төлөвлөсөн.




Зураг 46. ҮСХ-НЫ ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ТӨЛӨВШИЛ



Тайлбар: "Төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг үнэлэх аргачлал"-ын дагуу үнэлэв.

Өнөөгийн байдлаар ҮСХ-ны эрсдэлийн удирдлагын тогтолцооны хэрэгжилт нь "Төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг үнэлэх аргачлал"-ын дагуу 3 дугаар түвшинд буюу хөгжиж буй шатанд байна. Тухайлбал, эрсдэлийн удирдлагын бодлого, журам, бүтэц, чиг үүргийг бүрэн тодорхойлж, баталсан. Ажилтан, албан хаагчдын эрсдэлийн удирдлагын мэдлэг, ойлголт, оролцоо дээшилсэн. Эрсдэлийн мониторинг, хяналтыг тодорхой хэмжээнд хэрэгжүүлж эхэлсэн.

Цаашид Статистикийн салбарын 2026-2030 оны стратеги төлөвлөгөөнд тус аргачлалын дагуу 4 дүгээр түвшинд хүрэх, "Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж хэвших буюу эрсдэлийн удирдлагын үйл явц нь байгууллагын стратегийн зорилготой нягт уялдсан, удирдлагын түвшинд тогтмол хяналт тавьдаг, байгууллагын хэмжээнд зохицуулалт сайтай, эрсдэлийн удирдлагын чиглэлээр алба нэгжийн харилцаа, хамтын ажиллагаа сайжирсан байх" зорилт тусган, төлөвлөөд байна.



7

## СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

## 7.1 СТАТИСТИКИЙН САЛБАРЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ (ТОМООХОН АЖИЛ, ҮР ДҮН)

Статистикийн салбарыг 2021-2025 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөөнд Хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, Хүний нөөцийн хөгжлийг хангах, Дэд бүтцийг сайжруулах, Статистикийн мэдээллийг эрхлэн гаргах ажиллагааг боловсронгуй болгох гэсэн 4 зорилтын хүрээнд 23 арга хэмжээ төлөвлөснөөс 19 арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 1 арга хэмжээ хэрэгжих шатандаа, 3 арга хэмжээ хэсэгчлэн хэрэгжиж, 82.6 хувийн биелэлттэй байна.

- Хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгын хүрээнд олон улсын зөвлөмж, сайн туршлагад үндэслэсэн албан ёсны статистикийн бие даасан, хараат бус байдал, үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулах өөрчлөлтийг Статистикийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусган хууль санаачлагчид хүргүүлээд байна. Мөн мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын стандарт (ISO 27001)-ыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, магадлах аудит хийлгэв.
- Хүний нөөцийн хөгжлийг хангах зорилгын хүрээнд салбарын албан хаагчдын нийгмийн асуудал, ажиллах нөхцөл, цалин хөлс, урамшууллыг төрийн захиргааны төв байгууллагуудтай дүйцэх хэмжээнд хүргэж, өрсөлдөхүйц болголоо. Ажилтнуудынхаа их өгөгдөл, хиймэл оюун ашиглан дүн шинжилгээ хийх ур чадварыг нэмэгдүүлэхэд анхаарч статистикийн программын сургалтуудыг үе шаттайгаар зохион байгуулав. Байгууллагын бүтэц зохион байгуулалтыг шинэчилж ажлын ачааллыг тэнцвэржүүлэх хүрээнд ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн батлуулав.
- Дэд бүтцийг сайжруулах зорилгын хүрээнд нотолгоонд суурилсан шийдвэр гаргалтыг нэмэгдүүлэх зорилгоор АХБ-ны техник туслалцаагаар TA10029-MON "Төрийн нэгдсэн мэдээллийн сангийн хөгжүүлэлт, удирдлага" төслийг хэрэгжүүлж, төрийн байгууллагуудын өгөгдлийг нэгтгэх бэлэн байдлын үнэлгээг хийж, "Төрийн мета өгөгдлийн нэгдсэн сан"-г байгууллаа. Мөн өгөгдлийг нэгтгэх, боловсруулах, ашиглах, хадгалахад шаардлагатай зохицуулалт, үйл ажиллагаанд баримтлах өгөгдлийн засаглал, экосистемийн ерөнхий бүтэц түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний зураглалыг боловсруулсан. Статистикийн мэдээ тайланг цуглуулах, боловсруулах программ хангамжийг шинэчлэх, сайжруулах ажлуудыг хийж, ААНБ өөрсдөө мэдээллээ оруулах боломжоор хангав. Түүнчлэн статистикийн мэдээллийг бусад мэдээллийн эх үүсвэртэй уялдуулах, холбож судалгаа, шинжилгээ хийх боломжийг бүрдүүлэх зорилгоор захиргааны өгөгдлийг нэгтгэсэн Төрийн нэгдсэн өгөгдлийн сан бий болгож, даталаб байгуулах ажлыг эхлүүлээд байна.
- Статистикийн мэдээллийг эрхлэн гаргах ажиллагааг боловсронгуй болгох зорилгын хүрээнд мэдээллийн шинэ эх үүсвэрүүд тухайлбал, веб скрапинг, орон зайн мэдээлэл, захиргааны өгөгдөл ашиглан шинэ статистик мэдээлэл бий болгох, мэдээлэл цуглуулалтад шинэ технологи, хиймэл оюуныг ашигласан хэд, хэдэн туршилт тооцоолол хийгээд байна. Чанарын удирдлагын тогтолцоог хөгжүүлж, статистикийн үйл ажиллагааны ерөнхий загварыг үйл ажиллагаандаа мөрдүүлэн ажиллаж байна.

## 7.2 СТАТИСТИКИЙН САЛБАРЫГ 2026-2030 ОНД ХӨГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ

Статистикийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "Үндэсний Статистикийн Хороо нь албан ёсны статистикийн үзүүлэлтийг тооцох, тооллого, судалгаа явуулах талаар ойрын зорилтыг тодорхойлсон хөтөлбөрийг боловсруулж, УИХ-аар батлуулах" гэсэн заалтыг үндэслэн Статистикийн салбарын 2026–2030 оны стратеги төлөвлөгөөг орчин үеийн статистикийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн шинэчлэх, тулгамдаж байгаа асуудлуудыг шийдэхэд чиглүүлэн холбогдох судалгаа, шинжилгээний баримтад тулгуурлан боловсруулж, Үндэсний Статистикийн Хорооны даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/150 тушаалаар батлав.

## 7. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

Статистикийн салбарын 2026-2030 оны стратеги төлөвлөгөөнд хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, өгөгдлийн засаглалыг бэхжүүлэх, дэд бүтэц, хүний нөөцийн чадавхыг сайжруулах, статистикийн үйл ажиллагааг шинэчлэх, өгөгдлийн ашиглалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн стратегийн 4 зорилго, 14 дэд зорилт, 26 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.



Зураг 47. СТАТИСТИКИЙН САЛБАРЫН 2026-2030 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО, ХҮРЭХ ҮР ДҮН





8

**ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ  
2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД  
ХИЙСЭН СИСТЕМЧИЛСЭН  
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

## ОРШИЛ

Үндэсний Статистикийн Хороо (цаашид ҮСХ гэх) нь “Статистикийн салбарыг 2021-2025 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөө”-тэй уялдуулан ҮСХ-ны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлан хэрэгжүүлсэн байна.

ҮСХ-ны Дотоод аудит, эрсдэлийн удирдлагын газраас УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны 5 дугаар тогтоол, Хууль зүй, дотоод хэргийн яам (тухайн үеийн нэрээр Хууль зүйн яам)-аас боловсруулсан гаргасан “Байгууллагын үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу ҮСХ-ны 2025 оны үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээг дараах хүрээнд хийлээ. Үүнд:

- ҮСХ-ны чиг үүргийн хэрэгжилт
- ҮСХ-ны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт
- Хүний нөөцийн хэрэгцээ
- Санхүү, төсвийн үйл ажиллагаа

Системчилсэн үнэлгээнд ҮСХ болон газруудын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан, бүтэц, зохион байгуулалт, хүний нөөцийн судалгаа, 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан, худалдан авах ажиллагааны тайлан болон бусад холбогдох баримт материалыг хамруулж, системчилсэн үнэлгээ хийх арга зүйг ашиглав.

### 8.1 ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

ҮСХ нь Статистикийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан албан ёсны статистикийн үзүүлэлтүүдийг боловсруулах, 7 дугаар зүйлд заасан тооллого, судалгааг тогтоосон хугацаанд зохион байгуулах, статистикийн хэрэглэгчдийг чанартай тоон мэдээллээр тасралтгүй хангах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Дээрх чиг үүргийнхээ хүрээнд жил бүр албан ёсны статистикийн үзүүлэлтийг нийтлэх тархаах хуваарийг боловсруулж, ҮСХ-ны даргын тушаалаар батлан мөрдүүлдэг. Үүний дагуу ҮСХ-ны даргын 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн А/174 дүгээр тушаалаар “Албан ёсны статистикийн мэдээ, тооллого, судалгааны үр дүнг 2025 онд тархаах хуваарь”-ийг баталсан бөгөөд уг хуваарьт нийт 34 нэр төрлийн мэдээ, тайлан, тооллого, судалгаа багтсан байна.

Улсын хэмжээнд 2025 онд 2 тооллого, 7 түүвэр судалгааг цаг хугацаанд нь зохион байгуулж, үр дүнг тархаасан байна. Тухайлбал:

- ҮСХ нь Статистикийн тухай болон Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хуульд заасан чиг үүргийн дагуу хүн ам, орон сууцны завсрын тооллогыг 2025 онд зохион байгуулсан. Ингэхдээ тооллогыг төрийн 14 байгууллагуудын суурь болон төрөлжсөн 30 мэдээллийн санг ашиглаж, бүртгэлд суурилсан аргаар зохион байгуулсан байна;
- Мал, тэжээвэр амьтдын тооллогыг шинэчилсэн маягтаар зохион байгуулсан;
- Эдийн засгийн түвшин, эдийн засгийн нөөцийн эх үүсвэр, бүтэц, эдийн засгийн салбар хоорондын харилцаа, уялдаа, холбоог судлах, чиг хандлагыг тодорхойлох “Нөөц, ашиглалтын хүснэгт, Салбар хоорондын тэнцлийг 2024 оны гүйцэтгэлээр байгуулах судалгаа”, “Хувиараа хөдөлмөр эрхлэлтийн судалгаа”-г зохион байгуулсан байна;
- Монгол Улсын иргэдийн дотоодын аялал жуулчлалыг дэмжих, бодлого хөтөлбөр боловсруулахад судалгаанд суурилсан тоон мэдээлэл дутмаг, мэдээллийн эх үүсвэр тодорхойгүй байсан тул ҮСХ-оос Дотоодын жуулчдын түүвэр судалгааг 2025 онд зохион байгууллаа.

## 8. ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Сүүлийн жилүүдэд статистикийн мэдээлэлд тавигдах чанар, нарийвчлал, хүртээмжийн шаардлага нэмэгдэж, судалгаа, тооллогын агуулга, арга зүй олон улсын стандарттай уялдан шинэчлэгдэж, мэдээлэл цуглуулах үйл ажиллагаанд цахим технологийн хэрэглээ өргөжиж байгаа нь статистикийн байгууллагын хүний нөөцийн бүтэц, чадварт шинэ шаардлага тавьж байна.

Энэ хүрээнд ҮСХ нь тооллого, судалгааны мэдээлэл цуглуулалтыг цахимжуулах, мэдээлэл боловсруулалтын үйл ажиллагаанд их өгөгдөл болон хиймэл оюун ухааны дэвшилтэт технологийг ашиглах замаар статистик мэдээллийн чанар, хүртээмж, бодит байдлыг дээшлүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлээд байна. Тухайлбал:

### **Их өгөгдлийн эх үүсвэрүүдийг статистикт нэвтрүүлэх чиглэлээр:**

- Төрийн 43 байгууллага төрийн мета өгөгдлийн нэгдсэн санд мэдээллээ бүрэн оруулснаас 31 байгууллагын өгөгдөлд үнэлгээ хийж, холбогдох засвар өөрчлөлтийг тусгуулсан байна;
- Төрийн 15 байгууллагын суурь болон төрөлжсөн мэдээллийн санг ашиглан “Хүн ам, орон сууцны 2025 оны завсрын тооллого”-ыг анх удаа бүртгэлд суурилсан хэлбэрээр зохион байгуулсан байна;
- Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр хүн амын шилжилт хөдөлгөөн, аялал жуулчлал, харилцаа холбооны салбарын статистикийг гар утасны өгөгдөл ашиглан боловсруулах зорилт тавин ажиллаж байна.

### **Статистикт дэвшилтэт техник технологи ашиглах чиглэлээр:**

- Хэрэглэгчдэд статистикийн мэдээллийг хялбар хүргэх зорилгоор хиймэл оюунд суурилсан статистикийн чатбот (MonStatGPT) нэвтрүүлж, хэрэглэгчдэд статистик мэдээллийг шуурхай, ойлгомжтой, хялбар хүргэх боломж бүрдэж байна;
- Мал тоолж байгаа 5,568 бичлэгээс малын зургийг төрлөөр нь ялган тэмдэглэж, машин сургалтын туршилтын программыг хөгжүүлсэн. Мал тооллогын явцад малыг төрлөөр ялган тоолох туршилтын аппликейшныг хөгжүүлэн, 2025 оны мал тооллогын хяналтад ашиглажээ.

### **Мэдээллийн аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр:**

- Азийн Хөгжлийн Банкны техникийн туслалцааны хүрээнд хэрэгжиж буй “Төрийн нэгдсэн мэдээллийн сангийн удирдлага, хөгжүүлэлт” төслийн дагуу ҮСХ нь Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо (МАБМТ)-ны ISO 27001:2022 олон улсын стандартыг нэвтрүүлэх ажлыг 2024 оноос эхлүүлж, эхний шатны шаардлагуудыг бүрэн ханган анхан шатны баталгаажуулалтын гэрчилгээг авсан. 2025 онд МАБМТ-г хэрэгжүүлэх, мэдээллийн аюулгүй байдлын хэвийн болон тасралтгүй үйл ажиллагааг хангах, сайжруулах зорилтын хүрээнд дотоод аудитыг хагас жил тутам хийж, МАБМТ-ны хэрэгжилт болон аюулгүй байдлын хяналтын үр нөлөөг үнэлсэн. Мөн хяналт шалгалтыг улирал бүр хийж, стандартын хэрэгжилт, мэдээллийн аюулгүй байдлын түвшин болон эрсдэлийн удирдлагын байдлыг үнэлж, шаардлагатай сайжруулалтыг хийж ажилласан байна. Үр дүнд 2025 онд хөндлөнгийн магадлангийн аудитаар баталгаажуулалтын гэрчилгээг амжилттай шинэчлэн сунгуулж, МАБМТ-ны хэрэгжилтийг олон улсын шаардлагын дагуу тогтвортой, тасралтгүй ханган ажиллаж байна.

### **Статистикийн мэдээллийн нэгдсэн санг шинэчлэх чиглэлээр:**

- Статистикийн мэдээллийн нэгдсэн сан [www.1212.mn](http://www.1212.mn) цахим хуудсыг шинэ технологид суурилан бүрэн шинэчилж, нээлттэй эх үүсвэр PXWeb системд шилжүүлсэн байна. Шинэ [www.1212.mn](http://www.1212.mn)-ийг [data.1212.mn](http://data.1212.mn) системтэй API сервисээр холбож, контент удирдах систем хөгжүүлэн Үндэсний дата төвд байршуулснаар мэдээллийн аюулгүй байдал хангагдаж, мэдээлэл авах хурд 10 дахин нэмэгдсэн байна.

### Гадаад харилцаа, хамтын ажиллагааны чиглэлээр:

- Статистикийн тухай хуульд заасан "Статистикийн талаар гадаад улс, олон улсын статистикийн болон төрөлжсөн бусад байгууллагын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, тэдгээртэй Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээний дагуу хамтран ажиллах, тус улсын эдийн засаг, нийгмийн холбогдолтой статистикийн мэдээллийг гаргаж өгөх" эрхийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна. Тухайлбал:
  - НҮБ-ын Ази, Номхон далайн орнуудын Статистикийн институтын Удирдах зөвлөлийн гишүүнээр ҮСХ-ны дарга сонгогдож, ажиллахаар болсон байна;
  - НҮБСХ-ийн Чанарын баталгаажилтын үндэсний хүрээний мэргэшсэн бүлэгт ҮСХ нэгдэн орсон байна;
  - Олон улсын байгууллагуудтай хамтран 10 төсөл арга хэмжээг хэрэгжүүлж, үндэсний статистикийн систем болон ҮСХ-ны чадавхыг бэхжүүлэх чиглэлээр санаачилгатай ажилласан байна;
  - 2025 онд Австралийн Статистикийн товчоо, БНХАУ-ын Үндэсний статистикийн товчоо, БНПУ-ын статистикийн газар, Норвегийн статистикийн байгууллага зэрэг улсуудтай туршлага судлах уулзалт зохион байгуулж, БНСУ-ын хөгжлийн албан ёсны тусламжаар хэрэгжүүлж буй төслийн хүрээнд Захиргааны мэдээллийн нэгдсэн системийг хөгжүүлж, хүлээн авсан байна;
  - НҮБ-ын Жендэрийн эрх тэгш байдал, эмэгтэйчүүдийг чадавхжуулах байгууллага, НҮБ-ын Ази, Номхон далайн орнуудын Эдийн засаг, Нийгмийн комисс, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Оксфордын Их Сургуулийн Хүний хөгжлийн институт, ПАРИС21 зэрэг олон улсын байгууллагуудтай хамтран 4 удаагийн сургалт, семинар, уулзалтыг Монгол Улсад зохион байгуулсан байна.

"Статистикийн тухай" хуулийн 12.3-т заасан чиг үүрэг, Парис21 олон улсын байгууллагын "Статистикийн хөгжлийн үндэсний стратеги боловсруулах гарын авлага 3.0", олон улсын сайн туршлагад үндэслэн Монгол Улсын статистикийн салбарыг 2026-2030 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөөг боловсруулж баталсан байна.

## 8.2 ҮСХ-НЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

ҮСХ нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Статистикийн салбарын 2021-2025 оны стратеги төлөвлөгөөтэй уялдуулан дараах 5 зорилтын хүрээнд 22 ажлыг төлөвлөж, хэрэгжилтийг ханган ажиллажээ. Үүнд:

1. Хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох;
2. Хүний нөөцийн хөгжлийг хангах;
3. Дэд бүтцийг сайжруулах;
4. Статистикийн мэдээллийг эрхлэн гаргах ажиллагааг боловсронгуй болгох;
5. Статистикийн тухай хуулийн 12 дугаар зүйл Нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах.

ҮСХ-ны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан газар, хэлтсүүд гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө боловсруулан, газар, хэлтсийн төлөвлөгөө, чиг үүргийн хүрээнд албан хаагчид гүйцэтгэх ажлуудыг гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлжээ. ҮСХ-ны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 92.7 хувьтай байна. Биелэлтийг Засгийн Газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын дагуу үнэлэхэд 18 ажил бүрэн хангалттай<sup>1</sup>, 4 ажил хангалттай<sup>2</sup> байна.

1 Төлөвлөгөөний хэрэгжилт 85 буюу түүнээс дээш хувь бол "бүрэн хангалттай" (арга хэмжээ оновчтой тодорхойлогдсон, зорилтот түвшиндээ хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан, эсхүл шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, үр дүн гарч эхэлсэн);

2 төлөвлөгөөний хэрэгжилт 70-85 хүртэл хувь бол "хангалттай" (шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах);



Хүснэгт 21. ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

| № | Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэсэг  | Зорилтын тоо | Төлөвлөсөн ажлын тоо | Хэрэгжилтийн үнэлгээ |            |            |
|---|---|--------------|----------------------|----------------------|------------|------------|
|   |   |              |                      | Бүрэн хангалттай     | Хангалттай | Хангалтгүй |
| 1 | Нэгдүгээр хэсэг. Бодлогын баримт бичиг болон хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт | 4            | 18                   | 14                   | 4          | -          |
| 2 | Хоёрдугаар хэсэг. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт                  | 1            | 4                    | 4                    | -          | -          |
|   | Нийт  | 5            | 22                   | 18                   | 4          | -          |

**“Хангалттай”** буюу шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах ажлууд (70-85%):

- Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.2-т “Албан хаагчдын албан тушаалын чиг үүрэг, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг харьцуулан дүгнэж ажлын ачааллыг тодорхойлох, KPI тооцоолох боломжит суурь үзүүлэлтийг танилцуулах” ажлыг төлөвлөжээ. Уг ажлын хүрээнд албан хаагчдын чиг үүргийн давхардал, ажлын ачааллыг тодорхойлсон ч KPI тооцоолох боломжит суурь үзүүлэлтийг нэгтгэн боловсруулаагүй, албан тушаал бүрд тохирсон KPI үзүүлэлтийг тодорхойлох зорилтот түвшинд хүрээгүй байна;
- Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.3-т 2025 онд 2 тооллого, 8 түүвэр судалгааг зохион байгуулж үр дүнг тархаах, мөн 1 тооллогыг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангахаар төлөвлөсөн байна. Үүнээс нөөц ашиглалтын хүснэгт болон салбар хоорондын тэнцлийг 2024 оны гүйцэтгэлээр байгуулах судалгааг зохион байгуулсан боловч үр дүнг тархаагаагүй байна;
- Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.4-т “2 тооллого, 7 судалгааны үзэл баримтлал, асуулга, нөхөх заавар, 3 салбарын мэдээний маягт, нөхөх заавар, 1 аргачлалыг олон улсын стандартын дагуу шинэчлэн сайжруулах, шинээр боловсруулж, батлах”-аар төлөвлөсөн байна. Үүнээс Аж ахуйн нэгжийн тооллогын үзэл баримтлал, асуулга, нөхөх заавар болон Соёлын статистикийн аргачлалыг эцэслэн батлуулаагүй байна. Мөн 2 судалгааны түүврийн арга зүй, гүйцэтгэлийн үнэлгээг хийж, арга зүйг сайжруулах ажлын хүрээнд Ажиллах хүчний судалгааны түүврийн дизайнд өөрчлөлт хийж, түүврийн арга зүйг сайжруулах саналыг танилцуулсан байна. Харин Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаанд түүврийн арга зүй, гүйцэтгэлийн үнэлгээг хийгээгүй байна;
- Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.4 болон 4.5-д түүврийн арга зүй, түүврийн дизайны үнэлгээ хийх ижил агуулгатай ажлыг давхардуулан төлөвлөж, уг ажлын хэрэгжилтийг тайлагнахдаа зорилго, агуулга ижил байхад өөр өөр гүйцэтгэлийн хувиар тайлагнасан. Мөн гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.4-т Аж үйлдвэр, барилгын салбарын мэдээ болон мал тооллогын мэдээлэлд түүвэр судалгааны аргыг турших, олон улсын туршлагад тулгуурлан түүвэрлэлт хийж үр дүнг бодит мэдээтэй харьцуулан салбар, дэд салбарын түвшинд хэрэгжүүлэх боломжийг үнэлэхээр төлөвлөсөн боловч Аж үйлдвэр, барилгын салбарын мэдээнд түүврийн аргыг ашигласан бодит туршилт хийгдээгүй байна.

## 8. ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ҮСХ-ны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд “Бүрэн хангалттай” гэж үнэлсэн боловч зарим шалтгааны улмаас шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй 85-95 хувийн хэрэгжилттэй дараах арга хэмжээ байна. Тодруулбал:

- Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.1-д “Статистикийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хууль санаачлагчид хүргүүлж, хуулийн шинэчилсэн найруулгыг сурталчлах” ажлыг тусган төлөвлөсөн. Уг ажлын хүрээнд хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хууль санаачлагчид хүргүүлж, [www.d.parliament.mn](http://www.d.parliament.mn) цахим хуудсанд байршуулан олон нийтийн саналыг авч байна. Статистикийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдаагүй тул хуулийг сурталчлах арга хэмжээг зохион байгуулаагүй байна;
- Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.1-т “Сургалтын цахим системийн ашиглалтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд сургалтын системийн хэрэглэгчдийн үнэлгээг тухай бүр хийлгэж, үр дүнг нэгтгэн танилцуулах”-аар төлөвлөсөн. Энэ хүрээнд үнэлгээний асуулгыг боловсруулж, системд байршуулсан боловч хэрэглэгчдийн үнэлгээний үр дүнг нэгтгэн гаргаж, танилцуулаагүй байна. Мөн төслийн хүрээнд зохион байгуулагдах нэгээс доошгүй сургалтыг системд байршуулахаар бэлтгэлийг хангасан ч зорилтот түвшиндээ хүрээгүй байна;
- Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.4-д “Салбаруудын мэдээ цуглуулалтад цахимд суурилсан программ ашиглалтыг эрчимжүүлж, ААНБ-ын мэдээг шивж оруулах байдлыг нэмэгдүүлэх, статистик тайлан, үр дүнг гаргах, ашиглах боломжтой болгох ажил”-ын хүрээнд ААНБ-ын үйл ажиллагааны жилийн мэдээ, аж үйлдвэр, тээвэр, холбоо, худалдаа, зочид буудал, зоогийн газар, үнийн статистик мэдээний программыг сайжруулж, хэрэглээнд нэвтрүүлсэн байна. ААНБ статистик тайлан, мэдээний үр дүнг харах боломжтой байдлаар программ хангамжийг хөгжүүлж дуусаагүй байна;
- Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.1-т “Чанарын удирдлагын систем бий болгох бэлтгэл хангах, мэдээ, тооллого, судалгааны чанарт хяналт, мониторинг хийх ажил”-ын хүрээнд СҮАЕЗ-ын дагуу чанарын өгөгдлийн санг туршилтаар байгуулах бодлогын даалгаврыг боловсруулж, [gsbrm.app.pso.mn](http://gsbrm.app.pso.mn) системийг хөгжүүлсэн байна. Түүнчлэн мал тооллого, хэрэглээний үнэ, байгаль орчны мэдээ, ӨНЭЗС, АХС-ны мэдээлэл цуглуулалт, чанарт хяналт, мониторинг хийсэн байна. Байгаль орчны статистикийн үнэлгээний үр дүнд үндэслэн байгаль орчны статистик үзүүлэлтүүдийн чанар, хамралтыг сайжруулах талаар холбогдох саналуудыг салбарын сайдад албан бичгээр хүргүүлсэн боловч зорилтот түвшинд хүрээгүй байна

Статистикийн үзүүлэлт, аргачлалыг олон улсын жишигт нийцүүлэн мөрдүүлэх ажлын хүрээнд 2 аргачлал, тооллого, судалгааны 7 үзэл баримтлал, асуулга, маягт нөхөх зааврыг шинээр болон шинэчлэн баталж, 4 тооцоолол, шинжилгээний ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Тухайлбал:

- Байр сууцаар хангах, нийтийн хоолны салбарын статистикийн мэдээний маягт, нөхөх заавар, аргачлалыг шинэчилсэн нь давхардал арилж, мэдээний бодит байдал, чанар сайжирч, аялал жуулчлалын тухай хуульд заасан хүний нөөц, жуулчдын тоо, байр сууцны нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх, улмаар аялал жуулчлалын бодлого, бүсийн нөөц, даац, үйлчилгээ эрхлэгчдийн тоо, байршлыг оновчтой тодорхойлох боломж бүрдсэн байна;
- Барилга байгууламжийн өртгийн мэдээний маягт, нөхөх зааврыг шинэчилснээр барилга байгууламжийн өртгийн индексийг тооцох суурь бүрдэж, барилгын материалын үнийн өөрчлөлт нь барилгын өртөг, зах зээлийн үнэд үзүүлэх нөлөөг тодорхойлон, Засгийн газар болон бизнесийн байгууллагуудын дүн шинжилгээ, төлөвлөлтөд ашиглах боломж бүрдсэн байна;

## 8. ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

- Соёлын өвийн албан ёсны болон захиргааны маягт, нөхөх зааврыг шинээр боловсруулж, баталсан нь холбогдох байгууллагуудын мэдээллийн чанар, уялдаа, холбоо сайжрах, шинжлэх ухааны үндэслэл бүхий нэгдмэл арга зүйд суурилсан үзүүлэлтүүдээр соёлын өвийн статистикийн мэдээллийг цуглуулж, нийтэд тархах, бодлого боловсруулагч болон хэрэглэгчдийг дэлгэрэнгүй мэдээллээр хангах, энэ чиглэлээр мэдээллийн сан үүсгэх боломж бүрдсэн байна;
- Монголбанк, арилжааны банкны орлого, зарлагын мэдээний маягт, нөхөх зааврыг ДНБ-ий хэлхээ индекс болон банкны санхүүгийн тайлагналын аргачлалтай уялдуулан, мэдээллийг илүү дэлгэрэнгүй, стандартчилсан, тогтмол хугацаанд авах зорилгоор шинэчлэн боловсруулсан байна;
- ДНБ-ийг хэлхээ индекс ашиглан зэрэгцүүлэх үнээр тооцох шинэ аргачлалыг боловсруулан баталж, ДНБ-ний 2019-2024 оны улирал, жилийн гүйцэтгэлийг хэлхээ индексийн аргаар туршилтаар тооцсон байна. Ингэснээр бүх салбарын үйлдвэрлэгчийн үнийг шинэчлэх, эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийг тухай бүр тусгах боломжийг бүрдүүлжээ. Жижиг нутаг дэвсгэрийн тооцооллын аргад үндэслэсэн ядуурлын зураглал, хөдөлмөр эрхлэлтийн шинжилгээг боловсруулж, үр дүнг бодлого тодорхойлогч байгууллагуудад танилцуулсан. Мөн гар утасны их өгөгдлийг албан ёсны статистикт ашиглах боломжийг туршиж, дотоод шилжих хөдөлгөөнийг тооцох арга зүйг боловсруулан танилцуулсан. Түүнчлэн Ажиллах хүчний судалгааны түүврийн арга зүй, үзэл баримтлалыг шинэчлэн баталсан байна. Эдгээр ажлууд нь статистикийн тооцоолол, шинжилгээний чанар, нарийвчлалыг сайжруулж, бодлого төлөвлөлт, шийдвэр гаргалтыг нотолгоонд суурилсан мэдээллээр хангах чадавхыг нэмэгдүүлсэн чухал алхам болжээ.

### 8.3 ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭРЭГЦЭЭНИЙ ҮНЭЛГЭЭ

Статистикийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т “Монгол Улсын статистикийн байгууллагын тогтолцоо нь албан ёсны статистикийн үйл ажиллагааг хараат бус, бие даасан байдлаар улс, орон нутгийн хэмжээнд төвлөрүүлэн эрхэлдэг ҮСХ, аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх статистикийн газар, хэлтсээс бүрдэнэ. ...” гэж заасны дагуу аймгийн статистикийн хэлтэст 129, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтэст 59 албан хаагч байна.


Нийслэл, аймаг, дүүргийн статистикийн газар, хэлтэс нь тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд статистикийн мэдээллийг анхан шатны нэгжүүдээс тогтмол, бүрэн, үнэн зөв цуглуулах, нэгтгэн боловсруулах, чанарын хяналт хийх, төв байгууллагад хугацаанд нь дамжуулах үндсэн үүргийг хэрэгжүүлдэг. Статистикийн үйл явц, мэдээллийн чанар, цаг хугацааны шаардлага өндөр байдаг тул орон нутгийн нэгжүүдийн хүний нөөцийн хангалт, чадавх нь статистикийн тогтолцооны найдвартай ажиллагаанд шууд нөлөөлдөг. Иймд Нийслэл, аймаг, дүүргийн статистикийн газар, хэлтсийн хүний нөөцийн хэрэгцээний үнэлгээг хийхээр төлөвлөсөн.

Нийслэл, аймаг, дүүргийн Засаг даргын дэргэдэх статистикийн газар, хэлтэст нийт 188 албан хаагч ажиллах орон тоо батлагдсан байна. Үүнээс 17 орон тоо нөхөгдөөгүй 171 албан хаагч нийслэл, аймаг, дүүргийн Засаг даргын дэргэдэх статистикийн газар, хэлтэст ажиллаж байна.

Нийт ажиллаж байгаа албан хаагчдын 125 (70.2%) албан хаагч Аймгийн статистикийн хэлтэст, 17 (10.5%) албан хаагч Нийслэлийн статистикийн газарт, 36 (19.3%) албан хаагч Дүүргийн статистикийн хэлтэст тус тус ажиллаж байна.



Зураг 48. НИЙСЛЭЛ, АЙМАГ, ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ГАЗАР, ХЭЛТСИЙН АЛБАН ХААГЧДЫН ТОО




Хүснэгт 22. НИЙСЛЭЛ, АЙМАГ, ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ГАЗАР, ХЭЛТСИЙН АЛБАН ХААГЧДЫН ТОО

| Д/д | Албан тушаалын нэр                      | Нийслэлийн статистикийн газар | Дүүргийн статистикийн хэлтэст | Аймгийн статистикийн хэлтэст | Нийт |
|-----|---|-------------------------------|-------------------------------|------------------------------|------|
| 1   | Батлагдсан орон тоо                     | 22                            | 37                            | 129                          | 188  |
| 2   | Үүнээс: Тайлант онд ажилласан хүний тоо | 18                            | 33                            | 120                          | 171  |
| 3   | Газрын дарга                            | 1                             | 0                             | 0                            | 1    |
| 4   | Хэлтсийн дарга                          | 3                             | 8                             | 21                           | 32   |
| 5   | Ахлах мэргэжилтэн                       | 2                             | 8                             | 21                           | 31   |
| 6   | Мэргэжилтэн                             | 11                            | 17                            | 52                           | 80   |
| 7   | Нягтлан бодогч                          | 1                             | 0                             | 21                           | 22   |
| 8   | Зохион байгуулагч                       | 0                             | 0                             | 5                            | 5    |
| 9   | Нэмэлтээр ажиллуулсан хүний тоо         | 20                            | -                             | 84                           | 104  |
| 10  | Гэрээт ажилтан /Судлаач/                | 20                            | 0                             | 61                           | 81   |
| 11  | Гэрээт ажилтан /Жолооч/                 | 0                             | 0                             | 23                           | 23   |

Нийслэл, аймаг, дүүргийн статистикийн газар, хэлтсийн албан хаагчдын статистикийн салбарт ажилласан жилийг авч үзвэл албан хаагчдын 3.4 хувь нь 1 жил хүртэл, 17.6 хувь нь 1-5 жил, 30.1 хувь нь 6-10 жил, 21.0 хувь нь 11-15 жил, 15.3 хувь нь 16-20 жил, 12.5 хувь нь 21-ээс дээш жил ажилласан байна.



Зураг 49. АЛБАН ХААГЧДЫН ТОО, АЖИЛЛАСАН ЖИЛЭЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР



8. ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Мэргэжлийн хувьд 29.5 хувь нь эдийн засагч, 27.8 хувь нь нягтлан бодогч, 23.9 хувь нь статистикч, 6.3 хувь нь банк, санхүү, 4.5 хувь нь бизнесийн удирдлага, менежмент, 8.0 хувь нь бусад төрлийн мэргэжилтэй байна.



Зураг 50. АЛБАН ХААГЧДЫН ТОО, мэргэжлээр, дүнд эзлэх хувиар



Нийслэл, аймаг, дүүргийн статистикийн газар, хэлтсийн үндсэн үйл ажиллагаа болох анхан шатны нэгжээс цуглуулж, боловсруулан нэгтгэж, дамжуулж байгаа мэдээ, тайлан, тооллого, судалгааны маягтын тоог давтамжаар хүснэгт 3-т харууллаа.



Хүснэгт 23. НИЙСЛЭЛ, АЙМАГ, ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ГАЗАР, ХЭЛТСЭЭС ИРҮҮЛДЭГ МЭДЭЭНИЙ ТОО

| Төрөл              | 2023 | 2024 | 2025 |
|--------------------|------|------|------|
| Мэдээ, тайлан      | 55   | 52   | 46   |
| 7 хоног            | 1    | 1    | 1    |
| 14 хоног           | 1    | 1    | -    |
| Сар                | 17   | 15   | 13   |
| Улирал             | 21   | 17   | 15   |
| Жил                | 15   | 18   | 17   |
| Тооллого, судалгаа | 7    | 5    | 9    |

Дээрх хүснэгтээс харахад сар, улирал, жилийн давтамжтай цуглуулдаг мэдээ, тайлангийн тоо тогтмол буурч байна. Энэ нь ҮСХ-оос мэдээлэл цуглуулах үйл ажиллагааг цахимжуулах, автоматжуулах, их өгөгдөл болон хиймэл оюун ухаанд суурилсан технологийн шийдлийг нэвтрүүлсэнтэй холбоотой юм.



Хүснэгт 24. ЖИЛД МЭДЭЭ АВЧ БАЙГАА ААНБ-ЫН ТОО, АЙМГААР

| Д/д | Нэрс        | Нийт ААНБ-ын тоо* | Аж үйлдвэр   | Бизнес регистр | ХАА          | НЗУ        | Худалдаа  | Үнэ          | БСНХ       | Барилга      | Тээвэр холбоо | Бусад         |
|-----|-------------|-------------------|--------------|----------------|--------------|------------|-----------|--------------|------------|--------------|---------------|---------------|
| 1   | Архангай    | 4,130             | 32           | 725            | 254          | 19         | 1         | 53           | 31         | 111          | 6             | 398           |
| 2   | Баян-Өлгий  | 4,171             | 81           | 673            | 277          | 13         | 1         | 47           | 11         | 189          | 13            | 486           |
| 3   | Баянхонгор  | 3,708             | 81           | 268            | 217          | 20         | 1         | 52           | 8          | 58           | 18            | 447           |
| 4   | Булган      | 3,391             | 33           | 297            | 377          | 16         | 1         | 48           | 11         | 154          | 6             | 343           |
| 5   | Говь-Алтай  | 3,515             | 82           | 260            | 177          | 18         | 0         | 54           | 6          | 124          | 3             | 302           |
| 6   | Говьсүмбэр  | 1,030             | 18           | 31             | 40           | 3          | 0         | 22           | 5          | 42           | 6             | 165           |
| 7   | Дархан-Уул  | 5,088             | 95           | 243            | 161          | 4          | 1         | 46           | 25         | 347          | 20            | 923           |
| 8   | Дорноговь   | 4,339             | 66           | 89             | 166          | 14         | 2         | 47           | 32         | 243          | 29            | 546           |
| 9   | Дорнод      | 3,824             | 36           | 583            | 243          | 14         | 0         | 48           | 9          | 130          | 12            | 611           |
| 10  | Дундговь    | 3,055             | 52           | 321            | 145          | 15         | 0         | 43           | 12         | 119          | 2             | 301           |
| 11  | Завхан      | 5,227             | 144          | 232            | 321          | 24         | 0         | 62           | 35         | 124          | 12            | 464           |
| 12  | Орхон       | 6,075             | 118          | 1613           | 92           | 2          | 2         | 42           | 32         | 175          | 23            | 1026          |
| 13  | Өвөрхангай  | 5,624             | 148          | 488            | 384          | 19         | 0         | 56           | 22         | 332          | 15            | 544           |
| 14  | Өмнөговь    | 5,434             | 93           | 465            | 172          | 15         | 0         | 68           | 26         | 623          | 5             | 804           |
| 15  | Сүхбаатар   | 3,077             | 70           | 106            | 193          | 13         | 1         | 47           | 24         | 103          | 3             | 350           |
| 16  | Сэлэнгэ     | 5,887             | 87           | 478            | 841          | 17         | 5         | 58           | 20         | 359          | 9             | 680           |
| 17  | Төв         | 5,576             | 72           | 474            | 954          | 27         | 0         | 66           | 19         | 137          | 11            | 464           |
| 18  | Увс         | 4,848             | 108          | 802            | 369          | 19         | 2         | 59           | 17         | 84           | 11            | 514           |
| 19  | Ховд        | 3,644             | 55           | 350            | 163          | 17         | 1         | 53           | 10         | 84           | 10            | 633           |
| 20  | Хөвсгөл     | 4,497             | 72           | 107            | 292          | 23         | 0         | 62           | 20         | 197          | 17            | 589           |
| 21  | Хэнтий      | 3,656             | 56           | 149            | 268          | 18         | 3         | 51           | 23         | 110          | 10            | 420           |
| 22  | Нийслэл     | 70,486            | 648          | 27177          | 3446         | 9          | 68        | 694          | 154        | 2026         | 356           | 10615         |
|     | <b>НИЙТ</b> | <b>160,282</b>    | <b>2,247</b> | <b>35,931</b>  | <b>9,552</b> | <b>339</b> | <b>89</b> | <b>1,778</b> | <b>552</b> | <b>5,871</b> | <b>597</b>    | <b>21,625</b> |

Тайлбар: \*Мэдээний давтамжийн тоогоор үржүүлж нийт ААНБ-ын тоог гаргасан болно.

Анхан шатны нэгжээс цуглуулах мэдээ, тайлангийн тоо буурсан ч энэ нь тэдний ачаалал багассан гэсэн үг биш. Учир нь нийгэм, эдийн засгийн талаар илүү нарийвчилсан мэдээлэл шаарддаг болсон тул сүүлийн жилүүдэд хийгдэх судалгааны тоо, хүрээ нэмэгдсээр байна. Мөн тухайн орон нутгийн бодлого боловсруулагчдыг үнэн зөв, богино хугацаанд бэлтгэсэн, олон улсын стандарт, арга зүйд нийцсэн, харьцуулагдахуйц нарийвчилсан тоон мэдээллээр хангах хэрэгцээ өсөж буй нь анхан шатны нэгжийн ачааллыг нэмэгдүүлж байна

Салбарын түвшинд дата анализ хийх, их өгөгдөл боловсруулах, машин сургалтын чиглэлийн орчин үеийн чадвар өндөртэй хүний нөөцийн хэрэгцээ эрс өсөж буй энэ үед орон нутагт ажиллаж байгаа статистикийн албан хаагчдын мэргэжил нь өнөөгийн статистикийн салбарын дэвшилтэт технологид суурилсан ур чадварын хэрэгцээг бүрэн хангахад хангалтгүй байна.

Иймд дата анализ хийх, их өгөгдөлтэй ажиллахад шаардлагатай статистикийн шинжилгээний программыг ашиглах чадварыг эзэмшүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг тодорхойлох зорилгоор "Статистикийн салбарын албан хаагчдад чиглэсэн сургалтын 2025 оны төлөвлөгөө"-нөөс сургалтын агуулга, зорилтот бүлгийг авч үзлээ. Эндээс харахад тусгайлсан ур чадвар олгох сургалтын агуулгад дата анализ хийх, их өгөгдөлтэй ажиллахад шаардлагатай статистикийн шинжилгээний программын


сургалтыг зөвхөн ҮСХ-ны ТӨШГ болон НИСГ-ын ӨССХ-ийн албан хаагчдад зориулан явуулахаар тусгасан байна.

Үүнээс гадна статистик мэдээллийн чанарын хяналтыг сайжруулах хүрээнд 2022 онд "Анхдагч мэдээллийн чанарыг сайжруулах багц журам"-ыг батлан мөрдүүлж эхэлсэн. Энэхүү журмын дагуу мэдээлэл цуглуулах, шалгах, боловсруулах, дамжуулах, нэгтгэх үйл явцыг илүү нарийвчлан баримтжуулж, бүртгэл, хяналт, тайлагнах үйл ажиллагааны чанарыг сайжруулах байна.

Аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн албан хаагчид нь Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан албан тушаалын цалингаар цалинжиж байна.

Статистикийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т "Монгол Улсын статистикийн байгууллагын тогтолцоо нь албан ёсны статистикийн үйл ажиллагааг хараат бус, бие даасан байдлаар улс, орон нутгийн хэмжээнд төвлөрүүлэн эрхэлдэг **ҮСХ, аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх статистикийн газар, хэлтсээс бүрдэнэ.** ..." гэж заасан тул аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн албан хаагчид нь аймаг, нийслэлийн Засаг даргын эрхлэх хүрээний нутгийн захиргааны байгууллагад хамаарч байна.

Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 487 дугаар тогтоолоор төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн баталж, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн. Аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн албан хаагчдын албан тушаалын зэрэглэлийг аймаг, нийслэл, сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчидтай харьцуулж, хүснэгт 4-т харуулав.

 Хүснэгт 25. АЛБАН ТУШААЛЫН ЗЭРЭГЛЭЛ

| №   | Байгууллагын нэр                                  | Төрийн захиргааны албан тушаалын зэрэглэл |                   |             |
|-----|---|---|-------------------|-------------|
|     |   | Албан тушаал                              |                   |             |
|     |   | Хэлтсийн дарга                            | Ахлах мэргэжилтэн | Мэргэжилтэн |
|     |   | Нийслэл                                   |                   |             |
| 1.1 | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар              | ТЗ-3                                      | ТЗ-6              | ТЗ-7        |
| 1.2 | Нийслэлийн статистикийн газар                     | ТЗ-4                                      | ТЗ-7              | ТЗ-8        |
|     |   | Аймаг                                     |                   |             |
| 2.1 | Аймгийн Засаг даргын Тамгын газар                 | ТЗ-4                                      | ТЗ-7              | ТЗ-8        |
| 2.2 | Сумын төрийн сангийн мэргэжилтэн                  | -   | -                 | ТЗ-8        |
| 2.3 | Аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс | ТЗ-4                                      | ТЗ-8              | ТЗ-9        |
| 2.4 | Сумын Тамгын газрын мэргэжилтэн                   | -   | -                 | ТЗ-9        |

Хүснэгтээс харахад Нийслэлийн статистикийн газрын дарга, хэлтсийн дарга болон Аймгийн статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, мэргэжилтнүүд нь тухайн шатны Засаг даргын Тамгын газрын албан хаагчдаас 1 зэрэглэл доогуур байна. Мөн Аймгийн статистикийн хэлтсийн мэргэжилтнүүд нь аймгийн Засаг даргын тамгын газрын бусад ажилтнууд болон сумын төрийн сангийн мэргэжилтнээс 1 зэрэглэл доогуур, сумын Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэнтэй адил зэрэглэлээр цалинжиж байна.

Мөн үүнээс гадна аймгийн Засаг даргын тамгын газар, сумын Засаг даргын тамгын газрын ажилтнуудаас бага урамшуулал авч байна. Тухайлбал:

Дээрх албан тушаалын ангилал зэрэглэл, урамшууллын ялгаатай байдлаас шалтгаалан статистикийн салбарын мэргэшсэн албан хаагчид нь бусад төрийн байгууллага (аймгийн Засаг даргын тамгын газар, сумын Засаг даргын тамгын газар)-д шилжин ажиллах тохиолдол нэмэгдэж байна.

8. ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ҮСХ-ны орон нутаг дахь нэгжийн албан хаагчийн албан тушаалын цалин, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын ижил албан тушаал эрхэлж байгаа албан хаагчийн албан тушаалын цалинг харьцуулан хүснэгт 5-д, цалингийн тооцооллыг (орон нутгийн нэмэгдэл, үр дүнгийн урамшуулал зэргийг оруулаагүй) хавсралт 2-т харуулав.



Хүснэгт 26. ТУХАЙН ШАТНЫ ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ИЖИЛ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИН БОЛОН НИЙТ ЦАЛИНГИЙН ЗӨРҮҮ

| №  | Албан тушаал      | Албан тушаалын цалингийн зөрүү, төгрөгөөр |           | Нийт цалин, /төгрөг/ <sup>3</sup> |           |
|--|-------------------|---|-----------|-----------------------------------|-----------|
|  |                   | сард                                      | жилд      | сард                              | жилд      |
| Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын ижил албан тушаалын цалингаас дараах хэмжээгээр бага                                   |                   |   |           |                                   |           |
| 1  | Хэлтсийн дарга    | 122,000                                   | 1,464,000 | 170,800                           | 2,049,600 |
| 2  | Ахлах мэргэжилтэн | 154,000                                   | 1,848,000 | 203,280                           | 2,439,360 |
| 3  | Мэргэжилтэн       | 140,000                                   | 1,680,000 | 184,800                           | 2,217,600 |
| Аймгийн Засаг даргын Тамгын газрын ижил албан тушаалын цалингаас дараах хэмжээгээр бага                                      |                   |   |           |                                   |           |
| 4  | Хэлтсийн дарга    | -   | -         | -                                 | -         |
| 5  | Ахлах мэргэжилтэн | 140,000                                   | 1,680,000 | 184,800                           | 2,217,600 |
| 6  | Мэргэжилтэн       | 116,000                                   | 1,392,000 | 153,120                           | 1,837,440 |
| Аймгийн статистикийн хэлтсийн мэргэжилтэн, сумын төрийн сангийн мэргэжилтний албан тушаалын цалингаас дараах хэмжээгээр бага |                   |   |           |                                   |           |
| 7  | Мэргэжилтэн       | 116,000                                   | 1,392,000 | 153,120                           | 1,837,440 |

Аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн албан хаагчийн албан тушаалын цалин нь тухайн шатны Засаг даргын Тамгын газрын ижил албан тушаалын цалингаас дараах хэмжээгээр бага байна. Үүнд:

- Нийслэлийн статистикийн газрын хэлтсийн даргын хувьд албан тушаалын цалингийн зөрүү сард 122.0 мянган төгрөг, жилд 1,464.0 мянган төгрөг, төрийн алба хаасан хугацаа болон зэрэг дэвийн нэмэгдлийг дунджаар тооцоход нийт цалингийн зөрүү сард 170.8 мянган төгрөг, жилд 2,049.6 мянган төгрөгөөр бага;
- Нийслэлийн статистикийн газрын ахлах мэргэжилтний хувьд албан тушаалын цалингийн зөрүү сард 154.0 мянган төгрөг, жилд 1,848.0 мянган төгрөг, төрийн алба хаасан хугацаа болон зэрэг дэвийн нэмэгдлийг дунджаар тооцоход нийт цалингийн зөрүү сард 203.3 мянган төгрөг, жилд 2,439.4 мянган төгрөгөөр бага;
- Нийслэлийн мэргэжилтэн, аймгийн ахлах мэргэжилтний хувьд албан тушаалын цалингийн зөрүү сард 140.0 мянган төгрөг, жилд 1,680.0 мянган төгрөгөөр, төрийн алба хаасан хугацаа болон зэрэг дэвийн нэмэгдлийг дунджаар тооцоход нийт цалингийн зөрүү сард 184.8 мянган төгрөг, жилд 2,217.6 мянган төгрөгөөр бага;
- Аймгийн мэргэжилтний хувьд албан тушаалын цалингийн зөрүү сард 116.0 мянган төгрөг, жилд 1,392.0 мянган төгрөгөөр, төрийн алба хаасан хугацаа болон зэрэг дэвийн нэмэгдлийг дунджаар тооцоход нийт цалингийн зөрүү сард 153.1 мянган төгрөг, жилд 1,837.4 мянган төгрөгөөр бага байна. Мөн сумын төрийн сангийн мэргэжилтнээс дээрх хэмжээгээр бага байна.

<sup>3</sup> Нийт цалинг тооцохдоо албан хаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 10 хувиар, зэрэг дэвийн нэмэгдлийг тухайн албан тушаалын ангиллын дэд зэргээр тооцсон.

8. ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

УИХ-аас удирдлага нь томилогддог, аймаг, нийслэл, дүүрэгт нэгжтэй ҮСХ, Үндэсний Аудитын Газар (цаашид ҮАГ гэх)-ын албан хаагчдын цалинг харьцуулахад ҮАГ-ын ижил албан тушаалын цалингаас дараах хэмжээгээр бага байна. Цалингийн тооцооллыг хавсралт 3-т харуулав.



**Хүснэгт 27. УИХ-ААС УДИРДЛАГА НЬ ТОМИЛОГДДОГ, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮҮРЭГТ НЭГЖТЭЙ ҮСХ, ҮАГ-ЫН АЛБАН ХААГЧДЫН ИЖИЛ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИН БОЛОН НИЙТ ЦАЛИНГИЙН ЗӨРҮҮ**

| № | Албан тушаал  | Албан тушаалын цалингийн зөрүү, төгрөгөөр |            | Нийт цалин, /төгрөг/ <sup>4</sup> |            |
|---|---|---|------------|-----------------------------------|------------|
|   |   | сард                                      | жилд       | сард                              | жилд       |
| 1 | Орон нутгийн газрын дарга                                 | 1,009,000                                 | 12,108,000 | 1,412,600                         | 16,951,200 |
| 2 | Орон нутгийн хэлтсийн дарга                               | 987,000                                   | 11,844,000 | 1,381,800                         | 16,581,600 |
| 3 | Нийслэлийн ахлах мэргэжилтэн/ахлах аудитор, ахлах шинжээч | 1,317,000                                 | 15,804,000 | 1,738,440                         | 20,861,280 |
| 4 | Аймгийн ахлах мэргэжилтэн/ахлах аудитор, ахлах шинжээч    | 1,457,000                                 | 17,484,000 | 1,923,240                         | 23,078,880 |
| 5 | Нийслэлийн мэргэжилтэн/аудитор, шинжээч                   | 1,157,000                                 | 13,884,000 | 1,527,240                         | 18,326,880 |
| 6 | Аймгийн мэргэжилтэн/аудитор, шинжээч                      | 1,273,000                                 | 15,276,000 | 1,680,360                         | 20,164,320 |

ҮСХ-ны орон нутаг дахь нэгжийн албан хаагчдын албан тушаалын цалин нь ҮАГ-ын орон нутаг дахь нэгжийн ижил албан тушаалын цалингаас дараах хэмжээгээр бага байна. Үүнд:

- Газрын даргын хувьд албан тушаалын цалингийн зөрүү сард 1,009.0 мянган төгрөг, жилд 12,108.0 мянган төгрөгөөр, төрийн алба хаасан хугацаа болон зэрэг дэвийн нэмэгдлийг дунджаар тооцоход нийт цалингийн зөрүү сард 1,412.6 мянган төгрөг, жилд 16,951.2 мянган төгрөгөөр бага;
- Хэлтсийн даргын хувьд албан тушаалын цалингийн зөрүү сард 987.0 мянган төгрөг, жилд 11,844.0 мянган төгрөгөөр, төрийн алба хаасан хугацаа болон зэрэг дэвийн нэмэгдлийг дунджаар тооцоход нийт цалингийн зөрүү сард 1,381.8 мянган төгрөг, жилд 16,581.6 мянган төгрөгөөр бага;
- Нийслэлийн ахлах мэргэжилтний хувьд албан тушаалын цалингийн зөрүү сард 1,317.0 мянган төгрөг, жилд 15,804.0 мянган төгрөгөөр, төрийн алба хаасан хугацаа болон зэрэг дэвийн нэмэгдлийг дунджаар тооцоход нийт цалингийн зөрүү сард 1,738.4 мянган төгрөг, жилд 20,861.3 мянган төгрөгөөр бага;
- Аймгийн ахлах мэргэжилтний хувьд албан тушаалын цалингийн зөрүү сард 1,457.0 мянган төгрөг, жилд 15,804.0 мянган төгрөгөөр, төрийн алба хаасан хугацаа болон зэрэг дэвийн нэмэгдлийг дунджаар тооцоход нийт цалингийн зөрүү сард 1,923.2 мянган төгрөг, жилд 23,078.9 мянган төгрөгөөр бага;
- Нийслэлийн мэргэжилтний хувьд албан тушаалын цалингийн зөрүү сард 1,157.0 мянган төгрөг, жилд 13,884.0 мянган төгрөгөөр, төрийн алба хаасан хугацаа болон зэрэг дэвийн нэмэгдлийг дунджаар тооцоход нийт цалингийн зөрүү сард 1,527.2 мянган төгрөг, жилд 18,326.9 мянган төгрөгөөр бага;
- Аймгийн мэргэжилтний хувьд албан тушаалын цалингийн зөрүү сард 1,273.0 мянган төгрөг, жилд 15,276.0 мянган төгрөгөөр, төрийн алба хаасан хугацаа болон зэрэг дэвийн нэмэгдлийг дунджаар тооцоход нийт цалингийн зөрүү сард 1,680.4 мянган төгрөг, жилд 20,164.3 мянган төгрөгөөр тус тус бага байна.

4 Нийт цалинг тооцоходоо албан хаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 10 хувиар, зэрэг дэвийн нэмэгдлийг тухайн албан тушаалын ангиллын дэд зэргээр тооцсон.

Дээрхээс дүгнэхэд аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх статистикийн газар, хэлтсийн албан хаагчдын албан тушаалын цалингийн хэмжээ нь харьцуулсан байгууллагуудын ижил албан хаагчдын албан тушаалын цалингаас хэт бага байгаа нь мэргэжлийн, мэргэшсэн албан хаагчдаа алдах эрсдэлийг бий болгож байна.

## 8.4 САНХҮҮ, ТӨСВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭ

### Төсвийн төлөвлөлт:

ҮСХ нь 2025 оны төсвийн саналаа боловсруулж, хуулийн хугацаанд Сангийн яаманд 34.8 тэрбум төгрөгөөр төсөвлөн хүргүүлснийг 4.9 тэрбум төгрөгөөр бууруулж, 29.9 тэрбум төгрөгөөр баталсан байна.

ҮСХ-ны 2025 оны батлагдсан 29.9 тэрбум төгрөгийн төсвийг өмнөх оны төсөвтэй харьцуулахад 8.7 тэрбум төгрөг буюу 29 хувиар нэмэгдсэн байна. Энэ нь цалингийн зардлын өсөлт болон 2025 онд Хүн ам орон сууцны тооллогын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь "ээлжит тооллого хооронд 5 жил тутамд явуулах завсрын тооллого" заалтын дагуу завсрын тооллогыг зохион байгуулсантай холбоотой байна.

### Төсвийн гүйцэтгэл:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн батлагдсан төсвийн 17.9 тэрбум төгрөг (59.9%)-ийг үндсэн цалин, нэмэгдэл, урамшуулал, даатгалын зардал, 9.0 тэрбум төгрөг (30.1%)-ийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, 1.2 тэрбум төгрөг (4%)-ийг бусад зардал, 1.8 тэрбум төгрөг (6%)-ийг хөрөнгийн зардал тус тус эзэлж байна.

ҮСХ-ны хэмжээнд 2025 онд батлагдсан төсвөөс 27.5 тэрбум төгрөгийг зарцуулж, 2.4 тэрбум төгрөгийн зардлыг хэмнэж ажилласан байна.

Нийт зардлын 29 хувийг (8.0 тэрбум төгрөг) тооллого, түүвэр судалгааны зардал эзэлж байна.

ҮСХ-ны орон нутаг дахь нэгжүүд нь өөрийн эзэмшлийн ажлын байргүй орон нутаг дахь төр захиргааны болон түрээсийн байранд үйл ажиллагаагаа явуулж байна. Түрээсийн байранд үйл ажиллагаа явуулж байгаа Говь-Алтай, Өмнөговь аймгийн статистикийн хэлтсүүд нь ашиглалтын зардалд 49.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

### Худалдан авах ажиллагаа:

ҮСХ-ны хэмжээнд 2025 онд 3,605.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 21 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөгөө боловсруулан батлуулж, [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим хуудаст байршуулжээ.

#### Улсын төсвийн хөрөнгө оруулалт:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2,000.0 сая төгрөгийг төсөвт өртөг бүхий 3 багц тендерийн худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 1,804.0 сая төгрөгийн гэрээ байгуулж, 202.1 сая төгрөгийн тендерийн хэмнэлтийг бий болгосон байна. Мөн хугацаандаа нийлүүлээгүй 1 гүйцэтгэгчээс 6.5 сая төгрөгийн алданги тооцон суутгажээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалт нь батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдаж бүрэн хэрэгжиж дууссан бөгөөд статистикийн салбарын чадавхыг бэхжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулан, ҮСХ-ны болон орон нутгийн салбар нэгжүүдийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэж чаджээ.

#### Урсгал болон төслийн санхүүжилт:

Улсын төсвийн урсгал болон төслийн санхүүжилтээр 1,605.9 сая төгрөгийн 20 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөсөн боловч "Төрийн болон орон нутгийн өмчийн

хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 30 дугаар зүйлийн 30.5-д заасан нөхцөл байдал үүсэж, 199.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 4 төсөл, арга хэмжээнд гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах боломжгүй болж, 1,406.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 16 төсөл, арга хэмжээнд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, 1,312.3 сая төгрөгийн гэрээ байгуулж, 94.5 сая төгрөгийн тендерийн хэмнэлтийг бий болгон ажиллажээ.

## 8.5 ДҮГНЭЛТ

Системчилсэн үнэлгээний үр дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- ҮСХ нь хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд олон улсын статистикийн байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандартын дагуу бодит байдалд нийцсэн чанартай, албан ёсны статистикийн мэдээллээр хэрэглэгчдийг шуурхай хангах үүргээ хангалттай сайн биелүүлсэн байна;
- ҮСХ нь тооллого, судалгааны мэдээлэл цуглуулалтыг цахимжуулах, мэдээлэл боловсруулалтын үйл ажиллагаанд их өгөгдөл болон хиймэл оюуны дэвшилтэт технологи ашиглах замаар статистик мэдээллийн чанар, хүртээмж, бодит байдлыг дээшлүүлэх чиглэлээр арга хэмжээг хэрэгжүүлжээ. Тухайлбал:
  - Төрийн 15 байгууллагын суурь болон төрөлжсөн мэдээллийн санг ашиглан “Хүн ам, орон сууцны 2025 оны завсрын тооллого”-ыг анх удаа бүртгэлд суурилсан хэлбэрээр зохион байгуулсан байна;
  - Мал тооллогод малын зургийг төрлөөр нь ялган тэмдэглэж, машин сургалтын туршилтын программыг хөгжүүлэн, 2025 оны мал тооллогын хяналтад ашигласан байна;
  - Хиймэл оюунд суурилсан статистикийн чатбот (MonStatGPT) нэвтрүүлж, хэрэглэгчдэд статистик мэдээллийг шуурхай, ойлгомжтой, хялбар хүргэх боломжийг бүрдүүлсэн байна;
- ҮСХ-ны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 92.7 хувьтай байгаа ба Засгийн Газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын дагуу үнэлэхэд 18 ажил бүрэн хангалттай, 4 ажил хангалттай үнэлэгдсэн байна;
- Статистикийн үзүүлэлт, аргачлалыг олон улсын жишигт нийцүүлэн мөрдүүлэх ажлын хүрээнд 2 аргачлал, тооллого, судалгааны 7 үзэл баримтлал, асуулга, маягт нөхөх зааврыг шинээр болон шинэчлэн баталж, 4 тооцоолол, шинжилгээний ажлыг хийж гүйцэтгэсэн байна;
- “Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо”-ны ISO 27001:2022 олон улсын стандартын баталгаажуулалтын гэрчилгээг шинэчлэн сунгуулж, МАБМТ-ны хэрэгжилтийг олон улсын шаардлагын дагуу тогтвортой, тасралтгүй ханган ажилласан байна;
- Статистикийн мэдээллийн нэгдсэн сан [www.1212.mn](http://www.1212.mn) цахим хуудсыг бүрэн шинэчилж, нээлттэй эх үүсвэрт шилжүүлснээр системийн тогтвортой байдлыг сайжруулан, мэдээлэл авах хурдыг 10 дахин нэмэгдүүлсэн байна;
- Олон улсын болон гадаадын статистикийн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ, харилцан ойлголцлын санаамж бичиг байгуулж, гадаад харилцаагаа өргөжүүлж ажилласан нь Статистикийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, статистикийн үзүүлэлт, арга зүйг боловсронгуй болгох, албан ёсны статистикийн мэдээллийг эрхлэн гаргахад шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх, дэд бүтцийг хөгжүүлэх, сайн туршлагыг нэвтрүүлэх, үндэсний статистикийн системийн албан хаагчдыг чадавхжуулах, олон улсад Монгол Улсын нэр хүндийг өргөх зэрэг олон талын ач холбогдолтой байна;


## 8. ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

- ҮСХ-ны аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх газар, хэлтсийн албан хаагчдын албан тушаалын цалин УИХ-аас удирдлага нь томилогддог орон нутагт нэгжтэй ҮАГ-ын ижил албан тушаалын цалинтай харьцуулахад нийт цалин сард 1,381.8-1,923.2 мянган төгрөгөөр, жилд 16,581.6-23,078.9 мянган төгрөгөөр, тухайн шатны Засаг даргын Тамгын газрын ижил албан тушаалын цалинтай харьцуулахад нийт цалин сард 153.1-203.3 мянган төгрөг, жилд 1,837.4-2,439.4 мянган төгрөгөөр тус тус бага байна.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалт нь батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдаж бүрэн хэрэгжиж дууссан бөгөөд статистикийн салбарын чадавхыг бэхжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулан, ҮСХ-ны болон орон нутгийн салбар нэгжүүдийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэж чаджээ.

### 8.6 САНАЛ

Системчилсэн үнэлгээний үр дүнд үндэслэн дараах саналыг байгууллагын удирдлагад хүргүүлж байна. Үүнд:

1. Статистикийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн статусыг УИХ-аас удирдлага нь томилогддог байгууллагын жишигт нийцүүлэн өөрчлөх, ажлын хүрээ, ачаалалд нь дүйцсэн цалин олгож, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх боломжийг судлан шийдвэрлэх;
2. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан ажлыг бүрэн гүйцэтгэхэд анхаарч ажиллах;
3. ҮСХ, аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн ажилтнуудын дата анализ хийх, их өгөгдөлтэй ажиллах чадварыг нэмэгдүүлэх, энэ чиглэлийн сургалтуудыг үе шаттайгаар зохион байгуулах.



# ХАВСРАЛТ


**Хавсралт 1. УСХ-ООС ШИНЭЭР БОЛОН ШИНЭЧЛЭН БАТАЛЖ МӨРДҮҮЛСЭН АРГАЧЛАЛ, АНГИЛАЛ, МАЯГТ, АСУУЛГА, НӨХӨХ ЗААВАР, ТҮҮВРИЙН ДИЗАЙН**

| №   | Арга зүйн баримт бичгийн нэр   | Тайлбар  |
|---|--|----------|
| <b>А. Аргачлал</b>  |  |          |
| 1   | Байр сууцаар хангах, нийтийн хоолны салбарын статистик үзүүлэлтийг тооцох аргачлал   | Шинэ     |
| 2   | Дотоодын нийт бүтээгдэхүүнийг хэлхээ индекс ашиглан зэрэгцүүлэх үнээр тооцох аргачлал  | Шинэ     |
| 3   | Хүний хөгжлийн индекс тооцох аргачлал  | Шинэчлэн |
| <b>Б. Ангилал</b>   |  |          |
| 1   | Гэмт хэргийн үндэсний ангилал  | Шинэ     |
| <b>В. Үзэл баримтлал, асуулга, маягт нөхөх заавар</b>         |  |          |
| 1   | Байр сууцаар хангах, нийтийн хоолны үйл ажиллагаа эрхэлдэг ААНБ, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн орлогын сарын мэдээний маягт, заавар         | Шинэ     |
| 2   | Хүн ам, орон сууцны завсрын тооллогын үзэл баримтлал, асуулга, нөхөх заавар  | Шинэчлэн |
| 3   | Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2026 онд мөрдөх дэлгэрэнгүй судалгааны үзэл баримтлал, асуулга, заавар                             | Шинэчлэн |
| 4   | Ажиллах хүчний судалгааны үзэл баримтлал   | Шинэчлэн |
| 5   | Албан бус сектор буюу Хувиараа хөдөлмөр эрхлэлтийн 2025 оны судалгааны үзэл баримтлал, асуулга, заавар                                     | Шинэчлэн |
| 6   | Нөөц, ашиглалтын хүснэгт, салбар хоорондын тэнцлийг 2024 оны гүйцэтгэлээр байгуулах суурь судалгааны үзэл баримтлал, асуулга, нөхөх заавар | Шинэчлэн |
| 7   | Барилга байгууламжийн өртгийн мэдээний маягт, нөхөх заавар   | Шинэчлэн |
| 8   | Соёлын өвийн албан ёсны болон захиргааны маягт, нөхөх заавар   | Шинэчлэн |
| 9   | Хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтэр   | Шинэчлэн |
| 10  | Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны албан ёсны болон захиргааны маягт, нөхөх заавар  | Шинэчлэн |
| 11  | Мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн тооллогын асуулга, нөхөх заавар  | Шинэчлэн |
| 12  | Харилцаа холбооны салбарын мэдээний маягт, нөхөх заавар  | Шинэчлэн |
| 13  | Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийн албан ёсны статистикийн маягт, маягт нөхөх заавар                                       | Шинэ     |
| 14  | Дотоодын жуулчдын түүвэр судалгааны үзэл баримтлал, маягт заавар   | Шинэ     |
| <b>Г. Гарын авлага, заавар</b>                                |  |          |
| 1   | Статистикийн хэвлэмэл бүтээгдэхүүн бэлтгэх заавар  | Шинэчлэн |
| 2   | Хүн ам, өрхийн мэдээллийн санг хөтлөх, ашиглахад баримтлах журам   | Шинэчлэн |
| 3   | Мета өгөгдлийг нэгтгэх, ашиглах гарын авлага   | Шинэ     |
| <b>Д. Судалгаа, тооцоолол, үнэлгээний үр дүн, танилцуулга</b> |  |          |
| 1   | Жижиг нутаг дэвсгэрийн шинжилгээ: Монгол Улсын ядуурал ба хөдөлмөр эрхлэлтийн зураглал   |          |
| 2   | Монгол Улсын нийгмийн халамжийн арга хэмжээний ядуурал, тэгш бус байдлыг бууруулахад үзүүлж буй нөлөөллийн судалгаа                        |          |
| <b>Е. Түүвэр судалгааны дизайн</b>                            |  |          |
| 1   | 2025 оны хагас жилийн мал тооллого   |          |
| 2   | Дотоодын жуулчдын зардлын судалгаа   |          |
| 3   | Ажиллах хүчний 2026 оны судалгаа   |          |
| 4   | Өрхийн нийгэм, эдийн засгийн 2026 оны судалгаа   |          |
| 5   | Гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгаа   |          |
| 6   | Мэргэжлээс шалтгаалах өвчний судалгаа  |          |



Хавсралт 2. СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГААР ТАРХААЖ БУЙ ҮЗҮҮЛЭЛТ

| Бүлэг                 | Дэд бүлэг   | Үзүүлэлт   |
|-----------------------|---|------------|
| <b>Бүлэг I</b>        |   |            |
| Хүн ам, өрх           | Хүн ам, өрх                                       | 27         |
|                       | Хүн амын ердийн хөдөлгөөн                         | 40         |
|                       | Малчид  | 6          |
|                       | Хүн амын дэд бүтэц, орон сууц                     | 9          |
|                       | Хүн амын хэтийн тооцоо                            | 3          |
|                       | Засаг захиргаа, нутаг дэвсгэр                     | 4          |
|                       | <b>Бүгд</b>                                       | <b>89</b>  |
| <b>Бүлэг II</b>       |   |            |
| Нийгэм, хөгжил        | Хөгжлийн бэрхшээл                                 | 9          |
|                       | Сонгууль  | 5          |
|                       | Хүнсний аюулгүй байдал                            | 8          |
|                       | Жендэр  | 27         |
|                       | Өрхийн орлого, зарлага                            | 21         |
|                       | Хүний хөгжлийн индекс                             | 7          |
|                       | Хууль эрх зүй, гэмт хэрэг                         | 49         |
|                       | Мянганы хөгжлийн зорилтын шалгуур үзүүлэлтүүд     | 81         |
|                       | Сүм хийд  | 3          |
|                       | Ядуурал, тэгш бус байдал, амьжиргааны доод түвшин | 11         |
|                       | Нийгмийн даатгал, халамж                          | 33         |
|                       | Тогтвортой хөгжлийн зорилго                       | 1          |
|                       | <b>Бүгд</b>                                       | <b>255</b> |
| <b>Бүлэг III</b>      |   |            |
| Хөдөлмөр, бизнес      | Төрийн албан хаагчид                              | 6          |
|                       | Зохистой хөдөлмөр                                 | 23         |
|                       | Хөдөлмөр  | 30         |
|                       | Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ                     | 6          |
|                       | Статистикийн бизнес регистр                       | 27         |
|                       | Цалин   | 9          |
|                       | <b>Бүгд</b>                                       | <b>101</b> |
| Үйлдвэрлэл, үйлчилгээ | Газар тариалан                                    | 21         |
|                       | Барилга   | 8          |
|                       | Соёл, соёлын бүтээлч үйлдвэрлэл                   | 10         |
|                       | Аж үйлдвэр  | 17         |
|                       | Оюуны өмч   | 12         |
|                       | Мал аж ахуй                                       | 19         |
|                       | Шинжлэх ухаан                                     | 2          |
|                       | Харилцаа холбоо                                   | 5          |
|                       | Аялал жуулчлал                                    | 14         |
|                       | Худалдаа, зочид буудал, нийтийн хоол              | 6          |
|                       | Тээвэр  | 10         |
|                       | <b>Бүгд</b>                                       | <b>124</b> |

| Бүлэг                            | Дэд бүлэг                          | Үзүүлэлт   |
|----------------------------------|------------------------------------|------------|
| <b>Бүлэг V</b>                   |                                    |            |
| Эдийн засаг,<br>байгаль<br>орчин | Төлбөрийн тэнцэл                   | 1          |
|                                  | Хэрэглээний үнэ                    | 21         |
|                                  | Байгаль орчин                      | 18         |
|                                  | Байгаль орчин - Эдийн засгийн данс | 18         |
|                                  | Гадаад худалдаа                    | 17         |
|                                  | Улсын төсөв                        | 15         |
|                                  | Орон сууцны үнэ                    | 6          |
|                                  | Хөрөнгө оруулалт                   | 12         |
|                                  | Мөнгө, санхүү                      | 22         |
|                                  | Үндэсний тооцоо                    | 30         |
|                                  | Үйлдвэрлэгчийн үнэ                 | 5          |
|                                  | Бүтээмж                            | 3          |
| <b>Бүгд</b>                      |                                    | <b>168</b> |
| <b>Бүлэг VI</b>                  |                                    |            |
| Боловсрол,<br>эрүүл мэнд         | Төрөлт, нас баралт                 | 41         |
|                                  | Өвчлөл                             | 6          |
|                                  | Ерөнхий боловсролын сургууль       | 19         |
|                                  | Боловсролын ерөнхий үзүүлэлт       | 6          |
|                                  | Эрүүл мэндийн даатгал              | 5          |
|                                  | Эрүүл мэндийн үндсэн үзүүлэлт      | 19         |
|                                  | Сургуулийн өмнөх боловсрол         | 10         |
|                                  | Их, дээд сургууль                  | 8          |
|                                  | Мэргэжлийн боловсрол               | 8          |
|                                  | Бүгд                               | 122        |
| <b>Нийт</b>                      |                                    | <b>859</b> |



## Хавсралт 3. ҮСХ-ООС 2025 ОНД ШИНЭЭР ТООЦОЖ ТАРХААЖ БАЙГАА ҮЗҮҮЛЭЛТ

| Д/д | Үзүүлэлтийн нэр   | Хамрах хугацаа | Тархаах түвшин    |
|-----|---|----------------|-------------------|
| 1   | Нэг өрхийн сарын дундаж орлого, бүс, жилээр   | 2007-2024      | Шинэ бүсээр       |
| 2   | Нэг өрхийн сарын дундаж зарлага, бүс, жилээр  | 2007-2024      | Шинэ бүсээр       |
| 3   | Нэг өрхийн сарын дундаж орлогын бүтэц, бүс, жилээр  | 2007-2024      | Шинэ бүсээр       |
| 4   | Нэг өрхийн сарын дундаж зарлагын бүтэц, бүс, жилээр   | 2007-2024      | Шинэ бүсээр       |
| 5   | Тэгш бус байдал, нэг хүнд сард ногдох хэрэглээнд үндэслэн тооцсон, бүс, жилээр  | 2010-2022      | Шинэ бүсээр       |
